



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023. 11. 29 № ЗГ-1/163

танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000234004313



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

᠒᠐᠒3-10-19 № ХТ/᠒361
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт^{1/8} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235022711

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлд:

“ХХХIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.07.25 № 01/5489

танай 2023.07.18 ы № 01/2567-Т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Х.БОЛОРЧУЛУУН ТАНАА**

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

Б. Урваншан
2023.07.18

9761001671




**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023 07 27 № 114055
танай _____-ны № _____-т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
Х.БОЛОРЧУЛУУН ТАНАА**


Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



ХНЯМБААТАР

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

151603658



**УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага**

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 141-д “Бэлчээрийн болон таримал ургамалд хөнөөлт организм тархахаас сэргийлэх, тархалтыг таслан зогсоох, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдааг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Ургамал хамгаалал, ургамлын эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 1.1.5-д “Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус тусгасан.

1.2.Практик шаардлага

Ургамлын эрүүл мэнд, био аюулгүй байдал нь дэлхий дээрх амьдралын үндэс суурь юм.¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас ургамлын эрүүл мэндийг хамгаалахын ач холбогдол, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хүнсний баталгаат байдлыг хангах болон экосистемд гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд өгч, сайн туршлагыг түгээн таниулах зорилгоор 2020 оныг “Ургамлын эрүүл мэндийн олон

¹ Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хуралд Их Британийн Ургамлын эрүүл мэндийн ахлах ажилтан Никола Спенсийн хэлсэн үгнээс, 2022. URL: <https://www.gov.uk/government/news/worlds-first-international-plant-health-conference-to-set-global-agenda-on-biosecurity-and-address-challenges-in-plant-health> (сүүлд үзсэн 2022.12.10).

улсын жил” болгон зарлаж, энэ хүрээнд холбогдох ажлуудыг хийхийг гишүүн орнууддаа уриалсан байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар хүний өдөрт хэрэглэж буй хүнсний 80.0 хувийг ургамлын гаралтай бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд бидний амьсгалж буй хүчилтөрөгчийн 98 хувийг ургамлаас хангадаг нь тогтоогджээ. Түүнчлэн дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа шувууны махны 72%, өндөгний 43%, гахайн махны 55% нь үр тариа, тосны ургамлаар тэжээсэн гахай шувууны эрчимжсэн фермээс гаралтай байгаа бол бэлчээрийн мал аж ахуй 100% байгалийн ургамлаас хамааралтай байна. Тиймээс “ургамлыг хамгаалснаар өөрсдийнхөө эрүүл мэнд, амь насаа хамгаалж байна”¹ гэсэн үг юм.

Байгаль цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагаанууд нь экосистемийг аль хэдийн өөрчлөлтөд оруулан биологийн төрөл зүйлийг багасган, ургамлын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хөнөөлт организмыг оршин тогтноулах шинэ орчинг бий болгож байна. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд олон улсын худалдаа, аялал жуулчлал хурдацтай хөгжихийн хэрээр дэлхийн улс орнуудад ургамлын хортон шавж, хог ургамал, өвчин маш хурдан тархаж, таримал болон байгалийн ургамалд эрсдэл учруулах өндөр магадлалтай болжээ. Энэ нь хүнсний хангамж, аюулгүй байдал болон байгаль орчинд асар их хохирол учруулж болзошгүй бөгөөд улмаар улс орны худалдаа, эдийн засагт нөлөөлдөг.

НҮБ-ын ХХААБ-гаас дэлхий нийт жил бүрийн тариалангийн ургацынхаа 40 хувийг ургамлын өвчин, хортноос болж алддаг гэсэн тооцоог гаргажээ. Цаашид энэ маягаар ургацаа алдаад байвал хүнсний хангамж багасан, тариаланчдын орлого, амжиргаа буурах, экосистемд сөргөөр нөлөөлнө гэдэг нь тодорхой. Тиймээс улс орнууд ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хорио цээр, эрүүл ахуйн хууль тогтоомж, тогтолцоогоо сайжруулах замаар ургамлын өвчин, хортон нутаг дэвсгэртээ орж ирэх, нэвтрэх, тархахаас сэргийлэхэд ихээхэн анхаарч байна.

Монгол Улс Ургамал хамгааллын тухай анхны хуулийг 1996 онд баталсан бөгөөд уг хуулиар ургамал хамгааллын албаны тогтолцоог төв болон аймгийн алба, хилийн салбараас бүрдэхээр тогтоож, чиг үүргийг нь тодорхойлж, ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагчийг томилох болон хэрэгжүүлэх үүргийг нь хуульчилж байжээ. Ургамал хамгааллын тухай хуулийг 2007 онд шинэчлэн найруулсан бөгөөд өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна. Тус хуульд ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг голлон зохицуулсан байх ба ургамал хамгаалах үйл ажиллагаа руу чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна.

¹ Osama El-Lissy, Secretary, International Plant Protection Convention, Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бара хурал, 2022. URL: <https://www.gov.uk/government/news/worlds-first-international-plant-health-conference-to-set-global-agenda-on-biosecurity-and-address-challenges-in-plant-health> (сүүлд үзсэн 2022.12.10)

Дээрх хууль батлагдсанаас нэг жилийн дараа буюу 2008 онд Монгол Улс нь Ургамал хамгааллын олон улсын конвенцид нэгдэн орсон. Энэхүү конвенцийн стратегийн зорилтод "Хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, дэлхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах" гэж заасан. Тиймээс Монгол Улс дээрх конвенцийн гишүүн орны хувьд ургамал хамгааллын салбарын хууль тогтоомжоо тус конвенцийн зарчим, үзэл санаанд нийцүүлэх үүрэгтэй. Энэ олон улсын гэрээний үүргийн хүрээнд хөнөөлт организмыг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд хамруулах, хөнөөлт организмын тандалт судалгаа, эсрдлийн үнэлгээг хийх, хөнөөлт организмгүй болон хөнөөлт организмаар бага нутаг дэвсгэрийг тогтоох өөрийн болон бусад орны нутаг дэвсгэрт ургамлын хөнөөлт организм нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэмийг сайжруулах, улмаар ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний худалдааг дэмжих, эдгээр асуудлыг бүхэлд хариуцаж, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Ургамал хамгааллын үндэсний байгууллагыг байгуулах, зарим чиг үүргээ үндэсний тогтолцооны онцлогоос хамааран бусад байгууллагад хуулиар шилжүүлэх, тэдгээр байгууллага нь үр дүнгээ Ургамал хамгааллын үндэсний байгууллагад тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тавигдаж байна.

Нөгөө талаар байгаль орчин, нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан хөдөө аж ахуйн салбарын хамрах хүрээ тэлж, ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, олон улсын худалдаа нэмэгдсэнтэй уялдан ургамал хамгааллын үйл ажиллагааг боловсронгуй болгоход юуны түрүүнд даган мөрдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Тариалалтын явцад хэрэглэдэг ургамал хамгааллын бэлдмэл нь ургамлын гадаргууд хүрэлцэн, борооны усаар угаагдах, нар салхи г.м. хүчин зүйлийн нөлөөгөөр задардаг. Түүнчлэн ургамлын үндэс рүү шингэх (лав маягийн хэсэг болох эсвэл ургамлын үндэс хэсэгт), ургамал руу шилжих, уурших, фотосинтезийн процессын үр дүнд хими, нянгийн задралд ордог бол зарим нь ургамлын гадаргууд үлддэг. Үүнтэй холбоотойгоор сүүлийн үед жимс, хүнсний ногоон дах пестицидийн үлдэгдэл, тэдгээрийн хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх асуудлыг эрдэмтэн, судлаачдын төдийгүй хэрэглэгчдийн анхаарлыг байнга татсаар байна.

Өнөөдрийн түвшинд ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналт, ургамал хамгааллын зөв дадал, тандалтын тогтолцоо, цаашилбал пестицидийн зөв менежментийг одоо хүртэл бүрдүүлж чадаагүй байна. Пестицидийн бодисыг импортоор орж ирэх явцад хяналт тавьдаг ч тариалан эрхлэх явцад хяналт тавьдаггүй, иргэд бодистой харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, хэрэглэх зааврыг мөрдөн ажилладаггүй, сургалтад бүрэн хамрагдаж чаддаггүй, өөрөөр хэлбэл ургамал хамгааллын цогц аргыг одоо хүртэл нэвтрүүлээгүй байна. Түүнчлэн пестицидийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, жимс жимсгэнэ, төмс, хүнсний

ногоон дах пестицидийн үлдэгдэл хэмжээг зөв тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч чадахгүй байгаа дутагдал одоо ч байсаар байна .

Ийнхүү 2007 онд батлагдсан Ургамал хамгааллын тухай хуулийн олонхи зүйл, заалтууд нийгэм, эдийн засгийн харилцааны хөгжлөөс хоцорч байгаа тул олон улсын сайн туршлага, чиг хандлагад тулгуурлан түүнийг шинэчлэн найруулах шаардлагатай нь дээрх байдлаас тодорхой байна.

Дээрх хууль зүйн үндэслэл болон практик шаардлагад үндэслэн ургамал хамгаалалттай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх зорилгоор Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн нэрийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль болгон өөрчилж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Хуулийн төсөл нь нийтлэг үндэслэл, ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар төрийн байгууллагын чиг үүрэг, ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, ургамлын хөнөөлт организмын судалгаа, ургамлын эрүүл мэндийн талаар авах арга хэмжээ, ургамал хамгаалах арга хэмжээ, бусад зүйл гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцааг дараах байдлаар тусгана:

-Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалалтай холбоотой зарим нэр томъёог Ургамал хамгааллын олон улсын конвенци, түүний холбогдох стандартад нийцүүлэн тайлбарлахаас гадна Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.

-Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар төрийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг тусгана.

-Ургамал хамгааллын олон улсын конвенциор хүлээсэн үүргийн дагуу хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ, хөнөөлт организмын гаралт, тархалтын талаарх мэдээллийг дотоод болон гадаад орон, бүс нутгуудад харилцан солилцох, ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Ургамал хамгааллын үндэсний

байгууллагыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулна.

-Хөнөөлт организмын тархалтын тандан судалгаа, мэдээллийн сан, хөнөөлт организмын тархалтын зураглал, хорио цээртэй хөнөөлт организмгүй болон тархалт багатай бүс нутгийг тодорхойлох асуудлыг зохицуулна.

- Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, ре-экспорт, дамжин өнгөрөх асуудал мөн ургамлын эрүүл мэндийн талаар авах арга хэмжээг тусгана.

-Ургамал хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөө, хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ургамал хамгаалах бэлдмэлийн асуудлыг зохицуулна.

-Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны санхүүжилт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Хуулийн төсөл боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиас ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо болон үндсэн зохицуулалттай холбогдох хэм хэмжээнүүдийг хэвээр авч үлдэх ба Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын конвенцийн зарчим, үзэл санаанд тулгуурлан бусад орны ургамал хамгааллын тухай хуулийг судалж харгалзан үзэх ба НҮБ-аас гаргасан эрх зүйн баримт бичиг, зөвлөмж зэрэгт нийцүүлнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсан дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж мөрдөгдсөнөөр ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаа Монгол Улсын олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээнд нийцэж, ургамлын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдох асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, худалдааг дэмжих орчин сайжирч, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлд эерэгээр нөлөөлнө.

Ургамал хамгаалах нь ургамлын өвчин, хортон, хог ургамал Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирэхээс хамгаалах, тариалангийн үйлдвэрлэл, ургацыг нэмэгдүүлэх, ач холбогдолтой учраас ургамал хамгааллын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлснээр тариалангийн үйлдвэрлэл тогтворжиж, ургамал, түүний гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа нэмэгдэж, тариаланчийн орлого нэмэгдэн тэдгээрийн эдийн засгийн баталгааг хангах эерэг нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй", 16.2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл

Түүнчлэн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнс үйлдвэрлэн хүний хэрэгцээнд нийлүүлснээр хэрэглэгчийн эрүүл мэнд дэмжин хамгаалагдаж, улмаар иргэдийн болон эх орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтай холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ургамал хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагалдуулан боловсруулна.

УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс “Ургамал хамгааллын тухай” хуулийг анх 1996 онд баталсан бөгөөд уг хуулиар ургамал хамгааллын албаны тогтолцоог төв болон аймгийн алба, хилийн салбараас бүрдэхээр тогтоож, чиг үүргийг тодорхойлон, ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагчийг томилох, хэрэгжүүлэх үүргийг хуульчилж, 2007 онд шинэчилэн найруулж, өнөөдрийг хүртэл мөрдөж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг голлон зохицуулсан байх ба ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалахад чиглэсэн зохицуулалт хангалтгүй гэж үзсэн болно.

Ургамал хамгааллын тухай хуулийг шинэчилэн найруулж, мөрдөж эхэлснээс нэг жилийн дараа буюу 2008 онд Монгол Улс Ургамал хамгааллын олон улсын конвенцид нэгдэн орсон. Энэхүү конвенцийн стратегийн зорилтод “Хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, дэлхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” асуудлыг тусгасан байдаг. Тиймээс Монгол Улс гишүүн орны хувьд ургамал хамгааллын салбарын хууль тогтоомжийг тус конвенцийн зарчим, үзэл санаанд нийцүүлэх шаардлага бий болж байна.

Түүнчлэн Ургамал хамгааллын тухай хууль батлагдсанаас хойш 15 жилийн хугацаанд хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил, дутагдлыг арилгах, нөгөө талаар байгаль орчин, нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан хөдөө аж ахуйн салбарын хамрах хүрээг тэлж, ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, олон улсын худалдаа нэмэгдсэнтэй уялдан ургамал хамгааллын үйл ажиллагааг боловсронгуй болгоход нэн тэргүүнд даган мөрдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь чухал байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ургамлын эрүүл мэндийг хамгаалахын ач холбогдол, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хүнсний баталгаат байдлыг хангах болон экосистемд гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд өгч, сайн туршлагыг түгээн таниулах зорилгоор 2020 оныг “Ургамлын эрүүл мэндийн олон улсын жил” болгон зарлаж, энэ хүрээнд холбогдох ажлуудыг хийх хэрэгжүүлэхийг гишүүн орнууддаа уриалсан байдаг.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар хүний өдөрт хэрэглэж буй хүнсний 80 хувийг ургамлын гаралтай хүнс эзэлж байгаа бөгөөд бидний амьсгалж буй хүчилтөрөгчийн 98 хувийг ургамлаас хангадаг нь тогтоогджээ.

Түүнчлэн дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа шувууны махны 72%, өндөгний 43%, гахайн махны 55% нь үр тариа, тосны ургамлаар тэжээсэн гахай шувууны эрчимжсэн фермээс гаралтай байгаа бол бэлчээрийн мал аж ахуй 100% байгалийн ургамлаас хамааралтай байгаа тул ургамлыг хамгаалах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудал яригдах юм.

Байгаль цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа нь экосистемийг өөрчлөлтөд оруулж, биологийн төрөл зүйлийг багасган, ургамлын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хөнөөлт организмыг оршин тогтноулах шинэ орчинг бий болгож байна.

Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд олон улсын худалдаа, аялал жуулчлал хурдацтай хөгжихийн хирээр дэлхийн улс орнуудад ургамлын хортон шавж, хог ургамал, өвчин маш хурдан тархаж, таримал болон байгалийн ургамалд эрсдэл учруулах өндөр магадлалтай болжээ. Энэ нь хүнсний хангамж, аюулгүй байдал болон байгаль орчинд асар их хохирол учруулж болзошгүй бөгөөд улмаар улс орны худалдаа, эдийн засагт нөлөөлдөг байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн дэлхий нийт жил бүрийн тариалангийн ургацын 40 хувийг ургамлын өвчин, хортноос болж алддаг гэсэн тооцоог гаргажээ. Цаашид энэ маягаар ургацаа алдаад байвал хүнсний хангамж багасан, тариаланчдын орлого, амжиргаа буурах, экосистемд сөргөөр нөлөөлнө гэдэг нь тодорхой юм. Тиймээс улс орнууд ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хорио цээр, эрүүл ахуйн хууль тогтоомж, тогтолцоог сайжруулах замаар ургамлын өвчин, хортонг нутаг дэвсгэртээ орж ирэх, нэвтрэх, тархахаас сэргийлэхэд ихээхэн анхаарч байна.

Тариалалтын явцад хэрэглэдэг ургамал хамгааллын бэлдмэл нь ургамлын гадаргууд хүрэлцэн, борооны усаар угаагдах, нар салхины хүчин зүйлийн нөлөөгөөр задардаг. Түүнчлэн ургамлын үндэс рүү шингэх (лав маягийн хэсэг болох эсвэл ургамлын үндэс хэсэгт), ургамал руу шилжих, уурших, фотосинтезийн процессын үр дүнд хими, нянгийн задралд ордог бол зарим нь ургамлын гадаргууд үлддэг.

Үүнтэй холбоотой сүүлийн үед жимс, хүнсний ногоон дахь пестицидийн үлдэгдэл, тэдгээрийн хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх нь эрдэмтэн, судлаачдын төдийгүй хэрэглэгчдийн анхаарлыг байнга татсаар байна.

Монгол Улс өнөөдрийн түвшинд ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналт, ургамал хамгааллын зөв дадал, тандалтын тогтолцоо, цаашилбал пестицидийн зөв менежментийг өнөөдрийг хүртэл бүрдүүлж чадаагүй байна. Пестицидийн бодисыг импортоор орж ирэх явцад хяналт тавьдаг ч тариалан эрхлэх явцад хяналт тавьдаггүй, иргэд бодистой харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, хэрэглэх зааврыг мөрдөн ажилладаггүй, сургалтад бүрэн хамрагдаж чаддаггүй, өөрөөр хэлбэл ургамал хамгааллын цогц аргыг одоо хүртэл нэвтрүүлээгүй байна. Түүнчлэн пестицидийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоон дахь пестицидийн үлдэгдэл хэмжээг зөв тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч чадахгүй байгаа дутагдал одоо ч байсаар байна.

Өнөөдөр Монгол Улсын хувьд ургамал, ургамлын гаралтай хүнсний эрүүл, аюулгүй байдлын асуудал ямар түвшинд байгаа вэ, эрүүл ахуйн шаардлага хир хангагдаж байна вэ?

Энэ асуултад баталгаа, нотолгоотой хариулах хэмжээнд манай улсын хүнсний хяналт, шинжилгээ, судалгааны тогтолцоо хараахан бүрдэж чадаагүй байна. Тиймээс таримал ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй, эрсдэлгүй байдлыг "тариан талбайгаас хэрэглэгчийн ширээ" хүртэлх хүнс үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд хангуулах, эрсдэл үүсч болзошгүй эгзэгтэй шат дамжлага, цэгүүдийг зөв тодорхойлж, тандалт судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал нь өнөөдрийн тулгамдсан зорилт болж байна.

Эрүүл, аюулгүй арга, технологиор тарьж ургуулсан ургамал, ургамлын гаралтай хүнсийг тариалах, ургуулах, хураах, тээвэрлэх, түүхий эд бэлтгэх, боловсруулахад анхаарлаа хандуулж, зайлшгүй шаардлагатай бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн тодорхой ахиц дэвшил гаргавал “Өлсгөлөнг зогсоож, хүнсний аюулгүй байдал бий болгох, шим тэжээлийг сайжруулах, тогтвортой газар тариаланг дэмжих” “Эрүүл амьдралыг баталгаажуулах, бүх насныхны сайн сайхан байдлыг дэмжих” гэсэн Тогтвортой хөгжлийн зорилго хэрэгжихэд хувь нэмэр болох юм.

Дээрх практик хэрэгцээ, шаардлагад үндэслэн ургамал хамгаалалтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчилэх зорилгоор Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааг дэмжих, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилго бүхий хуулийн төсөл нь 4 бүлэг, 28 зүйлээс бүрдэнэ. Хуулийн төсөлд дурдсан Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Ургамал хамгааллын олон улсын конвенциор хүлээсэн үүргийн дагуу Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ажиллахаар зохицуулсан.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус дагалдуулан боловсруулсан байна. Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулан төрийн байгууллага, олон нийтээс санал авах, хуулийн төслийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, зардал тооцооны судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Монгол Улсад Ургамал хамгааллын тухай анхны хуулийг 1996 онд баталсан ба уг хуулиар ургамал хамгааллын албаны тогтолцоог төв болон аймгийн алба, хилийн салбараас бүрдэхээр тогтоож, чиг үүргийг нь тодорхойлж, ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагчийг томилох болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий зохицуулалтыг агуулж байсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2007 онд баталсан бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаа руу чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна.

НҮБ-ын ХХААБ-гаас дэлхий нийт жил бүрийн тариалангийн ургацынхаа 40 хувийг ургамлын өвчин, хортноос болж алддаг гэсэн тооцоо гаргасан. Цаашид энэ маягаар ургацаа алдаад байвал хүнсний хангамж багасан, тариаланчдын орлого, амьжиргаа буурах, экосистемд сөргөөр нөлөөлнө гэдэг нь тодорхой. Тиймээс улс орнууд ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хорио цээр, эрүүл ахуйн хууль тогтоомж, тогтолцоогоо сайжруулах замаар ургамлын өвчин, хортон нутаг дэвсгэртээ орж ирэх, нэвтрэх, тархахаас сэргийлэхэд ихээхэн анхаардаг.

Монгол Улсын хувьд ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналт, ургамал хамгааллын зөв дадал, тандалтын тогтолцоо, цаашилбал пестицидийн зөв менежментийг одоо хүртэл бүрдүүлж чадаагүй. Пестицидийн бодисыг импортоор орж ирэх явцад хяналт тавьдаг ч тариалан эрхлэх явцад хяналт тавьдаггүй, иргэд бодистой харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, хэрэглэх зааврыг мөрдөн ажилладаггүй, сургалтад бүрэн хамрагдаж чаддаггүй, өөрөөр хэлбэл ургамал хамгааллын цогц аргыг одоо хүртэл нэвтрүүлээгүй байна.

Түүнчлэн пестицидийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй, жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоон дах пестицидийн үлдэгдэл хэмжээг зөв тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч чадахгүй дутагдалтай бөгөөд 2007 онд батлагдсан Ургамал хамгааллын тухай хуулийн олонх зүйл, заалтууд нийгэм, эдийн засгийн харилцааны хөгжлөөс хоцрогдсон тул олон улсын сайн туршлага, чиг хандлагад тулгуурлан түүнийг шинэчлэн найруулах шаардлага тулгарсан.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар хүний өдөрт хэрэглэж буй хүнсний 80.0 хувийг ургамлын гаралтай хүнс эзэлж байгаа ба бидний амьсгалж буй хүчилтөрөгчийн 98 хувийг ургамлаас хангадаг нь тогтоогджээ. Түүнчлэн дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа шувууны махны 72%, өндөгний 43%, гахайн махны 55% нь үр тариа, тосны ургамлаар тэжээсэн гахай шувууны эрчимжсэн фермээс гаралтай байгаа бол бэлчээрийн мал аж ахуй 100% байгалийн ургамлаас хамааралтай байна. Тиймээс “ургамлыг хамгаалснаар өөрсдийнхөө эрүүл мэнд, амь насаа хамгаалж байна”¹ гэсэн үг юм.

Мөн 2008 онд Монгол Улс нь Ургамал хамгааллын олон улсын конвенцод нэгдэн орсон. Энэхүү конвенцын стратегийн зорилтод “Хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, дэлхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” ба Монгол Улс гишүүн орны хувьд ургамал хамгааллын салбарын хууль тогтоомжийг тус конвенцын зарчим, үзэл санаанд нийцүүлэх үүрэг хүлээсэн.

Тиймээс нь Ургамал хамгааллын олон улсын конвенцод нийцүүлэн, таримал ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй, эрсдэлгүй байдлыг “тариан талбайгаас хэрэглэгчийн ширээ” хүртэлх хүнс үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд хангуулах, эрсдэл үүсч болзошгүй эгзэгтэй шат дамжлага, цэгүүдийг зөв тодорхойлж, тандалт судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хуулийг төслийг боловсрууллаа.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 4 бүлэг, 28 зүйлтэй байна. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг

Нийтлэг үндэслэл

Хуулийн төслийн нийтлэг үндэслэлд хуулийн зорилт, хэрэглэх хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тайлбар, ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгалаа.

Ургамал хамгааллын олон улсын конвенцын дагуу тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн, ойн болон таримал ургамал, байгалийн ургамлыг бүгдийг нь хамруулан бүх төрлийн ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг тул Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь зөвхөн ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд үйлчлэхээр тусгасан.

¹ Osama El-Lissy, Secretary, International Plant Protection Convention, Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хурал, 2022.

Уг хуулийн төсөл нь байгалийн ургамал, түүний олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, ре-экспорт, дамжин өнгөрөх харилцаанд үйлчлэхгүй байхаар тусгасан тул хуулийн төсөл батлагдсанаар Байгалийн ургамлын тухай болон Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн зохицуулалттай давхцаагүй болно.

Монгол Улс Ургамал хамгаалал. Нэр томьёо, тодорхойлолт, MNS 3471:20038 Ургамлын хорио цээр. Нэр томьёо, тодорхойлолт, MNS 3475:2003 гэсэн ургамал хамгаалал, хорио цээрийн 2 стандарттай боловч эдгээр стандартад хэрэглэж байгаа нэр томьёо, ойлголт нь олон улсын конвенцын нэр томьёотой зөрчилддөг байсан. Тиймээс хуулийн төсөлд ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хөнөөлт организм, хорио цээртэй хөнөөлт организм, гоц хөнөөлт организм, зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм, ургамлын эрүүл мэнд, ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамлын эрүүл ахуйн үзлэг, зохицуулалттай эд, материал, ургамал хамгаалал, эрсдэлийн шинжилгээ, хорио цээртэй хөнөөлт организмгүй газар нутаг, мэргэжлийн байгууллага, ургамал хамгааллын бүтээгдэхүүн гэсэн 15 нэр томьёоны тайлбарыг Ургамал хамгааллын олон улсын конвенцын нэр томьёотой нийцүүлэн тусгасан.

Мөн Ургамал хамгааллын тухай 1996 болон 2007 оны хуулиудад зарчмын зохицуулалтыг агуулаагүй байсан тул Ургамал хамгааллын олон улсын конвенцын суурь зарчмыг баримтлан ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээнд суурилсан байх, хүн, амьтан, хүрээлэн буй орчинд хамгийн бага эрсдэлтэй тэмцэх аргыг хэрэглэж, химийн пестицидийн хэрэглээг бууруулах, мэдээлэл солилцох болон ил тод, ил ялгаварлах байдлыг хангах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны хориг саадыг арилгахад чиглэх гэсэн таван зарчмыг шинээр тусгасан.

Хоёрдугаар бүлэг

Ургамлын хөнөөлт организм

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт хөнөөлт организм, хорио цээртэй хөнөөлт организмыг мэдэгдэх, баталгаажуулах, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ, ургамлын хорио цээр тогтоох, мэдээлэх, хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тавигдах шаардлага, хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх, ургамлын хорио цээрийг сунгах, цуцлах, хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгаа, гоц хөнөөлт организмын бэлэн байдлын төлөвлөгөө, хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг тодорхойлох, зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглал, ургамал хамгаалах цогц арга, ургамал хамгааллын бүтээгдэхүүнтэй холбогдох зохицуулалтыг агуулсан.

Хуулийн төсөлд “хөнөөлт организм” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны эсхүл эмгэг төрүүлэгчийн аливаа зүйл, омог, биологийн төрөл зүйлийг ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд энэхүү хөнөөлт организм гэдэг ойлголтод ургамалд хөнөөл учруулж болох өвчин, шавж, мэрэгч амьтан, хог ургамал зэрэг багтах юм. Хөнөөлт организмыг эдийн засгийн хөнөөлийн босго, түвшнээс нь хамааран хорио цээртэй хөнөөлт организм, зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм гэж ангилж, жагсаалтыг хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар тусгалаа.

Олон улсын ургамал хамгааллын конвенцын IV зүйлийн дагуу гишүүн орны хувьд хэд хэдэн үндсэн үүргийг хүлээдэг бөгөөд үүнд аюулд өртсөн бүс нутгийг хамгаалах, хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээнд нийцсэн техникийн үндэслэл бүхий ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, мэдээлэх, хөнөөлт организм тархаагүй болон бага тархсан газар нутгийг судлан тогтоох, зарлан мэдээлэх, ургамлын хөнөөлт организмын талаар мэдээлэл солилцоход бусад оронтой хамтран ажиллах асуудал туссан. Үүний дагуу хорио цээртэй хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл холбогдох этгээд мэдэгдэхээс эхлээд хэрэгжүүлэх арга хэмжээг шат дарааллаар тусгасан

Үүний дагуу хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед тухайн шатны албан тушаалтан, байгууллага голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоож, цуцлах асуудлыг хуулийн төсөлд шинээр тусгасан болно.

Хөнөөлт организмын төрлөөс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, уг бүсэд гаднаас орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, хэрэгжүүлэх арга хэмжээ, хөнөөлт организмын төрөлд тохируулан ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх нөхцөл байдал болон хорио цээрийг сунгасан, цуцлах зохицуулалтыг мөн тусгасан.

Хуулийн төсөлд хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн, эсхүл хөнөөлт организмын шинж тэмдэг илэрсэн бүх байршилд тандан судалгааг хийхээр тусгасан бөгөөд гоц хөнөөлт организм тус бүрээр бэлэн байдлын төлөвлөгөөг батлах субъект, төлөвлөгөөнд тавигдах шаардлагыг шинээр тусгаж өгсөн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ургамлын эрүүл мэндийг хамгаалахын ач холбогдол, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хүнсний баталгаат байдлыг хангах болон экосистемд гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд өгч, сайн туршлагыг түгээн таниулах зорилгоор 2020 оныг “Ургамлын эрүүл мэндийн олон улсын жил” болгон зарлаж, энэ хүрээнд холбогдох ажлуудыг хийхийг гишүүн орнууддаа уриалсан байдаг. Иймээс дэлхийн ихэнх улс орнууд ургамал хамгаалах үйл ажиллагаанд химийн пестицидийг хэрэглэхээс татгалзаж эхэлсэн.

Энэ зарчмын дагуу Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглалыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, бүс, улсаар гаргаж, хөнөөлт организм гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхийн тулд биологи, физик-механик, ургамлын селекти, агротехнологи, химийн аргуудаас дангаар нь эсхүл хослуулах замаар ургамал хамгаалах цогц аргыг хэрэглэх асуудлыг мөн хуулийн төсөлд тусгасан.

Хөдөө аж ахуйн салбарт ургамал хамгаалал, хөрсний үржил шимийг сайжруулах зориулалтаар ашиглах биологийн гаралтай бодисын талаар мэргэжлийн санал дүгнэлт, гаргах орон тооны бус Салбар зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлын дүгнэлтээр Монгол улсад ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох биобэлдмэлүүдийн жагсаалтыг баталдаг мөн Ургамал хамгааллын зориулалтаар тухайн онд ашиглах пестицид, химийн бордооны жагсаалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар жил бүр батлан хэрэгжилтийг хангадаг. Эдгээр жагсаалтуудаас үзэхэд ургамал хамгаалах үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүтээгдэхүүний хувьд үйлчлэх бодис, идэвхт бодис, энгийн химийн бодис, биологийн гаралтай бэлдмэлд ашигт, үет хөлтөн, шавжыг хүртэл ашиглах тохиолдол байдаг учраас ургамал хамгааллын бүтээгдэхүүн гэж нэрлэх нь зүйтэй байна. Олон улсад мөн "plant protection product" гэдгээрээ нэрлэгдэж явдаг тул үүний дагуу ургамал хамгааллын бүтээгдэхүүн гэсэн зүйлийг хуулийн төсөлд шинээр нэмсэн болно.

Гуравдугаар бүлэг

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаанд оролцогчийн чиг үүрэг

Хуулийн төслийн энэ бүлэгт Засгийн газрын бүрэн эрх, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг тус тусад тусгалаа.

Хуулийн төслийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхгүй, орхигдуулахаас сэргийлж бүрэн эрхийг багцлан тусгаснаас гадна иргэн, хуулийн этгээдэд ашиглаж, эзэмшиж, эсхүл өмчилж байгаа бэлчээр, тариалангийн талбай, хүлэмжид хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт нэн даруй мэдэгдэх үүргийг тусгасан болно. Олон улсын ургамал хамгааллын конвенцын IV зүйлийн дагуу гишүүн орны хувьд хэд хэдэн үндсэн үүргийг хүлээдэг бөгөөд үүнд Ургамал хамгааллын албан ёсны үндэсний байгууллагыг байгуулах асуудал туссан тул хуулийн төсөлд тусгасан ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байхаар зохицуулсан.

2023 оны 1 дүгээр сараас эхлэн мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, салбарын холбогдох төрийн байгууллагуудын харьяанд шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу ургамлын хорио цээрийн байцаагч (нийт 36 албан хаагч)-ийг салбарын бодлогын яаманд шилжүүлсэн учраас цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулахгүйгээр энэ байгууллагын хуулийн төсөлд заасан чиг үүрэг, нэмэлт арга хэмжээнүүдийг эдгээр байцаагчид гүйцэтгэх боломжтой.

Ургамал хамгааллын үйл ажиллагааг сум, дүүрэг бүрт шуурхай хэрэгжүүлэх боломжтой байхаар Засгийн газарт улсын хилийн боомт дээр ургамлын хорио цээрийн лаборатори, байгууламж, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн орон нутагт ургамлын хорио цээрийн лаборатори бүхий байнгын ажиллагаатай хорио цээрийн хяналтын цэг байгуулах эрхтэй байхаар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед харьяалах нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээрийн хяналтын цэг байгуулах эрхтэй байхаар тус тус шинээр тусгасан болно.

Дөрөвдүгээр бүлэг

Бусад зүйл

Олон улсын ургамал хамгааллын конвенцын IV зүйлийн дагуу гишүүн орны хувьд хэд хэдэн үндсэн үүргийг хүлээдэг бөгөөд үүнд аюулд өртсөн бүс нутгийг хамгаалах, хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээнд нийцсэн техникийн үндэслэл бүхий ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, мэдээлэх, хөнөөлт организм тархаагүй болон бага тархсан газар нутгийг судлан тогтоох, зарлан мэдээлэх, ургамлын хөнөөлт организмын талаар мэдээлэл солилцоход бусад оронтой хамтран ажиллах асуудал туссан.

Тиймээс Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын мэдээллийн санг үүсгэх, ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон холбогдох бусад этгээд мэдээлэл оруулах, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлэхээр хуулийн төсөлд шинээр тусгасан болно. Мөн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан болно.

---ooOoo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ..дугаар сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД,
УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааг дэмжих, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад оршино.

2 дугаар зүйл.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль тогтоомж

2.1.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Тариалангийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Ойн тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Байгалийн ургамал, түүний олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.3.Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, ре-экспорт, дамжин өнгөрөх асуудлыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ургамал” гэж амьд ургамал, түүний үр, суулгац, үр хөврөл, бусад эд эрхтэнг;

4.1.2.“ургамлын гаралтай бүтээгдэхүүн” гэж ургамлын боловсруулаагүй түүхий эд болон шинж чанар, боловсруулалтын онцлогоос хамаарч хөнөөлт организм нэвтрэх, тархах эрсдэлийг үүсгэж болзошгүй боловсруулсан бүтээгдэхүүнийг;

4.1.3.“хөнөөлт организм” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны, эсхүл эмгэг төрүүлэгчийн аливаа зүйл, омог, биологийн төрөл зүйлийг;

4.1.4.“хорио цээртэй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт илрээгүй боловч хил дамнан орж ирж аюул учруулж болзошгүй, эсхүл илэрсэн ч өргөн тархаагүй, эрсдэл, нөлөөллийг бууруулах арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол учруулж болзошгүй нь тогтоогдсон хөнөөлт организмыг;

4.1.5.“гоц хөнөөлт организм” гэж эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй болох нь энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр тогтоогдсон хорио цээртэй хөнөөлт организмыг;

4.1.6.“зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт өргөн тархсан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол багатай нь тогтоогдсон хөнөөлт организмыг;

4.1.7.“ургамлын эрүүл мэнд” гэж ургамлын хөнөөлт организмгүй байдлыг;

4.1.8.“ургамлын эрүүл мэндийг хамгаалах” гэж ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийн хор хөнөөлийг бууруулах, хөнөөлт организмгүй байдлыг тогтоох цогц үйл ажиллагааг;

4.1.9.“ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж улсын байцаагчаас ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, бусад зохицуулалттай эд, материалд хөнөөлт организм байгаа эсэх болон эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.10.“зохицуулалттай эд, материал” гэж хөнөөлт организмыг тээх, эсхүл дамжин тархах эрсдэлтэй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалахад ашиглах сав, баглаа боодол, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, хүн, хөрс, өөр бусад организм зэрэг ургамлын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай бүх төрлийн эд материалыг;

4.1.11.“ургамал хамгаалал” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хамгаалах зорилгоор хөнөөлт организмыг илрүүлэх, гаралт, тархалтыг хязгаарлах, тэмцэх үйл ажиллагааг;

4.1.12.“эрсдэлийн шинжилгээ” гэж тухайн илэрсэн организмыг биологийн болон бусад шинжлэх ухааны судалгаа, эдийн засгийн нотолгоонд үндэслэн эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хөнөөлийн түвшин, түүний эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.13.“хорио цээртэй хөнөөлт организмгүй газар нутаг” гэж хөнөөлт организмгүй болохыг тандан судалж тогтоох, хянах, тэмцэх, устгах арга хэмжээ хэрэгжүүлдэг болохыг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон газар нутаг, эсхүл зарим хэсэг нутгийг;

4.1.14.“мэргэжлийн байгууллага” гэж хөнөөлт организм гарсан, тархсан тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх аж ахуйн нэгжийг;

4.1.15.“ургамал хамгааллын бүтээгдэхүүн” гэж хөнөөлт организмтай тэмцэхэд хэрэглэх химийн болон биологийн гаралтай бүтээгдэхүүнийг.

5 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх;

5.1.2. хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээнд суурилсан байх;

5.1.3. хүн, амьтан, хүрээлэн буй орчинд хамгийн бага эрсдэлтэй тэмцэх аргыг хэрэглэж, химийн пестицидийн хэрэглээг бууруулах;

5.1.4. мэдээлэл солилцох болон ил тод, ил ялгаварлах байдлыг хангах;

5.1.5. ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны хориг саадыг арилгахад чиглэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫН ХӨНӨӨЛТ ОРГАНИЗМ

6 дугаар зүйл. Хөнөөлт организм

6.1. Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан тандан судалгаа хийсний үндсэн дээр хөнөөлт организмыг дор дурдсанаар ангилж, тэдгээрийн жагсаалтыг батална:

6.1.1. хорио цээртэй хөнөөлт организмын жагсаалт;

6.1.2. зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалт.

6.2.Хорио цээртэй хөнөөлт организмын жагсаалтад тухайн хөнөөлт организм нь гоц хөнөөлтэй эсэхийг тэмдэглэнэ.

6.3.Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор, сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, нутаг дэвсгэрийн дотор нүүлгэн шилжүүлэх, хадгалах, үржүүлэх, тараахыг хориглоно.

6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтой тэмцэх арга хэмжээний зааврыг эдийн засгийн хөнөөлийн босго, түвшингийн хамт хөнөөлт организмын зүйл тус бүрээр холбогдох эрдэм шинжилгээний байгууллага батлан мэдээллийн санд байршуулна.

7 дугаар зүйл.Хорио цээртэй хөнөөлт организмыг мэдэгдэх, баталгаажуулах

7.1.Хорио цээртэй хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл холбогдох этгээд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

7.2.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсны дараа хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн эд зүйл, нутаг дэвсгэрээс дээж авч, лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн албан ёсоор баталгаажуулна.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан баталгаажуулах үйл явцтай зэрэгцэн хорио цээртэй хөнөөлт организм тархах эрсдэлийг арилгах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан этгээд ургамлын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авна.

7.4.Хорио цээртэй хөнөөлт организм албан ёсоор баталгаажсан тохиолдолд нийтэд болон олон улсын холбогдох байгууллагад мэдээлнэ.

8 дугаар зүйл.Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ

8.1.Илэрсэн хорио цээртэй хөнөөлт организм тархахаас сэргийлэх зорилгоор энэ хуулийн 6.4-т заасан зааврын дагуу дор дурдсан этгээд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн хяналтан дор шуурхай хариу арга хэмжээг авна:

8.1.1.тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, зоорь, агуулахад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч;

8.1.2.бэлчээр, хадлангийн болон ойн сан бүхий газар, ногоон байгууламжид тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга.

8.2.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага илэрсэн хорио цээртэй хөнөөлт организм тархахаас сэргийлэх арга хэмжээний мэдээллийг энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд оруулна.

8.3.Хорио цээртэй хөнөөлт организмтой болох нь тогтоогдсон бол ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон бусад зохицуулалттай эд зүйлийг зах зээлээс холбогдох этгээд нэн даруй татах, холбогдох арга хэмжээг авах үүрэгтэй.

9 дүгээр зүйл.Ургамлын хорио цээр тогтоох, мэдээлэх

9.1.Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед доор дурдсан албан тушаалтан, байгууллага голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоож, цуцална:

9.1.1.хорио цээртэй хөнөөлт организмын тархалт нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл хөнөөлт организмын голомтыг нэгтгэх нөхцөл үүсээгүй бол тухайн орон нутаг дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга;

9.1.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан бол тухайн орон нутаг дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга;

9.1.3.хөнөөлт организмын тархалт төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол хяналт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын салбарын улсын ерөнхий байцаагчийн дүгнэлт, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.

9.2.Хорио цээр тогтоох үйл ажиллагаанд энэ хуулийн 20.1.4-т заасан журмыг мөрдөнө.

9.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, тэдгээртэй холбогдон гарах зардлыг баталж, биелэлтэд хяналт тавина.

9.4.Холбогдох шатны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт хорио цээр тогтоосон тухай шийдвэрээ ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нийтэд зарлан мэдээлнэ.

9.5.Засгийн газрын шийдвэрээр хорио цээр тогтоосон бол ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийтэд зарлан мэдээлнэ.

10 дугаар зүйл.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тавигдах шаардлага

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрлөөс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, уг бүсэд гаднаас орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг тавьж, харуул хамгаалалт ажиллуулна.

10.2.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах хяналтын цэг дээр ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах ажлыг сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан цэгт хяналтын байгууллагын хяналтан дор мэргэжлийн байгууллага ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийнэ.

11 дүгээр зүйл.Хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

11.1.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тухайн шатны Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулна:

11.1.1.хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах;

11.1.2.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид ариутгал, халдваргүйжүүлэлт хийх;

11.2.Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах зардлыг энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан тухайн шатны Засаг дарга, 9.1.3-д зааснаар хорио цээр тогтоох тохиолдолд Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх

12.1.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа мэргэжлийн байгууллага нь хөнөөлт организмын төрөлд тохируулан энэ хуулийн 6.5-т заасан зааврын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийнэ.

12.2.Ариутгал, халдваргүйжүүлэлт, хөнөөлт организмын голомтыг устгах үйл ажиллагааг голомт бүхий талбай, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, агуулах, зоорь, хүлэмж, ил талбай, үтрэм, бусад зориулалтын хэрэгсэл, голомтод орсон хүний хувцас, хэрэгсэл, бусад эд зүйлсэд хийнэ.

13 дугаар зүйл.Ургамлын хорио цээрийг сунгах, цуцлах

13.1.Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан холбогдох хяналтын байгууллага, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хорио

цээрийн хугацааг сунгах, эсхүл цуцлах тухай дүгнэлт, саналыг хорио цээр тогтоосон байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

13.2.Хорио цээрийг сунгасан, цуцалсан бол энэ хуулийн 20.1.4-т заасан журмын дагуу ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нийтэд зарлан мэдээлнэ.

14 дүгээр зүйл.Хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгаа

14.1.Хорио цээртэй хөнөөлт организмын илрэх цаг хугацаанд эрсдэлийн шинжилгээнд суурилан тандан судалгааг хийнэ.

14.2.Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн, эсхүл хөнөөлт организмын шинж тэмдэг илэрсэн бүх байршилд тандан судалгааг хийнэ.

14.3.Байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан холбогдох эзэн төрөл зүйл байхгүй нь нотлогдсон байршилд тандан судалгааг хийх шаардлагагүй.

Тайлбар: "эзэн төрөл зүйл" гэж тухайн хөнөөлт организмд өртдөг ургамлын төрөл, зүйлийг ойлгоно.

14.4.Хөнөөлт организмын тандан судалгаанд шинжлэх ухаан болон технологийн нотлох баримт, бусад шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг ашиглана.

14.5.Энэ хуулийн 14.2-т заасан байршилд тандан судалгааг 5-7 жилийн хугацаанд үргэлжлүүлэн хийнэ.

14.6.Тандан судалгааны өмнөх оны судалгааны тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээллийн сангаар дамжуулан тайлагнана.

14.7.Тандан судалгаа хийх аргачлал, эрсдэлийн шинжилгээ хийх зааврыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15 дугаар зүйл.Гоц хөнөөлт организмын бэлэн байдлын төлөвлөгөө

15.1.Энэ хуулийн 6.2-т заасан гоц хөнөөлт организм тус бүрээр бэлэн байдлын төлөвлөгөөг хөдөө аж ахуйн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

15.2.Бэлэн байдлын төлөвлөгөөг гоц хөнөөлт организмын сэжигтэй тохиолдол илэрсэн, албан ёсоор баталгаажсан тохиолдолд ашиглана.

15.3.Бэлэн байдлын төлөвлөгөө дор дурдсан агуулгатай байна:

15.3.1. удирдлага, зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зарлан мэдээлэх;

15.3.2. илэрсэн гоц хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтын хүрээг тогтоох, үнэлэх, хязгаарлах, устгах;

15.3.3. хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөний хяналт, хорио цээр, хязгаарлалтын дэглэм;

15.3.4. газар дээрх ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх, дээж авах, лабораторийн шинжилгээ хийх арга зүй;

15.3.5. цаашид шаардлагатай хамгийн бага нөөцийг тодорхойлох;

15.3.6. устгал, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт;

15.3.7. нийтэд зориулсан мэдээлэл, сургалт.

15.4. Биологи болон эзэн төрөл зүйл нь төстэй хэд хэдэн гоц хөнөөлт организмын бэлэн байдлын төлөвлөгөөг нэгтгэж гаргаж болно. Энэ тохиолдолд бэлэн байдлын төлөвлөгөө нь тэдгээр хөнөөлт организмын нийтлэг шинжид зориулсан болон тухайн хөнөөлт организмын онцлог шинжид тохирсон тусгайлсан хэсэгтэй байна.

15.5. Энэ хуулийн 6.1.1-т заасан жагсаалтад шинээр гоц хөнөөлт организм нэмэгдсэн тохиолдолд жагсаалтад орсноос хойш 1 жилийн дотор түүнтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг гаргана.

15.6. Бэлэн байдлын төлөвлөгөөг батлагдсан тухай бүр холбогдох байгууллагад мэдээлнэ.

15.7. Гоц хөнөөлт организмтой тэмцэх нарийвчилсан төлөвлөгөөг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан холбогдох этгээдэд хүргүүлнэ.

15.8. Нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

15.9. Нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

16 дугаар зүйл. Хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг тодорхойлох

16.1. Тандан судалгааны дүнг үндэслэн хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг аймаг, нийслэлийн хэмжээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэг, аж ахуйн нэгжийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус тогтоож, цуцална.

16.2.Хорио цээртэй хөнөөлт организм илрээгүй газар нутагт тавигдах шаардлага, газар нутгийг тогтоох, цуцлах журмыг Олон улсын ургамал хамгааллын конвенцийн холбогдох стандартад нийцүүлэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17 дугаар зүйл.Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглал

17.1.Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглалыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, бүс, улсаар ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргана.

17.2.Тархалтын зураглалыг үндэслэн зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагтаа төлөвлөж хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл.Ургамал хамгаалах цогц арга

18.1.Хөнөөлт организм гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхийн тулд биологи, физик-механик, ургамлын селекци, агротехнологи, химийн аргуудаас дангаар нь, эсхүл хослуулах замаар ургамал хамгаалах цогц аргыг хэрэглэнэ.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан ургамал хамгаалах цогц аргыг хэрэгжүүлэх зөвлөмжийг эрдэм шинжилгээний байгууллага гаргана.

18.3.Хөнөөлт организм гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхдээ ургамал хамгаалах цогц аргыг дор дурдсан байгууллага хариуцан зохион байгуулна:

18.3.1.тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, зоорь, агуулахад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч;

18.3.2.бэлчээр, ногоон байгууламжид тухайн шатны Засаг дарга;

18.3.3.ойд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

19 дүгээр зүйл.Ургамал хамгааллын бүтээгдэхүүн

19.1.Хөнөөлт организмтай тэмцэхэд Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрсөн пестицид ашиглаж болно.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан пестицидийг ашиглан ургамлын хөнөөлт организмтой тэмцэх тохиолдолд тухайн пестицидийн нэр, төрөл, хэмжээ, хор аюулын лавлах мэдээлэл, ашиглах зориулалтын талаар үйлдвэрлэгч, эсхүл албан ёсны

борлуулагчаас дагалдуулсан, эсхүл эрдэм шинжилгээний байгууллагаас баталсан технологийн зааврыг зөрчихийг хориглоно.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан пестицидийг ашиглан ургамлын хөнөөлт организмтай тэмцсэн талбайд тухайн пестицидийн задралын хугацаа дуусаагүй байхад аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

19.4.Тариалангийн талбай, хүлэмж, зоорь, агуулах, бэлчээр, ойд хөнөөлт организмтай тэмцэхдээ химийн болон цацрагийн аргыг сонгосон тохиолдолд пестицидтэй ажиллах талаарх сургалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

19.5.Энэ хуулийн 19.4-т заасан сургалтыг салбарын төрийн бус байгууллага зохион байгуулж болно.

19.6.Пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, худалдах, устгах болон сав баглаа боодлыг эгүүлэн татах, устгахтай холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

19.7.Биологийн гаралтай бэлдмэл, ашигт организмыг турших, бүртгэх, ашиглах, импортлох, худалдаалахтай холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.8.Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

19.9.Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан нэмэлт баримт бичгийг тусгай зөвшөөрлийн цахим системд илгээнэ:

19.9.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

19.9.2.эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой тусгасан өргөдөл;

19.9.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 17.1-т заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлт;

19.9.4.ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг худалдаалах байр, хадгалах агуулахад хийсэн байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт;

19.9.5.энэ хуулийн 19.7.4-т заасан тайлангийн дүгнэлтээр нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дүгнэлт;

19.9.6.химийн бодисын сав, баглаа, боодлыг устгах, дахин боловсруулах үйлдвэртэй байгуулсан гэрээ.

19.10.Энэ хуулийн 19.9-д заасан худалдаалах үйл ажиллагаанд цахим болон биет худалдаа хамаарна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН ЧИГ ҮҮРЭГ

20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

20.1.Засгийн газар ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зохицуулалттай эд, материалыг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг тогтоох;

20.1.2.улсын хилийн боомт дээр ургамлын хорио цээрийн лаборатори, байгууламж, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн орон нутагт ургамлын хорио цээрийн лаборатори бүхий байнгын ажиллагаатай хорио цээрийн хяналтын цэг байгуулах;

20.1.3.энэ хуульд заасны дагуу ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;

20.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах;

20.1.5.гадаад орон, олон улсын холбогдох байгууллагатай ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;

20.1.6.хуульд заасан бусад.

21 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

21.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.Засгийн газрын эрх олгосноор гадаад улс, олон улсын байгууллагатай ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;

21.1.2.ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

21.1.3.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаарх хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулах;

21.1.4.салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах.

22 дугаар зүйл.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

22.1.Ургамал хамгааллын олон улсын конвенциор хүлээсэн үүргийн дагуу хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллана.

22.2.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.2.1.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангах;

22.2.2.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалалтай холбоотой олон улсыг хамарсан цахим системд нэгдэх, харилцан мэдээлэл солилцох;

22.2.3.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран зохион байгуулах;

22.2.4.ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, дүгнэлт гаргах;

22.2.5.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, урьдчилан сэргийлэх болон тэмцэх арга хэмжээний талаар холбогдох этгээдэд мэдээлэх;

24.2.6.Тариалангийн тухай хуулийн 23.3-т заасан мэдээллийн санд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын дэд санг бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангах;

22.2.7.ургамлын хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгааг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэх;

22.2.8.хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг тогтоох;

22.2.9.экспортлох ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зохицуулалттай бусад эд, материалд ургамлын хорио цээрийн гэрчилгээг импортлогч орны шаардлагад нийцүүлэн олгох;

22.2.10.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 26.4-т заасан мэргэжлийн багийн дүгнэлтийг үндэслэн зохицуулалттай эд, материалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулахаас өмнө импортын мэдэгдэл олгох;

22.2.11.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаанд оролцогчдыг бүртгэх;

22.2.12.хуульд заасан бусад.

22.3.Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, түүнийг бүртгэхтэй холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

23.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсний дагуу нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, тэдгээртэй холбогдон гарах зардлыг батлах, биелэлтэд хяналт тавих;

23.1.2.ургамлын хөнөөлт организмын тархалт, олшролтын төлөв байдал, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх;

23.1.3.хуульд заасан бусад.

24 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

24.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед харьяалах нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээрийн хяналтын цэг байгуулах;

24.1.2.хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн ургамал, хамгааллын талаар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

24.1.3.ургамлын хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд энэ хуульд өөрөөр заагаагүй бол хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;

24.1.4.хуульд заасан бусад.

25 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

25.1.Иргэн, хуулийн этгээд нь ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

25.1.1.ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагаас ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалахтай холбогдсон мэдээлэл, зөвлөгөө авах, хэрэгжүүлэх;

25.1.2.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт, арга хэмжээний талаар тайлбар шаардах, гомдол гаргах;

25.1.3.ашиглаж, эзэмшиж, эсхүл өмчилж байгаа бэлчээр, тариалангийн талбай, хүлэмжид хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт нэн даруй мэдэгдэх;

25.1.4.ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хураах, савлах, тээвэрлэх, хадгалах, худалдах тохиолдолд Тариалангийн тухай хуулийн 23.3-т заасан мэдээллийн сангаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

26 дугаар зүйл.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын мэдээллийн сан

26.1.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/ бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

26.2.Мэдээллийн санд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон холбогдох бусад этгээд мэдээлэл оруулах, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлсэн байна.

26.3.Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.4.Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь нийтэд нээлттэй байна.

27 дугаар зүйл.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны санхүүжилт

27.1.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлнэ.

27.2.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

27.2.1.хорио цээртэй болон гоц хөнөөлт организмын тандан судалгаа хийх зардал;

27.2.2.бэлчээрийн хөнөөлт организмтой тэмцэх ургамал хамгааллын бүтээгдэхүүний зардал;

27.2.3.хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед түүнтэй тэмцэх арга хэмжээний зардал;

27.2.4.Энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санг байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг хангах зардал.

27.3.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны дараахь зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

27.3.1.бэлчээрийн ургамалд ургамлын хөнөөлт организм тархаж, хөнөөл учруулах үед түүнтэй тэмцэх арга хэмжээний зардал;

27.3.2.энэ хуулийн 10.2-т заасан хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагааны зардал;

27.3.3.зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалтад орсон хөнөөлт организмын гаралт, тархалт нь эдийн засгийн хөнөөлийн босгоос давсан үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр голомтыг устгах, хяналтад авах арга хэмжээний зардал.

27.4.Тариалангийн талбай болон хүлэмжинд ургамлын хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд хариуцна.

27.5.Ургамлын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг хөдөө аж ахуйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Ургамал хамгааллын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 17.1.4 дэх заалт нэмсүгэй:

“17.1.4.ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө батлах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “турших” гэсний дараа “бүртгэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмсүгэй:

“9. Ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж” гэснийг “хөнөөлт организм” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас” гэснийг “хөнөөлт организмаас” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын "өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал" гэснийг "хөнөөлт организм" гэж, 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын "арга хэмжээг" гэснийг "аргыг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.24 дэх заалт нэмсүгэй:

“20.1.24.ургамлын зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмтой тэмцэх арга хэмжээ.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.14 дэх заалтын “мал эмнэлгийн үйлчилгээ” гэсний дараа “ургамлын хорио цээртэй хөнөөлт организмтой тэмцэх арга хэмжээ” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

“6.Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор, сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, нутаг дэвсгэрийн дотор нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн, тараасан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.8 дахь зүйлийн гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэсний өмнө “Ургамлын эрүүл мэнд,” гэж, 3 дахь хэсгийн 3.5 дахь заалтын “хэрэглэх” гэсний дараа “заавар,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай” гэснийг “хөнөөлт организмтой” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн, эсхүл бусад үйл ажиллагаа явуулж ургамал, хорио цээрийн дэглэм” гэснийг “Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “бодисыг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, мөн хэсгийн 3.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдаалах” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчил шалгах шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь хэсгийн “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “5.11 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 6.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10 дахь хэсэг, 7.8,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар: ...

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг буюу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрлийн жагсаалтын хүснэгтийн 12.6-д “ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах” гэснийг “ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах” гэж, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд хэсгийн “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хорио цээртэй хөнөөлт организм” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт "26.Ургамал хамгааллын газар" гэж нэмсүгэй.

2."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн "26, 27, 28, 29" гэсэн дугаарыг "27, 28, 29, 30" гэж өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

Монгол Улсын ургамал хамгааллын тухай /2007 он/

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1.үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 1.2.үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 1.3.шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 1.4.харьцуулах хэлбэрийг сонгох;
- 1.5.шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 1.6.мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

- "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
- "Практикт нийцэж байгаа байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

УДИРТГАЛ

Ургамлын эрүүл мэнд, био аюулгүй байдал нь дэлхий дээрх амьдралын үндэс суурь юм.¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ургамлын эрүүл мэндийг хамгаалахын ач холбогдол, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хүнсний баталгаат байдлыг хангах болон экосистемд гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд өгч, сайн туршлагыг түгээн таниулах зорилгоор 2020 оныг “Ургамлын эрүүл мэндийн олон улсын жил” болгон зарлаж, энэ хүрээнд холбогдох ажлуудыг хийхийг гишүүн орнууддаа уриалсан байдаг. Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар хүний өдөрт хэрэглэж буй хүнсний 80.0 хувийг ургамлын гаралтай хүнс эзэлж байгаа ба бидний амьсгалж буй хүчилтөрөгчийн 98 хувийг ургамлаас хангадаг нь тогтоогджээ. Эндээс харахад хүн өдөрт хүнснээс авах илчлэгийнхээ 40 хувийг ургамал болон түүний гаралтай бүтээгдэхүүнээс авдаг байна. Түүнчлэн дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа шувууны махны 72%, өндөгний 43%, гахайн махны 55% нь үр тариа, тосны ургамлаар тэжээсэн гахай шувууны эрчимжсэн фермээс гаралтай байгаа бол бэлчээрийн мал аж ахуй 100% байгалийн ургамлаас хамааралтай байна. Тиймээс “ургамлыг хамгаалснаар өөрсдийнхөө эрүүл мэнд, амь насаа хамгаалж байна”² гэсэн үг.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлээрх 74 гаруй орны тэргүүлэгч байгууллагууд Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хуралд³ оролцож өнөөгийн тулгамдсан асуудал, ирээдүйн чиг хандлагын талаар хэлэлцсэн ба энэ үеэр “Уур амьсгалын өөрчлөлтийн үед ургамлын эрүүл мэнд, өсөж үржих нөхцөлийг тасралтгүй хангах нь хүнсний аюулгүй байдал, олон улсын аюулгүй худалдаа, хойч үедээ цэцэглэн хөгжиж буй байгаль орчныг үлдээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ” гэж Их Британийн Ургамлын эрүүл мэндийн ахлах ажилтан Никола Спенс хэлсэн байдаг.

Онцолж хэлбэл, хүн төрөлхтний өдөр тутам хэрэглэж буй хоол хүнс болон бидний эрүүл мэнд тариалан, ургамлаас хэр их хамааралтай нь тодорхой байгаа юм.

Иймд ургамлыг хамгаалахын тулд дараах зөвлөмжийг НҮБ-аас гаргажээ. Үүнд:

- Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ялангуяа улс хооронд тээвэрлэх явцад ургамлын хөнөөлт организм болох хог ургамал, өвчин, хортон шавж тархах эрсдэлтэй тул бүрэн хяналтад оруулах, иргэд хувиараа болон интернет, шуудан илгээмжээр ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг захиалж авахаас аль болох татгалзах;
- Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний стандартад нийцүүлсэн эрсдэлгүй байдлаар худалдаалах;
- Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалахын тулд ургамлыг эрүүл байлгах;
- Эрүүл байлгахын тулд эх газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх;
- Улс орон тогтвортой бодлоготой байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, төр хувийн хэвшил хамтрах.

Ургамал, байгаль орчинг ургамлын хөнөөлт организмын сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдуулан улс орнуудын гол үүрэг, хариуцлагуудыг ДХБ-ын Амьтан, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээр (АУЭАХ, 1995), Биологийн олон янз байдлын

¹ Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хуралд Их Британийн Ургамлын эрүүл мэндийн ахлах ажилтан Никола Спенсийн хэлсэн үгнээс, 2022

² Osama El-Lissy, Secretary, International Plant Protection Convention, Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хурал, 2022.

³ НҮБ-ын ХХААБ, Олон улсын Ургамал Хамгааллын Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар (IPPC) болон Их Британийн Байгаль орчин, хүнс, хөдөөгийн асуудлын яам (DEFRA)-наас хамтран 2022.09.21-23-ны өдөр зохион байгуулсан.

конвенци болон Ургамал хамгааллын олон улсын конвенциор тодорхойлсон байдаг. Монгол Улс ч дэлхийн дийлэнх орнуудын адил эдгээр олон улсын хэлэлцээр, конвенцийн гишүүн орон билээ. Тухайлбал, Биологийн олон янз байдлын конвенцийн (БОЯБК) гишүүн орны хувьд Монгол Улс нь түрэмгийлэгч харийн зүйлтэй холбогдуулан тодорхой үүрэг хүлээнэ. БОЯБК-ийн 8(н)-р зүйлд зааснаар, “экосистем, амьдрах орчин, төрөл зүйлд хөнөөлтэй түрэмгийлэгч харийн зүйл нэвтрэх, тархахаас сэргийлэх, тэмцэх, устгах” арга хэмжээг гэрээнд оролцогч бүх тал авах үүрэгтэй. Дийлэнхи түрэмгийлэгч зүйл нь ургамлын хортон, хог ургамлын ангилалд хамаарах ба ургамалын эрүүл ахуй, эрүүл мэндийн талаар үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тэдгээртэй тэмцэх засгийн газрын үүрэг хариуцлагыг чангатгахад БОЯБК-ийн зорилго оршино.⁴

АУЭАХ-ийн зорилго нь ургамал хамгааллы арга хэмжээг олон улсын худалдаанд саад болох зорилгоор хэрэглэхээс сэргийлэхэд оршино. Үндэсний хэмжээнд ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг (УЭААХ) зөвхөн ургамал, түүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлэх, уг арга хэмжээ нь зөвхөн эрсдлийн үнэлгээ нь хийгдсэн, шинжлэх ухааны хангалттай нотолгоонд суурилагдсан байх ёстойг тус хэлэлцээрт заасан. Холбогдох эрсдлүүдийг үнэлэхэд ямар хүчин зүйлсийг харгалзах ёстойг (техникийн үндэслэлтэй байх зарчим) мөн хэлэлцээрт туссан. УЭААХ-г ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний импортод тавигдах шаардлагын үүргээр ашиглахдаа, ургамлын эрүүл ахуйн ижил статустай улс орнуудыг хувийн үзэмж, үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхахгүй (үл ялгаварлан гадуурхах зарчим) байхыг ДХБ-ын гишүүн орнуудад анхааруулдаг.

Монгол Улсын Их хурлаас Ургамал хамгааллын үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, ургамлын хорио цээр тогтоох, ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих хяналтын асуудлыг зохицуулж буй Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан байдаг. Уг хуулийн зорилтыг “бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино”⁴ хэмээн тодорхойлсон. Ийнхүү батлагдсанаасаа хойш өнөөдрийг хүртэл 2010, 2011, 2015 онуудад зарим нэг нэмэлт, өөрчлөлтүүд орж байсан.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлаас Ургамал хамгааллын тухай хууль батлагдсаны нэг жилийн дараа буюу 2008 онд Олон улсын ургамал хамгааллын конвенц (ОУУХК)-ийг соёрхон баталж, тус конвенцийн гишүүн орон болсон. Ургамал хамгааллын олон улсын конвенцийн үндсэн чиглэл нь олон улсын худалдаанд шилжиж буй бүх төрлийн байгалийн, ойн болон таримал ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон ургамлын хөнөөлт организм тархаж болзошгүй бүх хэсэг тухайлбал сав, баглаа боодлын материал, хөрс, тээврийн хэрэгсэл, хөлөг онгоц, машин механизм гэх зэргээр дамжин улс орнуудын нутаг дэвсгэрт ургамлын хөнөөлт организм нэвтрэх, тархахаас сэргийлэх, хамгаалах, олон улсын худалдааг дэмжихтэй холбогдсон асуудлыг авч үздэг.

ОУУХК –ийг 1997 онд шинэчлэн найруулсан ба уг конвенцийн IV зүйлийн дагуу гишүүн орны хувьд дараахь үндсэн үүргийг хүлээсэн. Үүнд:

- Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээр дамжин тухайн орны нутаг дэвсгэрт хөнөөлт организм нэвтрэх, тархах, түүнээс урьдчилан сэргийлэх, хянах талаархи эрх зүйн орчныг бүрдүүлэх, техникийн болон захиргааны арга хэмжээ авах;
- Ургамал хамгааллын албан ёсны үндэсний байгууллагыг байгуулах;

⁴ Ургамал хамгааллын тухай хуулийн 1 дүгээр зүйл (2007)

- Хөнөөлт организмын тандалт судалгаа, эрсдлийн үнэлгээ хийх, түүнд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон бусад зохицуулалттай эд зүйлийг Монгол Улсад нэвтрүүлэх, эсхүл гадаад оронд тохиолдолд хяналт шалгалт хийх, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох;
- Хөнөөлт организм илэрсэн бол ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон бусад зохицуулалттай эд зүйлийг халдваргүйжүүлэх болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Аюулд өртсөн бүс нутгийг хамгаалах, хөнөөлт организмын эрсдлийн шинжилгээнд нийцсэн техникийн үндэслэл бүхий ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, мэдээлэх;
- Хөнөөлт организм тархаагүй болон бага тархсан газар нутгийг судлан тогтоох, зарлан мэдээлэх;
- Ургамлын хөнөөлт организмын талаар мэдээлэл солилцоход бусад оронтой хамтран ажиллах;
- Ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, тэдгээрийг сургах, хөгжүүлэх.

1951 онд анх батлагдсан УХОУК-ийг 1979, 1997 онд 2 удаа шинэчлэн найруулсан. 1997 оны хувилбар (“шинэчилсэн найруулга”) 2005 оны 10 сард хүчин төгөлдөр болсон. УХОУК нь олон талт хамтын ажиллагааны гэрээ бөгөөд “ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хөнөөлт организм нэвтрэх, тархахаас сэргийлэх нэгдмэл, үр дүнтэй үйл ажиллагааг бий болгох, хөнөөлт организмтой тэмцэх зохистой арга хэмжээг дэлгэрүүлэх” зорилготой. Дээр тэмдэглэсэнчлэн, УХОУК-ийг, УЭА-н олон улсын стандартыг тогтоох, худалдааг дэмжих зорилгоор улс орнуудын УЭААХ-г уялдуулах үүрэг хүлээсэн байгууллага гэж АУЭАХ-т тодорхойлсон ба, уг хэлэлцээрээр хүлээн зөвшөөрсөн УХОУК-ийн үүргийг шинэчилсэн найруулганд тусгасан. Мөн 1995 оны АУЭАХ-т нэгдэж, УХОУК-н хүрээнд боловсруулагдсан стандартуудыг заавал хэрэгжүүлэх үүргийг ДХБ-ын гишүүн орнууд хүлээсэн.

“Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан байдаг.⁵ Ургамал хамгааллын тухай хуулийг УХОУК-д нийцүүлэх талаарх эрх зүйн шинэчлэл хийгдээгүй өдий хүрчээ.

Тиймээс Монгол Улсын өнөөгийн ургамал хамгаалалтыг зохицуулж буй хууль эрх зүйн орчныг судалж, олон улсын худалдааны гэрээ, тухайлбал ОУУХК -ийн шаардлагад нийцүүлэх үүднээс ургамлын эрүүл ахуйн зохицуулалтыг бэхжүүлэх зайлшгүй шаардлага байна. Иймээс, Монгол Улсын олон улсын гэрээ түүний дотор УХОУК-ийн гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа болон ургамлын эрүүл ахуйг хамгааллын арга хэмжээ хэр үр дүнтэй байгаа хүрээнд “Ургамал хамгааллын тухай (2007) хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв. Энэхүү үнэлгээний зорилго нь уг хууль хэрэгжсэнээр УХОУК-иор хүлээсэн үүргийн биелэлт, улс орны нутаг дэвсгэрт хөнөөлт организм нэвтрэх, тархах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт, худалдааны хориг саадыг багасгахад чиглэсэн мэдэгдэхүйц ахиц дэвшлийг бататгахын зэрэгцээ уг хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар зөвлөмж боловсруулахад оршино.

⁵ Монгол Улсын Үндсэн хууль 10.2 болон 10.3 зүйл. (1992)

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Ургамал хамгааллын тухай 2007 оны хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд

1. үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. шалгуур үзүүлэлтийг томъёолох;
5. мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын хувьд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын салбарт дараахь хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байна:

- Ургамал хамгааллын тухай хууль 2007;
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль 2002.

Мөн эдгээр хуулиудыг дагалдан гарсан холбогдох дүрэм, журам, заавар, жагсаалтуудыг эрх бүхий этгээдээр батлуулан төрийн захиргааны холбогдох шатны байгууллага, албан тушаалтнууд, хуулийн этгээд, иргэд хэрэгжүүлэн ажиллаж байна. Ийнхүү төрөөс эрх зүйн орчныг бүрдүүлсэн болон хэрэгжүүлсэн олон арга хэмжээний үр дүнд Монгол Улсын ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын салбарт мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан байна.

Гэсэн хэдий ч Монгол Улс 1997 оноос ДХБ-ын гишүүн болсон улмар ДХБ-ын Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээрт нэгдэж, 2008 онд УХОУК-ийг соёрхон баталсан ба Ургамал хамгааллын тухай хууль нь уг конвенцид нэгдэн орохоос өмнө батлагдсан ба 2010, 2011, 2018, 2021 онуудад цөөн нэмэлт, өөрчлөлт орсон. Эдгээр өөрчлөлтүүд нь УХОУК-тай нийцүүлэх тал дээр хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл, УХОУК-иор хүлээсэн үүргийн дагуу ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг бүхэлд хамарч зохицуулаагүй байна.

Тухайлбал, УХОУК-иор тодорхойлсон улс орнууд өөрийн нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Ургамал хамгааллын үндэсний байгууллага, түүний бүрэн эрхийг хуульчилаагүй. Үүнээс шалтгаан Монгол Улсад ургамал хамгаллын асуудал хариуцсан 4 бие даасан байгууллага ажилладаг⁶:

- Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам (ХХААХҮЯ);
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам (БОАЖЯ);
- Ургамал Хамгаллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Боловсрол Шинжлэх Ухааны яамны (БШУЯ) харьяанд;
- Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар (МХЕГ) Шадар сайдын харьяанд.

Түүнчлэн, тухайн хууль нь ОУУХК-ийг Монгол Улсын Их Хурлаас соёрхон батлахаас өмнө батлагдсан ба уг конвенцид нийцүүлэх ажлыг хийгээгүй тул хуулийн нэр томъёоны тодорхойлолтууд ОУУХК ба ISPM 5⁷ стандартад нийцээгүй ба шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтуудыг бүрэн агуулаагүй.

⁶ Монгол Улсын ургамал хамгааллын тухай хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2021

⁷ International standards for phytosanitary measures 5-Ургамлын эрүүл ахуйн нэр томъёоны тайлбар

Өөрөөр хэлбэл, ОУУХК, түүний стандартад байгаа зарим нэр томъёог Ургамал хамгааллын хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд орхигдуулсан байна. ОУУХК-иор зөвлөсний дагуу хуульд тодорхойлоогүй нэр томъёог ОУУХК болон ISPM 5 томъёолсоноор ойлгоно гэсэн ишлэлгүй бол ердийн түгээмэл утгаар ойлгоно гэж заагаагүй байна.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх явцад ургамлын эрүүл ахуй, ургамал хамгааллын арга хэмжээг олон улсын хэм хэмжээ, зарчим, Монгол Улсын олон улсын гэрээний үүргээ хэрэгжүүлэх үүднээс эрхзүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байгааг “Ургамал хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”⁸-д “Өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь ОУУХК -ийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд бүрэн нийцээгүй байна.” гэж дүгнэснээс харагдаж байна.

Салбарын эрдэмтэд, судлаачдын хэлэлцүүлэг, уулзалт дээр энэ асуудлууд хөндөгддөг.

Гишүүн орны хувьд ургамлын эрүүл ахуйн асуудлыг хариуцсан Ургамал хамгааллын үндэсний байгууллага (УХҮБ)-ыг байгуулах, үйл ажиллагааг нь тодорхойлох, зөвхөн зохицуулалттай хөнөөлт организмыг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд хамруулах, хөнөөлт организмын тандалт судалгаа, эсрдлийн үнэлгээг хийх, хөнөөлт организмгүй болон хөнөөлт организмаар бага нутаг дэвсгэрийг тогтоох өөрийн болон бусад орны нутаг дэвсгэрт ургамлын хөнөөлт организм нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэмийг сайжруулах, улмаар ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний худалдааг дэмжих зэрэг асуудлыг бүхэлд нь хамарч зохицуулсан үндэсний эрх зүйн орчноо боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас “Ургамал хамгааллын тухай” хуулийн сонгож авсан зарим зохицуулалтад үнэлгээг хийхээр төлөвлөсөн.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”⁹-д хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж буй хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийх боломжтой юм. Иймд ургамлын эрүүл мэндийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

Тухайлбал, гишүүн орны хувьд Монгол Улсын олон улсын гэрээ болох ДХБ-ын Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрээр гишүүн

⁸ Монгол Улсын ургамал хамгааллын тухай хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2021

⁹ “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт

орнууд хүлээн зөвшөөрсөн үндсэн үүрэг¹⁰ болон ОУУХК –ийн IV зүйл¹¹-ийн дагуу гишүүн орнуудын хүлээсэн үндсэн үүргийн хүрээнд ач холбогдолтой гэж үзсэн зохицуулалтуудын хүрээнд үнэлгээг хийв. Тухайлбал, ургамал хамгааллын үйл ажиллагаа, ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага, ургамлын хорио цээр тогтоох болон Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбоотой уг хуулийн хэрэгжилтэд голлон нөлөөлж буй зүйл, заалтуудыг сонгосон.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох, шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд Ургамал хамгааллын тухай хуулийн сонгосон зүйл заалтыг дээрх аргачлалын 3.4.1-д заасан “Зорилгод хүрсэн түвшин”, 3.4.5-д заасан “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх боломжтой гэж үзлээ.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашил “аргачлал” гэх/-д заасан “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьдог тул сонгосон зохицуулалт тус бүрийг зорилгод хүрэх түвшин шалгуураар үнэлнэ.

¹⁰ Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр 2-р зүйл. Үндсэн эрх, үүрэг 1. Энэхүү Хэлэлцээрийн заалтад харшлахгүй бол, гишүүд хүн ам, амьтан, ургамлын амьдрал, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхтэй. 2. Гишүүд амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг зөвхөн хүн ам, амьтан, ургамлын амьдрал, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай хэмжээгээр хэрэгжүүлж, шинжлэх ухааны зарчимд үндэслэх ба 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд шинжлэх ухааны нотолгоогүйгээр хэрэгжүүлэх ёсгүй. 3. Гишүүд нь өөрсдийн авсан амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ нь ижил буюу төстэй нөхцөлд байгаа гишүүдийн хувьд, түүний дотор өөрсдийн болон бусад гишүүний нутаг дэвсгэрийн хооронд дур зоргоор болон үндэслэлгүйгээр үл ялгаварласан байх явдлыг хангана. Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг олон улсын худалдаанд нуугдмал хязгаарлалт тогтоосон байдлаар ашиглахгүй.

¹¹ Ургамал хамгааллын олон улсын конвенцийн 4 дүгээр зүйл. Ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн хувьд үндэсний хэмжээнд авах зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд 1. Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлд заасан үндсэн үүрэг хүлээх албан ёсны ургамал хамгаалал, хорио цээрийн үндэсний байгууллагыг өөрсдийн боломжийн хэрээр үүсгэн байгуулах явдлыг хэлнэ. Ургамал хамгаалал хорио цээрийн үндэсний байгууллага дараахь үүргийг хүлээнэ: Тээвэрлэх гэж буй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, түүнчлэн зохицуулагдах бусад зүйлд импортлогч хэлэлцэн тохирогч талын ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн хууль тогтоомжийн дагуу гэрчилгээ олгох:

- a) 8 дугаар зүйлийн 1(a) хэсэгт заасан хортон шавьжийг хянах, ургаж байгаа ургамлын суулгацыг нэвтрүүлэхдээ тариалж байгаа газар болон хүрээлэн байгаа орчинд (тариалангийн талбайн дундын газрууд, тариалангийн талбай, суулгац тариалах, цэцэрлэг, хүлэмж лабораториуд) үзлэг хийх, ялангуяа хортон шавьж илэрсэн болон тархаж байсан тохиолдлууд бүртгэгдсэн газруудад ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтэнд үзлэг хийх,
- b) олон улсын тээвэрлэлтээр тээвэрлэгдэж байгаа ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний бүхий ачаа болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хортон шавьж тархахаас болон эсхүл түгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохицуулагдах бусад зүйлийг шалгах
- c) олон улсын тээвэрлэлтээр тээвэрлэгдэж байгаа ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон ачаа болон зохицуулагдах бусад зүйлийг ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагад нийцүүлэн ариутгах халдваргүйжүүлэх:
- d) аюулд өртөгдөж болох нутаг дэвсгэрийг хамгаалах, хортон шавьж тархаагүй болон бага тархсан нутаг дэвсгэрийг тодорхойлох, тогтоох, шалгах:
- e) хортон шавьжны эрсдлийн шинжилгээ хийх:
- f) экспортлогдохоос өмнөх бараа бүтээгдэхүүний бүтэц, найрлага, ариутгалтай холбоотой гэрчилгээ олгосны дараа ургамлын эрүүл ахуй, хорио цээрийг хангахтай холбогдох арга хэмжээг авах болон
- g) мэргэжилтнүүдийг сургах, хөгжүүлэх

2. Хэлэлцэн тохирогч тал бүр дараахь зүйлийг боломжийн хэрээр хангах арга хэмжээ авна:

- a) хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээрх хяналтанд байгаа хортон шавьж, тэдгээрийн тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг дамжуулах
- b) ургамал хамгаалал, хорио цээрийн чиглэлээр эрдэм шинжилгээний судалгаа хийх:
- c) ургамлын эрүүл ахуйн зохицуулалтыг хэвлэн нийтлэх
- d) энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд шаардагдаж болох чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Хэлэлцэн тохирч тал бүр ургамал хамгаалал, хорио цээрийн үндэсний байгууллагын тухай албан ёсны мэдээлэл болон уг байгууллагын өөрчлөлтүүдийн талаархи мэдээллийг Нарийн бичгийн даргад хүргүүлэх ёстой. Хэлэлцэн тохирогч тал өөрийн ургамал хамгаалал, хорио цээрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаархи хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтийн дагуу түүнд хүргүүлнэ.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлт

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн сонгосон зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг сонгосон зохицуулалт тус бүрээр тодорхойлно.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлог

№	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.	Тухайн хууль нь 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдан Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэнээс 10 хоногийн дараагаас үйлчилж эхэлсэн. Хууль тогтоогч уг хуулийн зорилтыг бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлсон. Иймд хууль энэ зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлэх ёстой.
2	Практикт нийцэж байгаа байдал	Хууль хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.	Хуулийн ойлгомжтой байдал, амжилттай хэрэгжүүлэх боломж, бололцоо практикт байгаа эсэх зэргийг тодорхойлно.

Харин хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд сонгоогүй шалгуур үзүүлэлтийн хувьд:

- зардлын өсөлт бууралтыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн хувьд хууль хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүссэн зардлын өсөлт, бууралтыг тодорхойлох шаардлагатай болох бөгөөд 2007 оноос хойших хугацааны зардлын өсөлт, бууралтын мэдээллийн бааз хангалтгүй.
- зардал-үр өгөөжийн харьцааг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн хувьд хууль хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр өгөөжийн харьцааг тооцон гаргах шаардлагатай. Хуулийг хэрэгжүүлэхэд гарсан зардал нь бий болсон үр өгөөжөөтэй харьцуулах мэдээлэл хангалтгүй тул энэхүү шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх боломжгүй байна.

1.4. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Ургамал хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, холбогдох мэргэжлийн хүрээлэн болон бусад төрийн байгууллагуудаас гаргасан мэдээ мэдээлэл, мөн аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу ургамлын эрүүл ахуй, ургамал хамгааллын чиглэлийн эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд болон олон улсын байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн үр дүн зэргээр бүрдүүлсэн болно.

1.5. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлан хийж, гүйцэтгэв. Түүнчлэн Ургамал хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхэтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон холбогдох байгууллагуудаас гаргасан мэдээлэлд үндэслэн Ургамал хамгааллын тухай хуулийн сонгогдсон зүйл, заалтууд тухайн асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлохыг зорьсон бөгөөд дор дурдсан заалтуудыг "Зорилгод хүрэх түвшин" болон "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв.

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	3.1.3."ургамал хамгаалал" гэж бэлчээрийн болон таримал ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг;	Монгол Улсын нутаг дэвсгэрт хөнөөлт организм нэвтрэх, тархах, урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.
2	5 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага 5.2.Төв байгууллага нь бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ байна.	Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага нь МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч

	<p>8 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>8.1.Төрийн захиргааны төв байгууллага ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.3.ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>8.1.4.ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалтыг батлах;</p> <p>8.1.6.ургамал хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>8.1.8.ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;</p> <p>8.1.9.бэлчээрийн ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалт, олшролтын тодотгох судалгааг салбарын эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;</p> <p>8.1.10.тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах.</p>	<p>хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон байх.</p>
<p>3</p>	<p>7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</p> <p>7.1.Засгийн газар ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.2.бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;</p> <p>7.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах.</p> <p>14 дүгээр зүйл.Ургамлын хорио цээр тогтоох</p> <p>14.1.Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтооно.</p>	<p>Ургамлын хөнөөлт организм дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүнийг удирдах нөхцөл, журам, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх</p>

4	<p>15 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт</p> <p>15.1. Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2, 10.1-д заасан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.</p> <p>15.2. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.2.1. ургамал хамгааллын үйл ажиллагааны талаархи стандарт, технологийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>15.2.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх;</p> <p>15.2.3. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;</p> <p>15.2.4. таримал ургамлын үр, суулгац, ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх явцад хяналт тавих</p>	<p>Ургамлын хөнөөлт организм улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх.</p>
---	---	--

2.1. ҮНЭЛСЭН БАЙДАЛ

2.1.1. ХУУЛИЙН 3.1.3 ДАХЬ ЗААЛТЫН "ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ" БОЛОН "ПРАКТИКТ НИЙЦСЭН БАЙДАЛ"-ЫН ҮНЭЛГЭЭ

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	<p>3.1.3. "ургамал хамгаалал" гэж бэлчээрийн болон таримал ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг;</p>	<p>Ургамлын хөнөөлт организм Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, тархах, урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.</p>

2.1.1.а. Хуулийн 3.1.3 дахь заалтыг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.3-т “ургамал хамгаалал” гэсэн нэр томъёог тодорхойлсон байх ба энэхүү заалтыг “Ургамлын хөнөөлт организм Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, тархах, урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.” гэх шалгуур үзүүлэлтээр “Зорилгод хүрэх түвшин”-г үнэлэв.

Судалсан байдал

“Ургамал хамгаалал” гэсэн нэр томъёог авч үзвэл “бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын “өвчин”, “хөнөөлт шавж”, “мэрэгч амьтан”, “хог ургамал”-ын хөнөөлөөс “урьдчилан сэргийлэх”, түүнтэй “тэмцэх”, “хорио цээр тогтоох” арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа гэж тодорхойлжээ.

Уг нэр томъёог “Ургамлын хөнөөлт организм Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, тархах, урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх ойлголтууд бүрэн багтсан байна.” гэх шалгуур үзүүлэлтээр шалгахад ЗОРИЛГОДОО ХҮРСЭН байна. Тодруулбал,

Бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гэсэн уг хуулийн зорилтод нийцэж байгаа ба ургамал хамгааллын үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх, тэмцэх, хорио цээр тогтоох, түүнийг цуцлахтай холбоотой цогц арга хэмжээнээс бүрдэнэ хэмээн заажээ.

Энэ хүрээнд салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд бэлчээрийн болон таримал ургамлын хөнөөлт организмын тандалт судалгааг хийх үүргийг хүлээсэн. Судалгааны дүнд үндэслэн хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлууд тодорхой түвшинд бүсчилсэн байдлаар хуульд заасны дагуу хийгдэж байна.

Гэсэн хэдий ч судалгааны дүнд үндэслэн ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажил төдийлөн хийгддэггүй талаар салбарын мэргэжилтүүд ярьж хэлж байв. Хуульд тусгагдсан ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалт¹², ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх¹³ болон хорио цээр тогтоох¹⁴той холбогдсон журмууд эрх бүхий албан тушаалтнаар батлагдсан хэрэгжиж байна. Ургамал хамгааллын тухай хууль 2007 онд батлагдсан боловч 2008 онд хорио цээрийн үед баримтлах журам, 2015 онд ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалт, 2019 онд ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх журам батлагдсан байна. Өөрөөр хэлбэл, ургамал хамгаалалтай холбогдсон эрх зүйн орчин удааширалтай бүрджээ. Хэдийгээр хууль батлагдсанаас хойш 12 жилийн дараа уг нэр томъёоны тодорхойлолтод заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий төлөвлөх, санхүүжүүлэх журам гарсан байгаа нь зорилгодоо хүрсэн гэж дүгнэх үндэслэл болж байна. “Ургамал хамгаалал” нэр томъёогоор тодорхойлсон үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн боловч дараахь асуудлыг анхаарах шаардлагатай. Үүнд:

¹² Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон гадаад хорио цээртэй болон тус улсад хязгаарлагдмал тархалттай дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтдын нэрсийн жагсаалт, ХХАА-н сайдын 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/90 дүгээр тушаал

¹³ Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам, ХХААХҮ-ийн сайд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/500/283 дугаар тушаал

¹⁴ Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам, Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 190 дүгээр тогтоолын хавсралт

Гэсэн хэдий ч “ургамлын эрүүл ахуй үзлэг” гэсэн нэр томъёонд химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг шалгах асуудлыг оруулсан нь УХОУК-ийн нэр томъёоны стандарт¹⁷тай зөрчилдөж байгааг дээр дурдсан.

Түүнчлэн Монгол Улсын Ургамал хамгааллын нэр томъёоны стандарт¹⁸-д “Ургамал хамгаалал” гэж “Байгалийн болон таримал бүх төрлийн ургамлыг өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хорио цээр тогтоохтой холбогдсон арга хэмжээ”, Ургамлын хорио цээрийн нэр томъёоны стандарт¹⁹ад “ургамлын хорио цээр” гэснийг “Ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамлыг улсын хил нэвтрүүлэхгүй байх, тэдгээрийг тархсан, олширсон нутгаас бусад нутагт тархахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн хорио цээрийн арга хэмжээ” гэж, түүнчлэн “хорио цээрийн үзлэг шалгалт” гэснийг “Ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, сав баглаа боодолд ургамлын хорио цээрийн үзлэг шалгалт хийх” гэж тус тус томъёолсонтой нийцэхгүй байна.

Зөв зохистой мэдлэггүй байх нь тухайн улсыг гадны хөнөөлт организмын халдлагад өртөх эрсдэл өндөртэй болгоно.²⁰ Үүнээс улбаалан “ургамал хамгаалал”, “ургамлын эрүүл ахуйн үзлэг” болон “ургамал хамгаалах бодис” гэсэн тодорхойлолтууд, тэдгээртэй холбоотой тус хуулийн бусад зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учрах, энэ талаарх үйл ажиллагааг нэр мөр ойлгож хэрэглэхгүй байх зэрэг сөрөг үр дагавартай гэж үзэн практикт нийцэж байгаа шалгуур үзүүлэлтийг хэсэгчлэн хангасан байна гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

Хуулийн гол агуулгыг тайлбарласан “ургамал хамгаалал” гэсэн томъёог тайлбарласан байдал болон түүнтэй холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хуулийн бусад зохицуулалт нь ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай “эрх зүйн орчин бүрдсэн” байна гэсэн “томъёоллоор шалгаж “Зорилгод хүрсэн байдал”, “Практикт нийцсэн байдал”-ыг тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Ургамал хамгаалал гэсэн нэр томъёоны тайлбарыг Монгол Улсын холбогдох стандартад нийцүүлэх шинэчлэх. Эсхүл УХОУК-ийн нэр томъёоны стандартад ургамал хамгаалал гэсэн нэр томъёо байхгүй байгааг анхаарах,
2. Улмаар үүнтэй холбогдуулан уг хуулийн ургамал хамгаалалтай холбогдсон зохицуулалтууд болон хуулийг дагаж гарсан дүрэм, журам зааврыг шинэчлэх.

2.1.2 ХУУЛИЙН 5 БОЛОН 8 ДУГААР ЗҮЙЛИЙН “ЗОРИЛГОД ХҮРЭХ ТҮВШИН” БА “ПРАКТИКТ НИЙЦСЭН БАЙДАЛ”ЫН ҮНЭЛГЭЭ

2	<p>5 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага</p> <p>5.2. Төв байгууллага нь бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ байна.</p> <p>8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p>	<p>Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага нь МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон байх.</p>
---	--	--

¹⁷ ISPM 5-14

¹⁸ Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт, MNS 3471:2003

¹⁹ Ургамлын хорио цээр. Нэр томъёо, тодорхойлолт, MNS 3475:2003

²⁰ Report on the evaluation of the capacity building in strengthening agriculture quarantine services in Mongolia, 2016

- Уг нэр томъёонд “өвчин”, “хөнөөлт шавж”, “мэрэгч амьтан”, “хог ургамал”-ын хөнөөлыг дурдсан боловч цаашид задлан тайлбарласан нэр томъёонд “хог ургамал”-ыг тайлбарлаагүй орхигдуулсан.

2.1.1.6. Хуулийн 3.1.3 дахь заалтыг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 3.1.3-т “ургамал хамгаалал” гэсэн нэр томъёог тодорхойлсон байх ба энэхүү заалтыг “Ургамлын хөнөөлт организм Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, тархах, урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.” гэх шалгуур үзүүлэлтээр “Практикт нийцэж байгаа байдал”-ыг үнэлэв.

Судалсан байдал

Аргачлалд практикт нийцэж байгаа байдлыг тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно гэж заасны дагуу “Ургамал хамгаалал” гэсэн томъёог практикт нийцэж байгаа эсэхийг шалгав. Тухайн нэр томъёоны Зорилгодоо хүрсэн байдлыг шинжлэх явцад илрүүлсний дагуу энэ нэр томъёотой уялдсан дараагийн тодорхойлолт болох “ургамлын эрүүл ахуйн үзлэг”-т “химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг шалгах” асуудлыг оруулсан нь хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй, төөрөгдүүлэх шинжтэй болсон байна. Мөн “Ургамал хамгаалал” нэр томъёо-нд туссан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй уг хуулийн 3.1.7-д “ургамлын эрүүл ахуйн үзлэг”-ийг тайлбарласан.

Уг нэр томъёоны тайлбарыг “ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал, химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг шалгахыг” хэлнэ гэж томъёолсон ба энэ нь УХОУК-ийн Нэр томъёоны стандартад “ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон бусад зохицуулалттай эд зүйлд хөнөөлт организм байгаа эсэхийг тодорхойлох эсхүл ургамлын эрүүл ахуйн дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг шалгах тогтоох үйл ажиллагаа”¹⁵-г хэлнэ гэсэнтэй уялдахгүй байна. Тухайлбал, химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг шалгахаар байгаа.

Ургамлын хорио цээрийн зорилго нь хөнөөлт организм нэвтрэхээс сэргийлэх, тархалтыг хянахад чиглэдэг бол пестицидийн менежмент нь пестицидийн хэрэглээнээс үүдэн эрүүл мэнд, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.¹⁶ УЭА-г хамгаалдаг этгээд нь үзлэг шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий УХҮБ, харин нөгөө нь, пестицидийн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх, импортлох, үйлдвэрлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй этгээд байдаг. Хэдий хоёул ургамал, хөнөөлт организмд тавих хяналттай холбоотой ч, үйл ажиллагаанууд нь хоорондоо тэр бүр таардаггүй гэж үздэг.

УЭА-н бүх үйлчилгээ (УХҮБ) хилийн нэвтрэх цэгүүдэд (усан/хилийн боомтууд, онгоцны буудал, шуудан илгээмж, хилээр нэвтэрсний дараахи хорио цээрийн бүс), харин пестицидийн албаны бүх үйл ажиллагаа (импортын хяналтаас бусад) үйлдвэрлэлийн байгууламж, лаборатор, тариалангийн талбайд явагддаг.

Ургамлын эрүүл ахуй, пестицидийн асуудлууд хоорондоо олон талаар холбогддог тул эдгээрийг нэг хуулиар зохицуулахыг зүйтэй гэж үзэж нэг хуулиар зохицуулдаг зарим улс орнууд байдаг.

¹⁵ ISPM 5-14

¹⁶ Ургамлын эрүүл ахуйн тухай үндэсний хууль тогтоомжийг шинэчлэн найруулах заавар, Жессика Ванпек, Даниел Манцелла, 2007

	<p>8.1.Төрийн захиргааны төв байгууллага ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.3.ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>8.1.4.ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалтыг батлах;</p> <p>8.1.6.ургамал хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>8.1.8.ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;</p> <p>8.1.9.бэлчээрийн ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалт, олшролтын тодотгох судалгааг салбарын эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;</p> <p>8.1.10.тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах.</p>	
--	--	--

2.1.2.а. Хуулийн 5 болон 8 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 5 ба 8 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон түүний чиг үүргийг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон байх” гэх шалгуур үзүүлэлтээр “Зорилгод хүрэх түвшин”-г үнэлэв.

Судалсан байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д ургамал хамгааллын үйл ажиллагааг төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллага хэрэгжүүлэхээр хуульчилсан ба 5.2-т “Төв байгууллага нь бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ байна” гэж заажээ. Хэдийгээр УХОУК-д нэгдэхээс нэг жилийн өмнө гарсан ч одоог хүртэл уг хуулийг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх ажлыг хийгээгүй байна.

Ургамал хамгааллын тухай хуулийн 2.2-т Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж заасан ба эндээс харахад УХОУК-иор хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгаа ч ямар нэг хууль зүйн үр дагавар бүхий асуудал үүсэхэд УХОУК-ийг дагаж мөрдөх эрх зүйн орчин хэдийн нь үүссэн байгааг тэмдэглэх нь зүйтэй. Уг конвенциор гишүүн орон, тухайлбал манай улс ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөлт организм үүсэх, тархахыг хянах, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, техникийн болон захиргааны арга хэмжээ авах, ургамал хамгааллын албан ёсны үндэсний байгууллагыг байгуулах үүргийг хүлээжээ.

Дараах хүснэгтээр Монгол Улсын 2007 оны Ургамал хамгааллын тухай хууль болон бусад хуульд УХОУК-ийн үндэсний хэмжээнд ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хариуцах байгууллагыг ОУУХК-ийн 4-р зүйл буюу гишүүн орнуудын хүлээсэн үндсэн үүрэгтэй харьцуулан харуулав.

№	Гишүүн орнууд дараахь үндсэн үүрэгтэй (ОУУХК-ийн 4-р зүйл)	Үндэсний хуульд туссан байдал	Зохицуулсан хуулийн нэр	Хариуцах байгууллага
1	Ургамал хамгааллын албан ёсны үндэсний байгууллагыг байгуулах	5.1.Ургамал хамгааллын үйл ажиллагааг төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллага хэрэгжүүлнэ.	Ургамал хамгааллын тухай хууль	ХХААХҮЯ, Орон нутгийн Засаг дарга, Мэргэжлийн байгууллага, Эрдэм шинжилгээний байгууллага
2	Ургамал хамгааллын албан ёсны үндэсний байгууллага нь ургамал хамгааллын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах	8.1.3.ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;	Ургамал хамгааллын тухай хууль	ХХААХҮЯ
3	Хорио цээртэй болон зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалтыг гаргах	8.1.4.ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалтыг батлах;	Ургамал хамгааллын тухай хууль	ХХААХҮЯ
4	Ургамал хамгаалах дүрэм, журам батлах	7.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах.	Ургамал хамгааллын тухай хууль	Засгийн газар
		8.1.8.ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;		ХХААХҮЯ
5	Эрүүл ахуйн гэрчилгээ олгох	ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох;	Амьтан, ургамлын ... хорио цээрийн тухай хууль	ГЕГ-ын Хилийн хорио цээрийн газар
6	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг Монгол Улсад	1.1.Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд,	Амьтан, ургамлын ... хорио цээрийн тухай хууль	ГЕГ-ын Хилийн хорио цээрийн газар

	<p>нэвтрүүлэх, олон улсад тээвэрлэгдэж буй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон бусад зохицуулалттай зүйлд хяналт шалгалт хийх, халдвар илэрсэн тохиолдолд халдваргүйжүүлэх ажлыг зохицуулах;</p>	<p>бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>		
7	<p>Ургамал хамгаалах чиглэлээр судалгаа хийх; Хөнөөлт организм тархаагүй болон бага тархсан газар нутгийг судлах;</p>	<p>8.1.9.бэлчээрийн ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалт, олшролтын тодотгох судалгааг салбарын эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;</p>	Ургамал хамгааллын тухай хууль	ХХААХҮЯ
		<p>5.4.Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн талаар судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах, ургамал хамгаалах арга технологи /цаашид "технологи" гэх/ боловсруулах, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага байна.</p>		УХЭШХ
8		<p>8.1.10.тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах.</p>		УХЭШХ

9	Аюулд өртсөн бүс нутгийг хамгаалах, хөнөөлт организмын эрсдлийн шинжилгээнд нийцсэн техникийн үндэслэл бүхий ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлох, явуулах, зарлан мэдээллэх;	7.1.2.бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;	Ургамал хамгааллын тухай хууль	Засгийн газар
		14.1.Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтооно.		Тухайн шатны Засаг дарга
10	Ургамлын хөнөөлт организмын талаар мэдээлэл солилцоход хамтран ажиллах;	-	-	-
11	Конвенцийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцоход холбоо барих ажилтныг томилох	-	-	-
12	Ажилтнууддаа сургалт явуулах, тэдгээрийг хөгжүүлэх	-	-	-

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсын олон улсын холбогдох гэрээгээр хүлээсэн үүргийг Ургамал хамгааллын тухай хууль /2007/ болон Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль /2002/ хуулиудаар зохицуулж байгаа ба хариуцсан хэд хэдэн байгууллагууд байна. Тухайлбал, тус хуулийн 5.1-д “Ургамал хамгааллын үйл ажиллагааг төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллага хэрэгжүүлнэ” гэж хуульчилсан ба дараахь байгууллагуудыг дурджээ. Үүнд

- Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам;
- Орон нутгийн байгууллага нь аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, түүний харъяа байгууллага;
- Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн;
- Мэргэжлийн байгууллага.

УХОУК-иор гишүүн орнуудын хүлээсэн үүргийн ихэнхийг Монгол Улсын Ургамал хамгааллын тухай хууль, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн тухай хуулиар зохицуулсан байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Харин ургамлын хөнөөлт организмын талаар мэдээлэл солилцоход хамтран ажиллах, Конвенцийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцоход холбоо барих ажилтныг томилох, ажилтнууддаа сургалт явуулах, тэдгээрийг хөгжүүлэхтэй холбоотой заалтууд аль ч хуульд тусгагдаагүй байна. Ургамал хамгааллын тухай хуульд “ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах”²¹ үүргийг ХХААХҮЯ-нд олгосон ба бусад байгууллагаар зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр тусгасан.

Эдгээр зохицуулалт нь ургамал хамгааллын үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг нь үндэсний нэг байгууллагад байх ёстой гэсэн УХОУК-ийн заалтад нийцэж байгаа мэт харагдавч энэ үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд конвенцид заасны дагуу тус яаманд тайлагнах тухай заалт Ургамал хамгааллын хуульд тусгагдаагүй.

Нөгөө талаас УХОУК-иор ургамлын эрүүл мэндийг хамгаалахад чухал чиг үүргийг хэрэгжүүлэгч хяналтын байгууллагыг дээрх байгууллагад оруулаагүй байгаа боловч уг хуулийн 15 дугаар зүйлд “Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт” гэсэн утгаар заажээ. Түүнчлэн тус хуулийн 15.2-т “Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- “15.2.1.ургамал хамгааллын үйл ажиллагааны талаархи стандарт, технологийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангуулах;
- 15.2.2.ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх;
- 15.2.3.ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах” гэж заасан байдаг.

Гэсэн хэдий ч Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон зохицуулалттай эд зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх үед ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцаа буюу УХОУК-иор хүлээсэн үүргийг голчлон тусгасан холбогдох хууль²²-ийг дурдаагүй байна. Мөн уг хуулийн ургамал хамгааллын тухай хууль тогтоомжид ч байхгүй байна.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох; ургамал экспортлох, импортлох нөхцөл; дамжин өнгөрөх нөхцөл, журам; ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн нэвтрүүлэх боомт; ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний ачааг шалгах журмыг тогтоосон.

Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хяналт шалгалт, экспорт, импорт, гэрчилгээ олгох асуудлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) хариуцан гүйцэтгэдэг. Өнөөдрийн байдлаар энэ чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжсэн.

²¹ Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.3.ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, 2007 он

²² Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002 он

Мөн хуулийн 3.1.1."бэлчээр" гэдгийг Газрын тухай хуулийн 3.1.6-д зааснаар ойлгоно гэж, 3.1.2."таримал ургамал" гэж хүний үйл ажиллагааны оролцоотойгоор зориудаар тарьж ургуулсан ургамал, тэдгээрийн үр, суулгацыг гэж тус тус томъёолсон ба хуулийн хамрах хүрээг заагаагүйгээс ойн ургамал хамгааллын асуудлыг хамарч байгаа эсэх нь бүдэг зохицуулагдсан ба үүнтэй холбоотойгоор ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохицуулалт сул болжээ.

Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ойн тухай хууль (2012) хуулиудад ч ургамал хамгаалалттай холбогдсон зохицуулалт хангалтгүй байдаг. Өөрөөр хэлбэл, одоогийн хууль тогтоомжид Үндэсний ургамал хамгааллын байгууллагыг албан ёсоор заагаагүй ба түүний ОУУХК-ийн дагуу гүйцэтгэх бүх чиг үүргийг тусгаагүй байна. Эндээс дүгнэхэд Ургамал хамгааллын тухай хуулийн 5 ба 8 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн зарим чиг үүргийг өөр өөр хуулиар салангид тодорхойлсон.

Иймээс "Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага нь МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон байх." гэх шалгуур үзүүлэлтээр "ЗОРИЛГОД ХЭСЭГЧЛЭН ХҮРСЭН" гэж үнэлэв.

Өөрөөр хэлбэл, ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага нь МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч хэрэгжүүлэх зохицуулалт болж хараахан чадаагүй байна.

2.1.2.6. Хуулийн 5 болон 8 дугаар зүйлийг "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 5 ба 8 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон түүний чиг үүргийг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул МУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлсон Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хамарч хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон байх." гэх шалгуур үзүүлэлтээр "Практикт нийцэж байгаа байдал"-ыг үнэлэв.

Судалсан байдал

Аргачлалд заасныг баримтлан уг хуулийн 5 ба 8 дугаар зүйл нь хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлж практикт нийцэж байгаа эсэхийг тогтоов.

Өнөөдрийн эрх зүйн орчны хүрээнд Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Үндэсний ургамал хамгааллын байгууллагыг албан ёсоор хуульчилж, түүний чиг үүргийг ОУУХК-ид нийцүүлээгүй даруй 18 жил өнгөрчээ. Харин бэлчээрийн болон таримал ургамал хамгаалах асуудлыг ХХАХҮЯ, Байгалийн ургамал хамгаалах асуудлыг БОАЖЯ, ургамлын хөнөөлт организмын тандалт судалгааны үүргийг Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнд, эскпорт, импортын гэрчилгээ олгох, ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд тавих хилийн хяналтыг Гаалийн байгууллага тус тус гүйцэтгэж байгаа ба өөр өөр хуулиудаар зохицуулж байна.

Ургамал хамгааллын тухай хуулиар холбогдох хууль тогтоомжийг нарийвчлан тусгаагүй, хамрах хүрээг заагаагүй. ХХААХҮЯ-ны чиг үүрэгт ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангахаар байгаа боловч бусад байгууллагад чиг үүргээ шилжүүлэх, эргээд тайлагнах, цаашид арга хэмжээг төлөвлөх

талаарх зохицуулалт тусгагдаагүй тул зөвхөн бэлчээрийн болон тариалангийн ургамал хамгааллын асуудлаар хумигдаж байна.

Түүнчлэн “хууль тогтоомж нь бүх холбогдох төрийн байгууллага, бусад сонирхогч талуудын төлөөллийг оролцуулсан Ургамал хамгааллын зөвлөл зэрэг зөвшилцлийн механизмыг тогтоогоогүй болно.”²³ Иймд Ургамал хамгааллын тухай хуулийн 5 ба 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж дүгнэв. Өөрөөр хэлбэл “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Санал, зөвлөмж:

Хуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах байгууллагын чиг үүргийн тогтоосон 5 ба 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “эрх зүйн орчин бүрдсэн” байна гэсэн “томьёоллоор “Зорилгод хүрсэн байдал” болон “Практикт нийцэж байгаа байдал”-ыг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын олон улсын гэрээний гишүүн орны хувьд Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ²⁴ гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу үндэсний ургамал хамгааллын байгууллагыг тодорхойлж хуульчлах, түүний үндсэн чиг үүргүүдийг тусгах.
2. Холбогдох бусад хуулиудыг судалж, уялдаа холбоог хангах.

2.1.3.ХУУЛИЙН 7 БОЛОН 14 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН “ЗОРИЛГОД ХҮРСЭН БАЙДАЛ” БОЛОН “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ”-ЫН ҮНЭЛГЭЭ

2.1.3.а.Хуулийн 7 болон 14 дүгээр зүйлийг “Зорилгод хүрсэн байдал”-ыг үнэлсэн байдал

3	<p>7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 7.1.Засгийн газар ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.2.бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;</p> <p>7.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах.</p> <p>14 дүгээр зүйл.Ургамлын хорио цээр тогтоох</p> <p>14.1.Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтооно.</p>	<p>Ургамлын хөнөөлт организм дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүнийг удирдах нөхцөл, журам, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх</p>
---	--	---

²³ Монгол Улсын Ургамал хамгааллын тухай хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2021 он

²⁴ Монгол Улсын Үндсэн хууль 10.2 болон 10.3 зүйл. (1992)

2.1.3.а. Ургамал хамгааллын тухай хуулийн 7 ба 14 дүгээр зүйлд хөнөөлт организм илэрсэн тохиолдолд ургамлын хорио цээр тогтоох байгууллага, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул “Ургамлын хөнөөлт организм дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүнийг удирдах нөхцөл, журам, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх” гэх шалгуур үзүүлэлтээр “Зорилгод хүрэх түвшин”-г үнэлэв.

Судалсан байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн дараахь заалтуудаар хөнөөлт организм илэрсэн үед хорио цээр тогтоох, цуцлах шийдвэрийг бүс нутгийн хэмжээнд Засгийн газар, харин тухайн орон нутгийн түвшинд тухайн шатны Засаг дарга гаргахаар заасан. Харин энэ тохиолдолд баримтлах журмыг батлах бүрэн эрхийг Засгийн газарт олгожээ. Хуулийн доор дурдсан заалтууд нь Засгийн газарт хамаарна.

- 7.1.2.бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;
- 7.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах.

Хуулийн 14 дүгээр зүйл.Ургамлын хорио цээр тогтоох буюу 14.1-д заасны дагуу ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтооно.

Эдгээр заалтуудаас харахад Засгийн газар хорио цээр тогтоохдоо холбогдох яам болон мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвхөн бүс нутгийн хэмжээнд хорио цээр тогтоож, цуцална. Харин тухайн шатны Засаг дарга буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ хорио цээр тогтоохоор хуульд заасан боловч цуцлах асуудлыг тусгаагүй байна. Түүнчлэн, Засаг дарга хорио цээр тогтоосон тохиолдолд энэ тухай холбогдох яаманд мэдэгдэх, тайлагнах талаар зохицуулалтгүй байна. Мөн сумын Засаг дарга нутаг дэвсгэртээ хорио цээр тогтоосон бол бас л дээд шатны Засаг дарга болон яаманд мэдэгдэх үүргийг хуульчлаагүй байна.

Хуульд заасны дагуу Засгийн газар хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг 2008 онд²⁵ баталсан. Энэ журмыг хорио цээр тогтоосон бол дээрх 2 тохиолдолд хоёуланд нь дагаж мөрдөнө. Журмын 4-т хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ургамлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн шатны Засаг даргатай хамтран арга хэмжээг зохион байгуулахаар тусгасан боловч хэрэв сумын Засаг дарга хорио цээр тогтоосон бол аймгийн Засаг дарга энд ямар нэг үүрэггүй байхаар харагдаж байна.

Энэ журамд мөн тайлагнах асуудлыг орхигдуулсан байна. Уг журамд хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт зохион байгуулах арга хэмжээ, тухайн нутаг дэвсгэрт орох, гарахад тавигдах шаардлага болон хориглох зүйл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөл, арга, уг журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгажээ. Хуулийн 8.1.8.ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлахаар заасан. Энэ заалтыг үндэслэн “Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам”²⁶ хууль батлагдаж хэрэгжсэнээс хойш 12 жилийн дараа буюу 2019 онд батлагдсан.

²⁵ “Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам”, Засгийн газрын 2008.05.28-ны өдрийн 190 дугаар тогтоол

²⁶ “Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам”, ХХАА-н сайд, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №А500/283 хамтарсан тушаал, <https://legalinfo.mn/mn/detail/14994>

Харин хуулийн 16 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх ба санхүүжүүлэх арга хэмжээг хуульчилсан. Энд уг журмыг баримтлах талаар тусгаагүй. Түүнчлэн журам 2019 онд батлагдсан тул ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх эрх зүйн орчин 12 жилийн дараа бүрджээ. Хорио цээрийн үед баримтлах журмын 4.6-д хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, хүн хүч, техник хэрэгсэл, материалын тооцоог холбогдох байгууллагатай хамтран боловсруулж шийдвэрлүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, Гамшгаас хамгаалах тухай²⁷ хуульд аюулт үзэгдэлд хортон шавж, мэрэгч тархахыг оруулж томъёолсон байгаа ба энэ тохиолдолд авах арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын тусгай сангийн тухай²⁸ хуулиар зохицуулсан.

Өнөөдрийн байдлаар санхүүжилттэй холбоотой эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн байна. НҮБ-ын ХХААБ-аас 2007 онд гаргасан Ургамлын эрүүл ахуйн тухай үндэсний хууль тогтоомжийг шинэчлэн найруулах зааварт хорио цээр тогтоох, цуцлах бүрэн эрхийг сайдад олгож, харин тэдгээр арга хэмжээг авах шийдвэр гаргах бүрэн эрхийг УХҮБ-н даргад олгох хувилбар байж болох талаар тусгасан ба манай улсын эрх зүйн орчинд энэхүү эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой хэмжээгээр хийсэн байна. Гэхдээ, үндэсний хэмжээнд ургамал хамгааллыг хариуцсан нэг байгууллага байхгүйгээс хорио цээр тогтоохтой холбогдсон эрх мэдлийн хуваарилалт эмх цэгцгүй энд тэнд байгаа байдал ажиглагдлаа.

Түүнчлэн хорио цээрийн үед баримтлах дээр дурдсан журамд хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт хориглох зүйлийг зааж оруулсан байгаа нь хуулиар зааснаас өөр зохицуулалтуудыг нэмж оруулсан байгаа ба зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Хуулиар дараахь үйл ажиллагааг хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр явуулахыг хориглосон байдаг. Үүнд:

4.4.1. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гаргах, дамжин өнгөрүүлэх;

- 14.4.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг бэлтгэх;
- 14.4.3. халдвартай үр, суулгацыг борлуулах, шилжүүлэх, тариалах;
- 14.4.4. хөнөөлийн голомттой байр, агуулах, хашаа, талбайг ариутгал, халдваргүйжүүлэлт хийхгүйгээр ашиглах.

Тэгвэл журмаар дараахь үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэхгүйгээр явуулахыг хориглохоор тусгасан:

22.1. Бэлчээр, нутаг сэлгэх, нүүх;

- 22.2. Үр, суулгац тариалах, ургац хураах, борлуулах;
- 22.3. Хадлан бэлтгэх;
- 22.4. Явган болон ердийн хөсгөөр хориотой бүсээс гадагш зорчих;
- 22.5. Халдварын голомт бүхий агуулах, зоорь, сав баглаа, боодол, үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, түүхий эд, хөрс, бэлчээр, талбайг ашиглах;
- 22.6. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрээс тээврийн хэрэгслээр тайван бүс нутаг руу зорчих, тээвэр хийх;
- 22.7. Үзэсгэлэн, хурал, цуглаан, баяр наадам зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;
- 22.8. Онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс гарах, орох, дамжин өнгөрөх.

²⁷ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12458>

²⁸ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019, <https://legalinfo.mn/mn/detail/14848>

Ингэхдээ журамд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн бол хориглосон үйл ажиллагааг зөвшөөрөхөөр журамласан байна.

Өөрөөр хэлбэл, журам нь хуулиас давсан зохицуулалтуудыг агуулжээ. НҮБ-ын ХХААБ-гаас гаргасан зааварт хорио цээрийн дэглэм тогтоох, хөнөөлт организм гарсан нутаг дэвсгэрээс хүн ам, тээврийн хэрэгсэл, ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний орох, гарах хөдөлгөөнд хязгаарлалт тавих Засгийн газрын эрх үүргийг хуулиар тогтооно гэж тусгасан байдаг. Дээр дурдсан нөхцөл байдлаас харахад Ургамал хамгааллын тухай хуулийн хорио цээр тогтоохтой холбогдсон 7 ба 17 дүгээр зүйлүүдийг “Ургамлын хөнөөлт организм дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүнийг удирдах нөхцөл, журам, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх” шалгуураар шалгахад “Зорилгод хүрсэн байдал” хэсэгчлэн биеэлсэн гэж дүгнэв.

Санал, зөвлөмж:

Хуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах байгууллагын чиг үүргийн тогтоосон 5 ба 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “эрх зүйн орчин бүрдсэн” байна гэсэн “томьёоллоор “Зорилгод хүрсэн байдал” болон “Практикт нийцсэн байдал”-ыг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Ургамлын хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд тухайн бүс нутаг эсхүл тухайн нутаг дэвсгэрт хорио цээр тогтоох, цуцлах эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох:
 - 1.1. Энэ эрхийг Засгийн газарт эсхүл Үндэсний ургамал хамгааллын байгууллагад олгохоор хуульчлах,
 - 1.2. Харин тухайн шатын Засаг дарга хорио цээр тогтоох, цуцлахаар хуульчлах бол Үндэсний ургамал хамгааллын байгууллагад тухай бүр мэдээлэх,
 - 1.3. Тухайн шатны гэснийг тодорхой тусгаж өгөх,
2. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг хуульчлах,

2.1.3.а.Хуулийн 7 болон 14 дүгээр зүйлийн “Практикт нийцсэн байдал”-ыг үнэлсэн байдал

Ургамал хамгааллын тухай хуулийн 7 ба 14 дүгээр зүйлд хөнөөлт организм илэрсэн тохиолдолд ургамлын хорио цээр тогтоох байгууллага, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул “Ургамлын хөнөөлт организм дэгдсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүнийг удирдах нөхцөл, журам, үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байх” гэх шалгуур үзүүлэлтээр “Практикт нийцсэн байдал”-ыг үнэлэв.

Судалсан байдал

Хуульд заасны дагуу Засгийн газар, тухайн шатны Засаг дарга хорио цээрийг тогтоохоор байгаа, гэхдээ цуцлах эрхийг Засгийн газарт олгосон боловч Засаг даргад энэ эрх олгогдоогүй байна. Харин хуулиар эрх олгогдсоны дагуу Засгийн газраас баталсан “Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт баримтлах журам”-д Засаг дарга тухайн нутаг дэвсгэртэй хорио цээр тогтоож цуцална гэжээ. Түүнээс гадна хуульд тухайн шатны Засаг дарга гэсэн байгаа нь аймаг, нийслэл, сум, дүүргийнхээс гадна баг, дүүргийн Засаг даргад хамаарахаар ойлгогдож байгаа. Харин журамд зөвхөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамлын хөнөөлт организм харьяалах нутаг дэвсгэртээ хорио цээр тогтоож, цуцлахаар хязгаарласан байгаа нь мөн л хуулийн холбогдох заалтаас давсан байдал ажиглагдаж байна.

Мөн хуульд тайлагнахтай холбоотой асуудал орхигдсон, түүнчлэн журамд хуулиар хориглоогүй үйл ажиллагаануудыг оруулсан.

Хуулийн 16 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэхээр тусгасан. Тухайлбал, улсын төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлэх юм.

- 16.2.2.бэлчээрийн ургамалд ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан тархаж, хөнөөл учруулах үед түүнтэй тэмцэх зардал;
- 16.2.3.ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархаж, хөнөөл учруулж болзошгүй үед түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зардал.

Журмын 4.6-д хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, хүн хүч, техник хэрэгсэл, материалын тооцоог холбогдох байгууллагатай хамтран боловсруулж шийдвэрлүүлэхээр тусгасан.Түүнчлэн, Гамшгаас хамгаалах тухай²⁹ хуульд аюулт үзэгдэлд хортон шавж, мэрэгч тархахыг оруулж томъёолсон байгаа ба энэ тохиолдолд авах арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын тусгай сангийн тухай³⁰ хуулиар зохицуулсан. Санхүүжилттэй холбоотой эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн байгаа ч хорио цээр тогтоосон үед хэрэглэх санхүүжилтийг тодорхой заагаагүй байна.

Харин 2019 онд батлагдсан ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмын 2.2.7-т гадаад, дотоод хорио цээр тогтоох, хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байгаа ба энэ нь хуулийн болон хорио цээрийн үед баримтлах журмын холбогдох заалтуудтай зөрчилдөж байна. Харин хорио цээрийн үеийн санхүүжилт бүрхэг туссан ба санхүүжүүлэх журмын Ургамал хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэх гэсэн бүлэгт ХХААХҮЯ нь ургамал хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэх асуудлыг холбогдох ургамал хамгааллын эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл болон орон нутгийн саналыг үндэслэн Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан байгаа ба хорио цээрийн үеийн санхүүжилтэд гэж тодорхой заагаагүй байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад ургамлын хорио цээр тогтоосон тохиолдол гараагүй, харьцангуй тайван байна. Гэсэн хэдий ч дээрх нөхцөл байдлаас харахад хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учрах магадлалтай байна. Өөрөөр хэлбэл, хуулийн 7 ба 14 дүгээр зүйлүүдээр зохицуулсан харилцааны “Практикт нийцсэн байдал” хэсэгчлэн хангагдсан байна.

Санал, зөвлөмж:

Хуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах байгууллагын чиг үүргийн тогтоосон 5 ба 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “эрх зүйн орчин бүрдсэн” байна гэсэн “томъёоллоор “Практикт нийцсэн байдал”-ыг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Хорио цээр тогтоох талаарх журмын зохицуулалтыг хуульд нийцүүлэх,

²⁹ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12458>

³⁰ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019, <https://legalinfo.mn/mn/detail/14848>

- Хуулиас давсан зохицуулалтыг журмаар зохицуулахгүй байх тал дээр анхаарах,
- Хорио цээр тогтоосон үеийн санхүүжилтийн асуудлыг хуульд тодорхой тусгах, энэ талаарх холбогдох бусад хуулиудыг судалж, уялдаа холбоог хангах.

2.1.4.Хуулийн 15 дугаар зүйлийн “Зорилгод хүрсэн байдал” болон “Практикт нийцсэн байдал”-ын үнэлгээ

4	<p>15 дугаар зүйл.Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт</p> <p>15.1.Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2, 10.1-д заасан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.</p> <p>15.2.Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.2.1.ургамал хамгааллын үйл ажиллагааны талаархи стандарт, технологийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>15.2.2.ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх;</p> <p>15.2.3.ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;</p> <p>15.2.4.таримал ургамлын үр, суулгац, ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх явцад хяналт тавих.</p>	<p>Ургамлын хөнөөлт организм улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх.</p>
---	---	--

2.1.4.а.Хуулийн 15 дугаар зүйлийн “Зорилгод хүрсэн байдал” –ын үнэлгээ

Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул “Ургамлын хөнөөлт организм улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх” гэх шалгуур үзүүлэлтээр “Зорилгод хүрсэн байдал”-ыг үнэлэв.

Судалсан байдал

Хуулийн 15.1-д “Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2, 10.1-д заасан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ” гэсэн ба Төрийн хяналт шалгалтын тухай³¹ хуулийн 9.2.Мэргэжлийн хяналтын байгууллага нь мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ, 1.0.1.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутгийн байгууллагад бүсийн улсын ахлах байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана гэж заасан. Хуулийн 15.2-т ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих байцаагчийн чиг үүргийг тусгасан байна.³²

Харин нь УХОУК-иор тодорхойлсон байцаагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу экспорт, импорттой холбогдсон хэрэгжүүлэх үйл ажиллагааг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд ургамал хамгааллын байцаагчийн чиг үүргийг тогтоосон байдаг. Мөн ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох; ургамал экспортлох, импортлох нөхцөл; дамжин өнгөрөх нөхцөл, журам; ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн нэвтрүүлэх боомт; ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний ачааг шалгах журмыг тогтоосон.

Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хяналт шалгалт, экспорт, импорт, гэрчилгээ олгох асуудлыг Мэргэжлийн хяналтын байгууллага, түүний байцаагчид хариуцан гүйцэтгэдэг. Байцаагчийг мэргэжлийн хяналтын дарга томилдог. Харин Ургамал хамгааллын тухай хуулиар олгогдсон ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах талаарх холбогдох яаманд харъяалалгүй бөгөөд хяналтын байгууллага, түүний байцаагчид яаманд тайлагнах үүргийг хуулиар зохицуулаагүй. Энэ байдал нь өнөөдрийн эрх зүйн орчинд Үндэсний ургамал хамгааллын байгууллагыг тусгайлан зааж, түүнд ОУУХК-ийн дагуу гүйцэтгэх бүх чиг үүргийг оноосон зохицуулалтгүй байгаатай холбоотой.

Өөрөөр хэлбэл, Монгол Улс нь ургамал хамгааллын Үндэсний байгууллага байгуулаагүй бөгөөд түүний гүйцэтгэх чиг үүргийг бие биенээс хараат бус дөрвөн өөр төрийн байгууллага гүйцэтгэж байна гэж дүгнэж байна. Түүнчлэн, Ургамал хамгааллын тухай хуулийг 2007 онд баталсан, харин ОУУХК-д 2008 онд нэгдэж орсон байна. ОУУХК-ийг соёрхон баталсантай холбоотойгоор Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй. Мөн Ургамал хамгааллын тухай хуулийг батлагдахаас өмнө буюу 2002 онд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлсэн ч энэ хуулийн холбогдох заалтууд, ялангуяа хилийн хорио цээр, хяналт шалгалттай холбоотой зүйл, заалтуудыг Ургамал хамгааллын тухай хуулийн холбогдох хэсэгт ишлээгүй, хууль тогтоомж хэсэгт нэр дурдаж оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, хууль хоорондын уялдаа холбоог хангаагүй орхигдуулжээ.

³¹ Төрийн хяналт шалгалтын тухай, 2003, <https://legalinfo.mn/mn/detail/500>

³² Ургамал хамгааллын тухай хууль:

15.2.1. ургамал хамгааллын үйл ажиллагааны талаархи стандарт, технологийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангуулах;

15.2.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх;

15.2.3. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавьж, мэргэж амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;

15.2.4. таримал ургамлын үр, суулгац, ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх явцад хяналт тавих.

Иймээс Хуулийн 15 дугаар зүйл буюу ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбогдсон зохицуулалтыг “Ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх” шалгуураар үнэлэхэд “ЗОРИЛГОДОО ХҮРЭЭГҮЙ” гэж дүгнэв.

2.1.4.6.Хуулийн 15 дугаар зүйлийн “Практикт нийцсэн байдал” –ын үнэлгээ

Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг дээрх хүснэгтэд заасны дагуу тодорхойлсон тул “Ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх” гэх шалгуур үзүүлэлтээр “Практикт нийцсэн байдал”-ыг үнэлэв.

Судалсан байдал

Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан, ургамал хамгааллын салбарт хоёр хууль үйлчилж байгаа. Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлээр тодорхойлсон байцаагчийн чиг үүрэг нь ургамлын хөнөөлт организм улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоохтой төдийлөн холбогдохгүй байгаа ба зөвхөн ургамал, таримал ургамлын үр, суулгац ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх, ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах чиг үүргийг хуульчилсан. Эдгээр чиг үүрэг нь зөвхөн улс орны дотоодод хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Харин ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, хяналт тавихтай холбогдсон чиг үүрэг нь өөр хуулиар³³ зохицуулагдаж байгаа. Ургамал хамгааллын тухай хуульд хамрах хүрээг тусгаагүй, хууль тогтоомж хэсгийг ерөнхий хуульчилсан. Харин Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль хэдийгээр 2002 онд буюу Ургамал хамгааллын тухай хуулиас өмнө батлагдсан.

Энэ хуулийн хууль тогтоомж хэсэгт холбогдох хуулиудыг нэр зааж оруулсан боловч Ургамал хамгааллын тухай хууль 2007 онд батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулаагүй тул уг хуулийг заагаагүй байна. Энэ байдлуудаас харахад эдгээр 2 хууль салангид үйл ажиллагааг зохицуулсан мэт харагдаж байна. Монгол Улсын олон улсын гэрээ болох ОУУХК нь хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлд заасан үндсэн үүрэг хүлээх албан ёсны ургамал хамгаалал, хорио цээрийн үндэсний байгууллагыг өөрсдийн боломжийн хэрээр үүсгэн байгуулах шаардлага тогтоосон³⁴ ба үүнийг гишүүн орнууд биелүүлэх үүрэгтэй. Энэ ажил хийгдээгүйгээс дээрх хуулиудын хооронд давхардал, хийдэл, зөрчил үүсчээ.

Түүнээс гадна ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, хяналт тавих чиг үүрэг бүхий байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллагад харъяалагдаж байгаа өнөөгийн тогтолцоо бас энэ байдалд нөлөөлжээ. Иймээс хууль хоорондын уялдаа холбоог хангах, холбогдох олон улсын гэрээнд нийцүүлэх асуудал нь өнөөдрийн тулгамдсан асуудал болж байгаа нь харагдаж байна.

³³ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль (2002)

³⁴ Зүйл IV 1,2, ОУУХК

Ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо нь өөр хуулиар буюу Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар бүрдсэнийг онцлох нь зүйтэй. Гэхдээ хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, ургамал хамгааллын талаарх нэгдсэн ойлголтыг оролцогч талуудад өгөх зэрэг дээр үл ойлголцол үүсэх, хуулийг буруу хэрэглэх, нэгдсэн ойлголт дутмаг байдаг тал ургамал хамгааллын салбарын эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд, тариаланчидтай хийсэн уулзалт, хэлэлцүүлгээс ажиглагддаг.

Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбоотой зохицуулалтыг “Ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх” гэх шалгуур үзүүлэлтээр үнэлсэн ба “Практикт нийцээгүй” гэж үнэлэв.

Санал, зөвлөмж:

Хуулийн Хуулийн 15 дугаар зүйл буюу ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбогдсон зохицуулалтыг “Ургамлын хөнөөлт организм илрэх, улсын хилээр нэвтрэх, тархахаас сэргийлэх, илэрсэн тохиолдолд таслан зогсоох, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоо бүрдсэн байх” байна гэсэн шалгуураар “Зорилгод хүрсэн байдал” болон “Практикт нийцсэн байдал”-ыг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Ургамал хамгааллын тухай хуулийн ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбогдсон зохицуулалтыг 2008 онд Монгол Улсын нэгдэн орсон ОУУХК-д нийцүүлэх,
- Ургамал хамгааллын тухай хууль болон Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн уялдаа холбоог хангах, холбогдох зүйл, заалтад ишлэл авах,
- Ургамал хамгааллын тухай хуулийн хууль тогтоомж хэсгийг эргэж харах.
- Ургамал хамгааллын тухай болон Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиудын уялдаа холбоог хангах.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

1. Ургамал хамгаалал гэсэн нэр томъёоны тайлбарыг Монгол Улсын холбогдох стандартад нийцүүлэх шинэчлэх. Гэхдээ УХОУК-ийн нэр томъёоны стандартад ургамал хамгаалал гэсэн нэр томъёо байхгүй байгааг анхаарах,
2. Дээрхтэй холбогдуулан уг хуулийн ургамал хамгаалалтай холбогдсон зохицуулалтууд болон хуулийг дагаж гарсан дүрэм, журам зааврыг шинэчлэх,
3. Монгол Улсын олон улсын гэрээний гишүүн орны хувьд Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ³⁵ гэж Монгол Улсын

³⁵ Монгол Улсын Үндсэн хууль 10.2 болон 10.3 зүйл. (1992)

- Үндсэн хуульд заасны дагуу үндэсний ургамал хамгааллын байгууллагыг тодорхойлж хуульчлах, түүний үндсэн чиг үүргүүдийг тусгах,
4. Ургамлын хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд тухайн бүс нутаг эсхүл тухайн нутаг дэвсгэрт хорио цээр тогтоох, цуцлах эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох:
 - а. Энэ эрхийг Засгийн газарт эсхүл Үндэсний ургамал хамгааллын байгууллагад олгохоор хуульчлах,
 - б. Харин тухайн шатын Засаг дарга хорио цээр тогтоох, цуцлахаар хуульчлах бол Үндэсний ургамал хамгааллын байгууллагад тухай бүр мэдээлэх,
 - с. Тухайн шатны гэснийг тодорхой тусгаж өгөх,
 5. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг хуульчлах,
 6. Хорио цээр тогтоох талаарх журмын зохицуулалтыг хуульд нийцүүлэх,
 7. Хуулиас давсан зохицуулалтыг журмаар зохицуулахгүй байх тал дээр анхаарах,
 8. Хорио цээр тогтоосон үеийн санхүүжилтийн асуудлыг хуульд тодорхой тусгах, энэ талаарх холбогдох бусад хуулиудыг судалж, уялдаа холбоог хангах,
 9. Ургамал хамгааллын тухай хуулийн ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналттай холбогдсон зохицуулалтыг 2008 онд Монгол Улсын нэгдэн орсон ОУУХК-д нийцүүлэх,
 10. Ургамал хамгааллын тухай хууль болон Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн уялдаа холбоог хангах, холбогдох зүйл, заалтад ишлэл авах,
 11. Ургамал хамгааллын тухай хуулийн “хууль тогтоомж” хэсгийг эргэж харж, холбогдох гол гол хуулиудыг нэр зааж оруулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол Улсын болон олон улсын дараахь баримт бичиг, хууль тогтоомжийг судалсан болно:

- Монгол Улсын Үндсэн хууль 1992
- Ургамал хамгааллын тухай хууль 2007
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль 2002
- Төрийн хяналт шалгалтын тухай 2003
- Ойн тухай хууль 2012
- Байгалийн ургамлын тухай хууль 1995
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2019
- Гамшгаас хамгаалах тухай хууль 2017
- Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны 190 тогтоолоор баталсан “Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам”
- ХХАА-н сайдын 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн №А 90 дугаар тушаалаар баталсан “Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч амьтдын нэрсийн жагсаалт”

- ХХАА-н сайд, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №А500/283 хамтарсан тушаалаар баталсан “Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам”
- Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт, MNS 3471:2003
- Ургамлын хорио цээр. Нэр томъёо, тодорхойлолт, MNS 3475:2003
- Ургамал хамгааллын тухай олон улсын конвенци, 2007
- Ургамлын эрүүл ахуйн тухай үндэсний хууль тогтоомжийг шинэчлэн найруулах заавар 2007, НҮБ-ын ХХААБ
- Ургамал хамгааллын нэр томъёоны тайлбар, ISPM 5 International standards for phytosanitary measures 5
- Дэлхийн анхны ургамлын эрүүл мэндийн олон улсын бага хуралд Их Британийн Ургамлын эрүүл мэндийн ахлах ажилтан Никола Спенсийн хэлсэн үг, 2022
- Монгол Улсын ургамал хамгааллын тухай хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2021
- Report on the evaluation of the capacity building in strengthening agriculture quarantine services in Mongolia, 2016

УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ,
ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГИЙГ СОНГОСОН
БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-д шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино. Энэхүү үнэлгээг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах; хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 3.Ойлгомжтой байдал
- 4.Зардал
- 5.Харилцан уялдаа зэрэг болно.

2.1.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох, хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц байна уу гэдгийг тогтоох зорилгоор сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хувьд уг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл биш учраас уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох зорилготой байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтад Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх, үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа зохицуулалтыг сонгож авсан.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь нэмэлт зардал үүсгэх эсэх тайланг Зардлын тооцооны тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судална.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн зорилтыг “ Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.” гэж тодорхойлсон бөгөөд энэхүү зорилтыг хангах зорилгоор тусгагдсан зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал, дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
1	Ургамлын эрүүл мэндийг хамгаалах	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйл бүхэлдээ, 23, 24, 25, 26, 27,

		28, 29, 30 дугаар зүйл бүхэлдээ
2	ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.13, 4.1.14, 4.1.15, 4.2, 8 дугаар зүйлийн 8.2.14, 8.2.16, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт
3	худалдааг дэмжих	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 болон хууль бүхэлдээ
4	мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 35 дугаар зүйлийн 35.2, 38 дугаар зүйлийн 38.1, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалт

3.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

"Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 7 бүлэг, 42 зүйлтэй/

3.3. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг шалгав.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
1	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны мэдээллийн санг бүрдүүлэх, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.23, 8 дугаар зүйлийн 8.2.9, 12 дугаар зүйлийн 12.2.3, 13 дугаар зүйлийн 13.1.3, 17 дугаар зүйлийн 17.3, 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйл бүхэлдээ, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйл бүхэлдээ, 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн ...	Зорилгод дүн шинжилгээ хийх
	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль

			болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах
	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9, 12 дугаар зүйлийн 12.2.3, 13 дугаар зүйлийн 13.1.3, 17 дугаар зүйлийн 17.3, 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйл бүхэлдээ, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйл бүхэлдээ, 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд холбогдох байгууллагуудаас бичгээр санал авч, төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх асуудлаар хуулийн төслийн холбогдох заалтуудыг шалгах
	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Ургамлын эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйл бүхэлдээ, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30 дугаар зүйл, заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 4.1.3. "ургамлын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа" гэж ургамлыг хөнөөлт организмд өртөхөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн хөнөөлт организмтай тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааг, 5 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчим, 5.1.1. шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, 5.1.2. хөнөөлт организмын эрсдлийн шинжилгээнд суурилсан байх, 5.1.3. хүн, амьтан, хүрээлэн буй орчинд хамгийн бага эрсдэлтэй тэмцэх аргыг хэрэглэж, химийн пестицидийн хэрэглээг бууруулах, 5.1.4. мэдээлэл солилцох болон ил тод, ил ялгаварлах байдлыг хангах, 5.1.5. ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдааны хориг саадыг арилгахад чиглэх гэж тодорхойлсон. Мөн хуулийн төслийн Тавдугаар бүлгээр Ургамлын эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний хүрээнд 23 дугаар зүйл. Хөнөөлт организм, 23.1. Энэ хуулийн 8.2.10, 16.1, 19.1-д заасан судалгаа, зураглал, шинжилгээ болон олон улсын байгууллага, гадаад оронд гаргасан хөнөөлт организмын жагсаалт, судалгааг харгалзан хорио цээртэй

болон зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалтыг ургамал хамгааллын үндэсний байгууллага батална, 23.2. Эрдэм шинжилгээний байгууллага энэ хуулийн 25.1-д заасан жагсаалтад орсон хөнөөлт организмтэй тэмцэх арга хэмжээний зааврыг хөнөөлт организмын зүйл тус бүрээр боловсруулна, 24, 25 дугаар зүйлээр импорт, экспорт, ре-экспорт, дамжин өнгөрөх асуудлыг Ургамал түүний гаралтай бүтээгдэхүүний импортыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулахаар тусгасан. Харин 26 дугаар зүйлээр Ургамлын хорио цээр тогтоох үйл ажиллагааг тухайлбал, 26.1.хорио цээртэй хөнөөлт организм илэрвэл Ургамал хамгааллын үндэсний байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар ургамлын хорио цээр тогтооно, 26.2.хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн үед доор дурдсан албан тушаалтан, байгууллага голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоож, цуцална, 26.2.1. хорио цээртэй хөнөөлт организмын тархалт нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл хөнөөлт организмын голомтыг нэгтгэх нөхцөл үүсээгүй бол тухайн орон нутгийн хяналтын байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, 26.2.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан бол тухайн орон нутгийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, 26.2.3.хөнөөлт организмын тархалт төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол хяналтын байгууллагын дүгнэлт, ургамал хамгааллын үндэсний байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар. 26.3.энэ хуулийн 26.1-д заасан хорио цээр тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг мөрдөнө, 27 дугаар зүйл.Ургамлын хорио цээрийг сунгах, цуцлах, 27.1.Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан холбогдох хяналтын байгууллага, ургамал хамгааллын үндэсний байгууллага хорио цээрийн хугацааг сунгах, эсхүл хугацаанаас өмнө болон хугацаа дууссан нөхцөлд цуцлах тухай дүгнэлт, саналыг хорио цээр тогтоосон байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ, 27.2.Холбогдох шатны засаг дарга тухайн нутаг дэвсгэрт хорио цээр тогтоосон, сунгасан, цуцалсан тухай шийдвэрээ ургамал хамгааллын үндэсний байгууллагад мэдэгдэж, нийтэд зарлан мэдээлнэ, 27.3. Засгийн газрын шийдвэрээр хорио цээр тогтоосон, сунгасан, цуцалсан бол Ургамал хамгааллын үндэсний байгууллага нийтэд зарлан мэдээлнэ, 28 дугаар зүйл.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тавигдах шаардлага, 28.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрлөөс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, уг бүсэд гаднаас орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг тавьж, харуул хамгаалалт ажиллуулна, 28.2.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах болон дамжин өнгөрүүлэх зурвас дээр шалган нэвтрүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх цэгийг байгуулж, хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах ажлыг сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна, 28.3.Энэ хуулийн 28.2-т заасан цэгт хяналтын байгууллагын хяналтын дор ургамал хамгааллын мэргэжлийн байгууллага ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийнэ, 29 дүгээр зүйл.Хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ, 29.1.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт Ургамал хамгааллын үндэсний байгууллага тухайн шатны Засаг даргатай хамтран дараах арга хэмжээг зохион байгуулна, 29.1.1.зохицуулалттай хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах, 29.1.2.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, зохицуулалттай хорио цээртэй хөнөөлт организм байгаа байгууламжид ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, 29.2.Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах зардлыг энэ хуулийн 26.2.1, 26.2.2-д заасан тухайн шатны Засаг дарга, 26.2.3-д зааснаар хорио цээр тогтоох тохиолдолд Засгийн газар тус тус шийдвэрлэнэ, 30 дугаар зүйл.Ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх, 30.1.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа мэргэжлийн байгууллага нь хөнөөлт организмын төрөлд тохируулан

ургамал хамгааллын үндэсний байгууллагын баталсан удирдамжийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийнэ, 30.2.Ариутгал, халдваргүйжүүлэлт, хөнөөлт организмын голомтыг устгах үйл ажиллагааг голомт бүхий талбай, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, агуулах, зоорь, хүлэмж, ил талбай, үтрэм, бусад зориулалтын хэрэгсэл, голомтод орсон хүний хувцас, хэрэгсэл, бусад эд зүйлсэд хийнэ гэж тус тус тодорхойлсон нь ургамлын эрүүл мэндийг хамгаалах зорилтыг бүрэн хангаж байна.

Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилтын хүрээнд хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.13, 4.1.14, 4.1.15, 4.2, 8 дугаар зүйлийн 8.2.14, 8.2.16, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 4.1.7.“ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж зохицуулалттай эд материалд хөнөөлт организм, химийн пестицид, бордооны үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг шалган тогтоох үйл ажиллагааг, 4.1.13.“ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ” гэж хөнөөлт организм нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль, тогтоомж, ургамал хамгаалах арга хэмжээг, 4.1.14.“зохицуулалттай эд материал” гэж хөнөөлт организмыг тээх, эсхүл дамжин тархах нөхцөл бүрдүүлэх боломжтой ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийг хадгалах, агуулах, тээвэрлэх сав, баглаа боодол, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, хүн, хөрс, өөр бусад организм зэрэг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах шаардлагатай бүх төрлийн эд, материалыг, 4.1.15.“хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ” гэж тухайн илэрсэн организмыг биологи болон бусад шинжлэх ухааны судалгаа, эдийн засгийн нотолгоонд үндэслэн үнэлэх замаар хөнөөлтэй эсэх, зохицуулагдах эсэх, түүний эсрэг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлох үйл явцыг, 4.2.Энэ хуульд ашигласан нэр томъёог Ургамал хамгааллын олон улсын конвенци болон Ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандартад зааснаар ойлгоно, 8.2.14.ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тариалах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх, 8.2.16.зохицуулалттай эд, материалыг экспортлохийн өмнө ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох, 13.1.2. зохицуулалттай эд материалд ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, итгэмжлэгдсэн лабораторид ургамлын эрүүл ахуй, хорио цээр, пестицид болон нитратын үлдэгдлийг шинжлүүлэх, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд шинжилгээний дүнг үндэслэн дүгнэлт гаргах баталгаажуулах гэж ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагын талаар тодорхой тусгаж өгсөн нь ургамлын эрүүл ахуйг хангуулах суурь харилцааны үндсийг тодорхойлох зорилгод бүрэн нийцэж байна.

Худалдааг дэмжих зорилтын хүрээнд хуулийн төслийн холбогдох заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Өмнө дурдсанчлан хуулийн төслийн зорилтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино гэж тодорхойлсон бөгөөд худалдааг дэмжих дэд зорилтыг хангахад хуулийн төсөл бүхэлдээ чухал үүрэгтэй байна. Учир нь байгаль цаг уурын өөрчлөлт, болон хүний үйл ажиллагаанууд нь экосистемийг аль хэдийн өөрчлөлтөд оруулан

биологийн төрөл зүйлийг багасган, ургамлын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хөнөөлт организмыг оршин тогтноулах шинэ орчинг бий болгож байна. Үүний зэрэгцээ сүүлийн арван жилд олон улсын худалдаа, аялал жуулчлал хурдацтай хөгжихийн хэрээр дэлхийн улс орнуудад ургамлын хортон шавж, хог ургамал, өвчин маш хурдан тархаж, таримал болон байгалийн ургамалд эрсдэл учруулах өндөр магадлалтай болжээ. Энэ нь хүнсний хангамж, аюулгүй байдал болон байгаль орчинд асар их хохирол учруулж болзошгүй бөгөөд улмаар улс орны худалдаа, эдийн засагт нөлөөлдөг. НҮБ-ын ХХААБ-гаас дэлхий нийт жил бүрийн тариалангийн ургацынхаа 40 хувийг ургамлын өвчин, хортоноос болж алддаг гэсэн тооцоог гаргажээ. Цаашид энэ маягаар ургацаа алдаад байвал хүнсний хангамж багасан, тариаланчдын орлого, амжиргаа буурах, экосистемд сөргөөр нөлөөлнө гэдэг нь тодорхой. Тиймээс улс орнууд ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хорио цээр, эрүүл ахуйн хууль тогтоомж, тогтолцоогоо сайжруулах замаар ургамлын өвчин, хортон нутаг дэвсгэртээ орж ирэх, нэвтрэх, тархахаас сэргийлэхэд ихээхэн анхаарч байна.

Мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 35 дугаар зүйлийн 35.2, 38 дугаар зүйлийн 38.1, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтад дүн шинжилгээ хийсэн байдал.

Хуулийн төслийн 35.2. Тариалан, эсхүл ашиглалтаас хүн, мал, амьтны эрүүл мэнд, эсхүл гүний усанд ямар нэг хор хохиролтой, эсхүл байгаль экосистемд хүлээн зөвшөөрөх боломжгүй сөрөг нөлөө үүснэ гэж хэрэглэгч мэдэгдсэн тохиолдолд тухайн үр, суулгац, эсхүл ургалтын субстратыг тариалах, ашиглахыг хориглоно, 38.1. Ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээнээс хүн, мал, амьтны эрүүл мэнд, эсхүл байгалийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үүснэ гэж мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага тогтоосон бол тухайн ургамал хамгааллын бодисыг хэрэглэхийг хориглоно, 39.1. Ургамал хамгааллын бэлдмэл хэрэглэхэд зөвшөөрөлд заасан заавар, нөхцлөөр нь зохистой ашиглах үед ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээнээс хүн, мал, амьтны эрүүл мэнд, гүний ус, байгаль орчинд ээлтэй байх нөхцлийг хангасан ургамал хамгааллын техник, тоног төхөөрөмж ашиглана гэж тус тус тусгасан нь Мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилтод нийцэж байна.

4.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9, 12 дугаар зүйлийн 12.2.3, 13 дугаар зүйлийн 13.1.3, 17 дугаар зүйлийн 17.3, 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйл бүхэлдээ, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйл бүхэлдээ, 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалтад шинжилгээ хийсэн байдал

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөхдөө холбогдох хуулийг дагаж мөрддөг. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 5 дугаар зүйлийн 5.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх гэж заасан бөгөөд хуулийн төслийн 8.2.9.хөнөөлт организмын цахим мэдээллийн санг бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангах, 12.2.3.лабораторийн сорилт, шинжилгээний дүнг мэдээллийн санд тухай бүр оруулах, 13.1.3. энэ хуулийн 13.1.2-т заасан шинжилгээний дүнгээр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, байгаль орчинд хор хөнөөл учруулах нь тогтоогдсон тохиолдолд

шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх, 17.3.Ерөнхий тандан судалгааны дүн, мэдээг мэдээллийн санд оруулна, 18.4. Тусгайлсан тандан судалгааны дүн, мэдээг эрх бүхий байгууллагад хүргүүлж судалгаа хийж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор мэдээллийн санд оруулна, 19.1.Тандан судалгааг хөнөөлт организмын төрөл, зүйл, тоо, гаралт, тархалтын хүрээ, давтамж, ургамалд учруулах хөнөөлөөр бүлэглэн гаргаж мэдээллийн санд оруулж, тархалтын зураглалыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээнд гаргана, 21.1.Ургамал хамгааллын үндэсний байгууллагын захиалгаар гоц хөнөөлтэй зүйлийн урт болон богино хугацааны гаралт, тархалтын урьдчилсан мэдээллийн судалгааг эрдэм шинжилгээний байгууллага гүйцэтгэнэ, 22 дугаар зүйл.Хөнөөлт организмын мэдээллийн сан, 22.1.Ургамал хамгааллын үндэсний байгууллага хөнөөлт организмын мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/ бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана, 22.2.Мэдээллийн сан нь дараах хэсгээс бүрдэнэ: 22.2.1.бэлчээр, ой, ногоон байгууламж болон таримал ургамлын хөнөөлт организм, 22.2.2.лабораторийн сорилт, шинжилгээ, 22.3.Мэдээллийн санд ургамлын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон холбогдох бусад этгээд мэдээлэл оруулах, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлсэн байна, 22.4.Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах тухай журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална, 22.5.Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь нийтэд нээлттэй байна, 22.6.Ургамал хамгааллын үндэсний байгууллага нь хөнөөлт организмын талаар статистик мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан цахим хуудастаа байршуулж, Засгийн газарт мөн хугацаанд хүргүүлнэ, 36.1.Энэ хуулийн 34.2-д заасан гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээд химийн пестицидийг өөрийн аж ахуйд хэрэглэсэн бол тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн цахим санд бүртгүүлэх үүрэгтэй. 37 дугаар зүйл. Ханган нийлүүлэгч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, импортлогчдын бүртгэх, мэдээлэх үүрэг, 37.1.Ургамал хамгааллын бэлдмэлийн ханган нийлүүлэгчид, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, импортлогчид зах зээлд гаргасан, нийлүүлсэн, эсхүл импортолсон ургамал хамгааллын бэлдмэлийн бүртгэлийг тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн цахим санд, эсхүл бичгээр хөтөлж, бүртгэл бүрийг 5-аас цөөнгүй жил хадгална, 40.2.5.хөнөөлт организмын мэдээллийн санг байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг хангах зардал гэж тус тус заасан нь хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

4.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд холбогдох 14 байгууллагаас тусгайлан санал ирээгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийлтэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай

уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тэдгээр зорилтуудад хүрэх шууд утга бүхий заалтуудыг нэмэлтээр оруулсан тул зорилтдоо хүрсэн гэж үзлээ.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	<p>Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд:</p> <p>4.1.1.“ургамал хамгаалал” гэж ургамлын нөөцийг хамгаалах зорилгоор хөнөөлт организмыг илрүүлэх, гаралт, тархалтыг хязгаарлах, тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааг, 4.1.2.“ургамлын хорио цээр” гэж хорио цээртэй болон харь төрөл зүйл нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэх, хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг, 4.1.3.“ургамлын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа” гэж ургамлыг хөнөөлт организмд өртөхөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн хөнөөлт организмтай тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааг, 4.1.4.“ургамал хамгаалах цогц арга” гэж тариалангийн талбайд хөнөөлт организмын популяцийн хэмжээг хөнөөл учруулахаас доогуур түвшинд барих биологи, физик-механик, ургамлын селекци, агротехнологийн аргуудыг хослуулан ашиглах замаар химийн пестицидийн хэрэглээг бууруулахад чиглэгдсэн цогц аргыг, 4.1.5.“ургамал” гэж амьд ургамал, түүний үр, суулгац, үр хөврөл, бусад эд эрхтэнг, 4.1.6.“ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж тухайн байгаа хэлбэрээрээ, эсхүл шинж чанар, боловсруулалтаас хамаарч хөнөөлт организм нэвтрэх, тархах эрсдэлийг үүсгэж болзошгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг, 4.1.7.“ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж зохицуулалттай эд материалд хөнөөлт организм, химийн пестицид, бордооны үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг шалган тогтоох үйл ажиллагааг, 4.1.8.“хөнөөлт организм” гэж ургамал,</p>

ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны зүйл, омог, биотип, өвчин үүсгэгч организмыг, 4.1.9."зохицуулалттай хөнөөлт организм" гэж хорио цээртэй болон зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмыг, 4.1.10."зохицуулалттай" гэж тухайн хөнөөлт организмтай тэмцэх арга нь албан ёсоор тогтоогдсон байхыг, 4.1.11."хорио цээртэй хөнөөлт организм" гэж аюулд өртөж болзошгүй газар нутагт одоогоор илрээгүй, эсвэл илэрсэн ч өргөн тархаагүй, энэ хуулийн 17.1-д заасны дагуу албан ёсны хяналтад байгаа эдийн засгийн хохиролд хүргэхүйц хөнөөлт организмыг, 4.1.12."зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм" гэж тариалах зориулалттай ургамалд илэрч зориулалтын дагуу ашиглахад эдийн засгийн хохиролд хүргэхүйц улмаар импортлогч орны нутаг дэвсгэрт зохицуулагдсан хорио цээргүй хөнөөлт организмыг, 4.1.13."ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ" гэж хөнөөлт организм нэвтрэх, тархахаас урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль, тогтоомж, ургамал хамгаалах арга хэмжээг, 4.1.14."зохицуулалттай эд материал" гэж хөнөөлт организмыг тээх, эсхүл дамжин тархах нөхцөл бүрдүүлэх боломжтой ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийг хадгалах, агуулах, тээвэрлэх сав, баглаа боодол, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, хүн, хөрс, өөр бусад организм зэрэг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах шаардлагатай бүх төрлийн эд, материалыг, 4.1.15."хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ" гэж тухайн илэрсэн организмыг биологи болон бусад шинжлэх ухааны судалгаа, эдийн засгийн нотолгоонд үндэслэн үнэлэх замаар хөнөөлтэй эсэх, зохицуулагдах эсэх, түүний эсрэг ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг тодорхойлох үйл явцыг, 4.1.16."хөнөөлт организмын тархалт багатай газар нутаг" гэж тодорхой хөнөөлт организм бага тархсан, түүнийг үр нөлөөтэй тандан судалж, хянах, тэмцэх, устгах арга хэмжээ хэрэгжүүлдэг болохыг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон газар нутаг эсвэл зарим хэсэг нутгийг, 4.1.17."аюулд өртөж болзошгүй газар нутаг" гэж эдийн

	<p>засгийн ноцтой хохирол учруулахуйц хөнөөлт организм нутагшихад тааламжтай экологийн хүчин зүйл бүрдсэн газар нутгийг, 4.1.18. “хөнөөлт организм нэвтрэх” гэж тухайн бүс нутагт хараахан илрээгүй, илэрсэн боловч өргөн тархаагүй албан ёсоор баримтжуулагдсан хөнөөлт организмын шилжилт, хөдөлгөөнийг, 4.1.19. “хөнөөлт организм нутагших” гэж тухайн нутагт нэвтэрсэн хөнөөлт организм суурьшихыг, 4.1.20. “хөнөөлт организм суурьших” гэж тухайн нутагт нэвтэрсэн хөнөөлт организм цаашид оршин амьдрахыг, 4.1.21. “урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж хорио цээртэй хөнөөлт организм нэвтрэх, хөнөөл учруулахаас өмнө илрүүлэх, мэдээлэх, тандан судлах, гаралт, тархалт, дамжин тархах арга замыг тогтоох, голомтыг халдваргүйжүүлэх үйл ажиллагааг, 4.1.22. “тэмцэх арга хэмжээ” гэж хөнөөлт организмын хөнөөл, тархалтын хүрээг тогтоох, эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу хөнөөлийг бууруулах, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор тархалтыг хязгаарлах, голомтыг устгах зэрэг хорио цээрийн арга хэмжээг, 4.1.23. “хорио цээр тогтоох арга хэмжээ” гэж хорио цээр тогтоох, сунгах, цуцлах, зарлан мэдээлэх, хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тавигдах шаардлага, хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх үйл ажиллагааг, 4.1.24 “мэргэжлийн байгууллага” гэж Ургамал хамгааллын үндэсний байгууллагад бүртгэгдсэн ургамлын хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг, 4.2.Энэ хуульд ашигласан нэр томъёог Ургамал хамгааллын олон улсын конвенци болон Ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандартад зааснаар ойлгоно гэж тодорхойлсон нь бусад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжинд ашигласан нэр томъёонд нийцэж байна.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх</p>	<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна.</p>

Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зүйл тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл тогтоогдоогүй
Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл тогтоогдоогүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон тухай ямар нэгэн зүйл заалт тусгаагүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд 34.11. Энэ хуулийн химийн болон биологийн гаралтай бэлдмэлийг импортлох, худалдаалах зөвшөөрлийг олгохтой холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендерийн эрх тэгш байдал хөндөгдөөгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгаадаагүй.
Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаадаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ, 42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тусгасан. Уг заалттай холбоотой ямар нэгэн тодорхойгүй зүйл тогтоогдоогүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Дүгнэлт, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ. Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан байна.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас дөрвөн төрлийн зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн зорилтыг “Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.” гэж тодорхойлсон нь уг зорилтын талаарх суурь зохицуулалтуудыг хуулийн төслийн Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйл бүхэлдээ, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30 дугаар зүйл бүхэлдээ, 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.13, 4.1.14, 4.1.15, 4.2, 8 дугаар зүйлийн 8.2.14, 8.2.16, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.2, 38 дугаар зүйлийн 38.1, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтад тус тус тусгаж өгсөн нь хуулийн төслийн зорилгод нийцсэн, зорилгодоо хүрэх байдал нь эерэг байна.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага зэргийг тус тус хангасан бөгөөд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 5 дугаар зүйлийн 5.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх гэж заасан бөгөөд энэ талаар хуулийн төслийн Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.23, 8 дугаар зүйлийн 8.2.9, 12 дугаар зүйлийн 12.2.3, 13 дугаар зүйлийн 13.1.3, 17 дугаар зүйлийн 17.3, 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйл бүхэлдээ, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйл бүхэлдээ, 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалтад холбогдох үйл ажиллагааг хуульчилж өгсөн нь хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуур үзүүлэлтиг хангасан гэсэн эерэг үзүүлэлттэй байна.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэхэд эерэг байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

- 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;

Гурав. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

- 3.1.Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2.Гарах зардлыг тооцох;
- 3.3.Зардлыг нэгтгэн тооцох.

Дөрөв. Дүгнэлт санал

- 4.1 Хуулийн төсөл хэрэгжсэнээр хуулийн этгээд, иргэн, улсын болон орон нутгийн төсөвт үүсэх зардлын нэгтгэл;
 - 4.2 Дүгнэлт, санал.
-

ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4- т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”¹ /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно. Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Хуулийн төсөл дэх шинэ зохицуулалтууд нь төрд буюу улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудад зардал үүсгэхээр байна. Харин бэлчээр, тариалангийн газар эзэмшигч, ашиглагчид, тариалангийн болон хүлэмжийн аж ахуй эрхлэгч хуулийн этгээд, иргэнд зардал үүсгэхгүй. Учир нь хуулийн төсөлд тусгагдсан иргэн, хуулийн этгээдэд хамаарах зохицуулалтууд нь өмнө нь бусад хуулиар, эсхүл журмаар зохицуулагдаж байсан тул шинээр үүрэг бий болгоогүй байна. Өөрөөр хэлбэл, иргэн, хуулийн этгээдэд хуулийг хэрэгжүүлэх явцад шинээр ямар нэг зардал үүсэхгүй (хүснэгт 1 болон 2-оос харна уу) тул хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зохицуулалтуудын зардлыг тооцох шаардлагагүй гэж үзсэн. Харин хуулийн төслийн зардлын тооцоог төрийн холбогдох байгууллагын хувьд тооцож гаргасан болно.

Хүснэгт 1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага

№	Хуулийн заалт	Зохицуулж байгаа хуулийн заалт
1	31.3.Тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, зоорь, агуулахад хөнөөлт организм тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхдээ биологи, физик-механик, агротехникийн аргуудыг	Тариалангийн тухай хууль, 25.1.7.эрдэс, органик бордоо, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвшүүлэх;

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1>

	тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч хариуцан зохион байгуулна.	
2	34.2.Тариалангийн талбай, хүлэмж, зоорь, агуулах, бэлчээр, ойд хөнөөлт организмтай тэмцэхдээ химийн болон цацрагийн аргыг сонгосон тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу химийн пестицидтэй ажиллах талаарх тусгай сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна. 17.2.Энэ хуулийн 17.1-д заасан сургалт нь дараахь төрлөөр зохион байгуулагдаж болно: 17.2.1. шинээр ажилд орж байгаа иргэний сургалт; 17.2.2. өөр ажлын байранд шилжиж байгаа иргэн, ажилтны сургалт; 17.2.3. үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт. 17.3.Энэ хуулийн 17.2.3-т заасан ажлын байранд зохих сургалтад хамрагдаж, дадлага хийж, шалгалтанд тэнцсэн иргэнийг ажиллуулна.
3	34.4. Энэ хуулийн 34.2-т заасан гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээд гэрчилгээ анх олгосон өдрөөс хойш 3 жил тутамд давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 17.4.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна.
4	40.3.Тариалангийн талбай болон хүлэмжинд ургамлын хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.	Ургамал хамгааллын тухай хууль, 16.3.Тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Хүснэгт 2. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд иргэнд шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага

№	Хуулийн заалт	Тайлбар
1	31.3.Тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, зоорь, агуулахад хөнөөлт организм тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхдээ биологи, физик-механик,	Тариалангийн тухай хууль, 25.1.7.эрдэс, органик бордоо, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвшүүлэх;

	агротехникийн аргуудыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч хариуцан зохион байгуулна.	
2	34.2.Тариалангийн талбай, хүлэмж, зоорь, агуулах, бэлчээр, ойд хөнөөлт организмтай тэмцэхдээ химийн болон цацрагийн аргыг сонгосон тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу химийн пестицидтэй ажиллах талаарх тусгай сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна. 17.2.Энэ хуулийн 17.1-д заасан сургалт нь дараахь төрлөөр зохион байгуулагдаж болно: 17.2.1. шинээр ажилд орж байгаа иргэний сургалт; 17.2.2. өөр ажлын байранд шилжиж байгаа иргэн, ажилтны сургалт; 17.2.3. үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт. 17.3.Энэ хуулийн 17.2.3-т заасан ажлын байранд зохих сургалтад хамрагдаж, дадлага хийж, шалгалтанд тэнцсэн иргэнийг ажиллуулна.
3	34.4. Энэ хуулийн 34.2-т заасан гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээд гэрчилгээ анх олгосон өдрөөс хойш 3 жил тутамд давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 17.4.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна.
4	40.3.Тариалангийн талбай болон хүлэмжинд ургамлын хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.	Ургамал хамгааллын тухай хууль, 16.3.Тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

ГУРАВ. УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДАН ГАРСНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3.1. Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил, үйлчилгээ/, тухайн үүргийг ямар, ямар байгууллага гүйцэтгэх талаар тогтоосныг хүснэгт 3-аар харуулав.

Хүснэгт 3. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага

№	Хуулийн заалт	Тайлбар	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
1	7.1.5.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах;	Журам батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	8.4.Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, түүнийг бүртгэхтэй холбогдсон журмыг ургамал хамгааллын үндэсний байгууллага батална.	Журам батлах зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
3	20.2.хорио цээртэй хөнөөлт организм илрээгүй болон тархалт багатай газар нутагт тавих шаардлага, газар нутгийг тогтоох, цуцлах журмыг Олон улсын ургамал хамгааллын конвенцийн холбогдох стандартад нийцүүлэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	22.4.Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах тухай журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	32.1.Зохицуулалттай хорио цээртэй хөнөөлт организмын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлэн байдлын ерөнхий болон тусгайлсан төлөвлөгөөг боловсруулах аргачлалыг Ургамал хамгааллын үндэсний байгууллага боловсруулна.	Төлөвлөгөө батлах зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
6	34.9. Биологийн, биохимийн, ургамлын гаралтай бэлдмэл, ангуучин, шимэгч амьдралтай үе хөлтөнг турших, бүртгэх, ашиглах, импортлох, экспортлох, худалдаалахтай холбогдсон журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

7	34.10.Химийн пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөөг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Төлөвлөгөө батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8	40.4.Ургамлын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Журам батлах зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9	23.1. Энэ хуулийн 8.2.10, 16.1, 19.1-д заасан судалгаа, зураглал, шинжилгээ болон олон улсын байгууллага, гадаад оронд гаргасан хөнөөлт организмын жагсаалт, судалгааг харгалзан хорио цээртэй болон зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалтыг ургамал хамгааллын үндэсний байгууллага батална.	Жагсаалт батлах зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
10	7.1.6.гадаад орон, олон улсын холбогдох байгууллагатай ургамал хамгааллын талаар хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;	Хамтын ажиллагааны зардал	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
11	8.2.5.хөнөөлт организмын гаралт, тархалтыг дотооддоо болон гадаад орон, бүс нутгуудад харилцан мэдээлэл солилцох;	Хамтын ажиллагааны зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
12	8.2.6. ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалалтай холбоотой олон улсыг хамарсан цахим системд нэгдэх, харилцан мэдээлэл солилцох;	Хамтын ажиллагааны зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
13	8.2.7.хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ хийх;	Эрсдлийн шинжилгээ хийх	Ургамал хамгааллын үндэсний байгууллага
14	8.2.8. ургамал хамгааллын салбарын мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажилтныг сургах;	Сургалтын зардал	Эрдэм шинжилгээний байгууллага
15	8.2.9.хөнөөлт организмын цахим мэдээллийн санг бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангах;	Мэдээллийн санг бүрдүүлэх	Эрдэм шинжилгээний байгууллага
16	8.2.10. хөнөөлт организмын тандалтын судалгаа хийх;	Судалгаа хийх	Эрдэм шинжилгээний байгууллага
17	8.2.11.хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай газар нутгийг тогтоох, байнгын тандалт судалгаа хийх, хяналт тогтоох;	Судалгаа хийх	Эрдэм шинжилгээний байгууллага
18	8.2.12.харь төрөл зүйл илэрсэн тохиолдолд эрсдлийн шинжилгээнд хамруулах;	Шинжилгээ хийх	Эрдэм шинжилгээний байгууллага
19	8.2.13.аюулд өртөж болзошгүй бүс нутгийг хамгаалах;	Төрөөс гарах зардал	Ургамал хамгааллын үндэсний байгууллага

“Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” хуулийн төслөөс харахад төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

1. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
2. Ургамал хамгааллын үндэсний байгууллага;
3. Эрдэм шинжилгээний байгууллага;
4. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын болон хилийн ургамал, хорио цээрийн байцаагч

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах төрийн байгууллагын чиг үүргийг одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжид байгааг хэвээр үлдээсэн бол төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзсэн.

Харин хуулийн төсөлд шинээр нэмсэн, эсхүл одоогийн хүчин төгөлдөр хуульд байгаа зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулсан, нэмэлт, өөрчлөлт орсон зүйл, заалт тус бүрээр тооцон зардлыг уг тайланд тусгалаа.

Хүснэгт 3-аас харахад шинээр, эсхүл нэмэлт, өөрчлөлтөөр орж ирж байгаа зүйл, заалтын ихэнхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ургамал хамгааллын үндэсний байгууллага, Эрдэм шинжилгээний байгууллага тус тус гүйцэтгэхээр байна.

3.2. Чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

“Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” хуулийн төсөлд төрийн байгууллагад хүлээлгэсэн чиг үүрэг нэг бүрээр стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож эдгээрт зарцуулах шаардлагатай цаг хугацааг тодорхойлсон ба ингэснээр улсын болон орон нутгийн төсөвт хүний нөөцтэй холбоотой гарч болох зардлыг урьдчилан тооцох боломж үүссэн.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалав.

Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацааг тогтохдоо стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тогтоосон загварт үндэслэх, хэрэв ийм загвар байхгүй бол өөрсдийн судалгаа, туршлагад тулгуурлан шинээр боловсруулахаар аргачлалд заасан. Одоогоор манай улс төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлог нөхцөл байдалд тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоогоогүй байна.

Тухайн хуулийн төсөлд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаанд шаардагдах журам, төлөвлөгөө, жагсаалт зэрэг захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, түүнчлэн гадаад орон, олон улсын холбогдох байгууллагатай ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлээр хамтран ажиллах, гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг үүрэгжүүлжээ.

Хүснэгт 3-ээс харахад нийт 5 журам, 2 төлөвлөгөөг тусгасан бөгөөд эдгээр нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт тул Захиргааны ерөнхий хуульд² заасны дагуу нийтийн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулахаар тохиолдлын тоог авсан болно.

Хүснэгт 4. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлээр Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хугацаа

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандартын үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /минут/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут/
Журам, жагсаалт, төлөвлөгөө боловсруулах	Захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах	1440	7	10080
	Захиргаан хэм хэмжээний актын төсөлд санал авах	60	7	420
	Нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах	180	21	3780
	Ирүүлсэн саналыг тусгах эсэх талаар тайлбар бэлтгэх	120	7	840
	Нөлөөллийн шинжилгээ хийх	960	7	6720
	Захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх материалын бүрдлийг хангах	180	7	1260
	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	60	7	420
	Захиргааны хэм хэмжээний актыг сурталчлан таниулах	90	7	630
гадаад орон, олон улсын холбогдох байгууллагатай ургамал хамгааллын талаар хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;	Урьдчилсан судалгааг гүйцэтгэх	1440	1	1440
	Гэрээ, хэлэлцээрт бэлтгэх сургалт зохион байгуулах	1440	1	1440
	Гэрээ, хэлэлцээрт оролцох талаар хэлэлцүүлэг,	240	4	960

² Захиргааны ерөнхий хууль 2015, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11259>

ярилцлага зохион байгуулах			
Гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах	3360	1	3360
Уг асуудлаар нийтийн хэлэлцүүлэг хийх	240	1	240
Гэрээ, хэлэлцээр хийх гадаад улс орон, олон улсын байгууллагын туршлага судлах	3360	1	3360
Гэрээ, хэлэлцээр байгуулах	380	1	380
Нийт			35330

Хүснэгт 4-өөс харахад Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлийн шинээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд бүгд нэг удаад хийгдэх ажил бөгөөд нийт 35330 минут буюу 588.8 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг жилийн 365 хоногоос амралтын 104, ээлжийн амралтын 22, бүх нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт 15 өдрийг хасвал нэг албан хаагч 224 ажлын өдөр буюу 1792 цаг ажилладаг гэж үзвэл: ажлын цаг $588.8/1792$ цаг = 0.3 хүний нөөцийн хэрэгцээ Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гарч байна.

Дээр дурдсан арга хэмжээний тухайд хүний нөөцийн нэмэлт зардал гарахгүй бөгөөд тухайн төрийн байгууллагын албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусан өдөр тутмын үүрэгт нь багтана. Харин, журам, жагсаалт, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор Хууль тогтоомжийн тухай хуульд³ заасан судалгаа, үнэлгээ, тооцоо хийх шаардлагатай ба энэ тохиолдолд гарах зардлыг олон улсын байгууллага, гадаад улсаас ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалал, тариалангийн салбарын хөгжлийг дэмжих хүрээнд хэрэгжиж байгаа салбарын төслүүдээс санхүүжүүлэх боломжтой. Тиймээс төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцов.

Хүснэгт 5. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлээр Ургамал хамгааллын үндэсний байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хугацаа

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандартын үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /минут/	Тохиолдолын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут/
Журам, жагсаалт, төлөвлөгөө боловсруулах	Захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах	1440	3	4320

³ Хууль тогтоомжийн тухай хууль 2015, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

	Захиргаан хэм хэмжээний актын төсөлд санал авах	60	3	180
	Нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах	180	9	540
	Ирүүлсэн саналыг тусгах эсэх талаар тайлбар бэлтгэх	120	3	360
	Нөлөөллийн шинжилгээ хийх	960	3	2880
	Захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх материалын бүрдлийг хангах	180	3	540
	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	60	3	180
	Захиргааны хэм хэмжээний актыг сурталчлан таниулах	90	3	270
8.2.5.хөнөөлт организмын гаралт, тархалтыг дотооддоо болон гадаад орон, бүс нутгуудад харилцан мэдээлэл солилцох;	Хөнөөлт организмын гаралт, тархалтын н урьдчилсан судалгааг гүйцэтгэх	10080	4	40320
	Мэдэгдэл бэлтгэх сургалт зохион байгуулах	1440	4	5760
	Мэдэгдэл бэлтгэх	1440	4	5760
	Мэдэгдэл орчуулах	3360	4	13440
	Мэдэгдэл хүргүүлэх	60	4	240
	Санал ирүүлсэн тохиолдолд саналын тайлбар хүргүүлэх	120	4	480
	Дараагийн бэлтгэл ажил	1440	4	5760
8.2.6. ургамлын эрүүл мэнд,	Мэдээллийн сан бүрдүүлэх	28800	1	28800

ургамал хамгаалалтай холбоотой олон улсыг хамарсан цахим системд нэгдэх, харилцан мэдээлэл солилцох;	Цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, ашиглах	7200	5	36000
	Мэдээлэл солилцох системд оролцогчдын үүргийг тодорхойлох	1440	1	1440
	Системд мэдээлэл оруулах, харилцан солилцох талаар оролцогчдыг сургах	1440	1	1440
Эрсдлийн шинжилгээ, тандан судалгаа хийх	Худалдан авах ажиллагаа зохион байгуулах	24000	1	24000
	Талбайн ажиглалт хийх	72000	8	576000
	Дээж цуглуулах	36000	8	288000
	Оношлогоо хийх, лабораторийн шинжилгээ хийх	7200	1	7200
	Тайлан боловсруулах	3360	1	3360
	Тайланг хэлэлцүүлэх	480	1	480
	Тайланг хүлээн авах	480	1	480
	Тэмцэх арга хэмжээ боловсруулах	7200	1	7200
				1055430

Үүнээс харахад Ургамал хамгааллын үндэсний байгууллагын ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлийн шинээр хэрэгжүүлэх чиг үүргүүд нийт 1055430 минут буюу 17590.5 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг жилийн 365 хоногоос амралтын 104, ээлжийн амралтын 22, бүх нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт 15 өдрийг хасвал нэг албан хаагч 224 ажлын өдөр буюу 1792 цаг ажилладаг гэж үзвэл: ажлын цаг $17590.5/1792$ цаг = 9.8 хүний нөөцийн хэрэгцээ Ургамал хамгааллын үндэсний байгууллагад гарч байна.

Одоогийн мэргэжлийн хяналтын байгууллагын ургамлын хорио цээрийн байцаагчид болон Гаалийн байгууллагын ургамлын хилийн хорио цээрийн байцаагчид хуулийн төсөлд шинээр бий болгож байгаа ургамал хамгааллын үндэсний байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Иймээс одоогийн ургамал, хорио цээрийн байцаагч нар нийт 36 хүнийг бодлогын яаманд тараан хуваарилах замаар цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулахгүйгээр хуулийн төсөлд заасан нэмэлт арга хэмжээнүүдийг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 6. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хугацаа

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандартын үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /минут/	Тохиолдолын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минут/
Эрсдлийн шинжилгээ, тандан судалгаа хийх	Худалдан авах ажиллагаа	24000	4	96000
	Талбайн ажиглалт хийх	72000	32	2304000
	Дээж цуглуулах	36000	32	1024000
	Оношлогоо хийх, лабораторийн шинжилгээ хийх	7200	4	28800
	Тайлан боловсруулах	3360	4	13440
	Тайланг хэлэлцүүлэх	480	4	1920
	Тайланг хүлээн авах	480	4	1920
	Тэмцэх арга хэмжээ боловсруулах	7200	4	28800
8.2.8. ургамал хамгааллын салбарын мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажилтныг сургах;	Сургалтын хөтөлбөр боловсруулах	3360	1	3360
	Сургалтын гарын авлага материал бэлтгэх	3360	1	3360
	Сургагч багш бэлтгэх	6720	1	6720
	Сургалт зохион байгуулах	1440	4	5760
	Сургалтын тайлан боловсруулах	480	4	1920
8.2.9.хөнөөлт организмын цахим мэдээллийн санг бий болгож, хэвийн үйл ажиллагааг хангах;	Мэдээллийн сан бүрдүүлэх	28800	1	28800
	Цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, ашиглах	7200	1	7200
	Мэдээлэл солилцох системд оролцогчдын	1440	1	1440

үүргийг тодорхойлох			
Системд мэдээлэл оруулах, харилцан солилцох талаар оролцогчдыг сургах	1440	1	1440
Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах	12480	1	12480
			3571360

Үүнээс харахад эрдэм шинжилгээний байгууллагын ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлийн шинээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд нийт 3571360 минут буюу 59522.6 ажлын цаг шаардагдахаар байна.

Нэг жилийн 365 хоногоос амралтын 104, ээлжийн амралтын 22, бүх нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт 15 өдрийг хасвал нэг албан хаагч 224 ажлын өдөр буюу 1792 цаг ажилладаг гэж үзвэл: ажлын цаг $59522.6/1792$ цаг = 33 хүний нөөцийн хэрэгцээ эрдэм шинжилгээний байгууллагад гарч байна.

Дээр дурдсан арга хэмжээний тухайд эрсдлийн шинжилгээ, тандан судалгааг гүйцэтгэхдээ Ургамал хамгааллын үндэсний байгууллагаас төлөөлөл татан оролцуулах боломжтой. Энэхүү судалгааны ажлын хүрээнд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог албан хаагчдаас авсан мэдээлэл болон ажлын байрны ажиглалтад түшиглэн стандарт үйл ажиллагааны хугацааг тогтоосон болно.

Нийт хүний нөөцийг тодорхойлох

Хүснэгт 7. Хүний нөөцийн нийт хэрэгцээ

Ажил үйлчилгээ	Хүний нөөцийн хэрэгцээ
Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	0.3
Ургамал хамгааллын үндэсний байгууллага	9.8
Эрдэм шинжилгээний байгууллага	33
Нийт хэрэгцээ	43.1

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах төрийн байгууллагын зардлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зарим зүйл, заалт дээр нэмж туссан болон өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан. Тэдгээр зүйл, заалтууд нь одоогийн хүчин төгөлдөр хуульд байгаа бол төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

Харин төрийн байгууллагад нэмэлт зардал шаардагдах чиг үүрэг, тэдгээрийн зүйл, заалтын ихэнхийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ургамал хамгааллын үндэсний байгууллага, Эрдэм шинжилгээний байгууллага тус тус гүйцэтгэхээр байна.

Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хамаарах зүйл заалтын тухайд хүний нөөцийн нэмэлт зардал гарахгүй бөгөөд тухайн төрийн байгууллагын албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусан өдөр тутмын үүрэгт орж явах боловч журам, жагсаалт, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор нэмэлт судалгаа хийх шаардлага гарвал түүнтэй холбогдох зардал гарч болзошгүй байна.

Харин Ургамал хамгааллын үндэсний байгууллагын ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын чиглэлийн шинээр хэрэгжүүлэх зүйл, заалтуудыг хэрэгжүүлэхэд 9.8 хүний нөөцийн хэрэгцээ гарч байгаа. Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг өөрчлөн шинэчлэх талаар Засгийн газрын тогтоолд⁴ одоогийн ургамал хорио цээрийн байцаагчийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бодлогын яаманд чиг үүрэг, орон тоо, цалингийн хамт шилжүүлэхээр заасан. Иймээс хуулийн төсөлд заасан ургамал хамгааллын үндэсний байгууллагын байгууллагад эдгээр албан хаагчид шилжин ажиллах эрх зүйн орчин бүрдсэн тул төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж үзэв.

Эрдэм шинжилгээний байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэхэд нийт 33 хүний нөөцийн хэрэгцээ гарахаар тооцсон. Гэхдээ эдгээр арга хэмжээ, тухайлбал, эрсдлийн шинжилгээ, тандан судалгаа, сургалт гэх мэт чиг үүргийн ихэнхийг одоогийн хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ба зарим нэг чиг үүргийг илүү тодорхой болгосон, иймээс нэмэлт зардал үүсэхгүй.

3.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бус зардал
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухай ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс,

⁴ Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр, Дугаар 417, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532027305321>

нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 1 албан хаагч нь ТЗ-7, Ургамал хамгааллын үндэсний байгууллагад 10 албан хаагч нь ТЗ-6 гэж тооцвол сарын цалингийн хэмжээг дараах байдлаар тооцно.

Хүснэгт 8. Цалингийн хэмжээ

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Албан хаагчийн тоо	Сарын дундаж цалин ⁵	Нийт цалин
1	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	ТЗ-7	1	835204	835204
2	Ургамал хамгааллын үндэсний байгууллага	ТЗ-6	10	772236	7722360
	Нийт дүн				8,557,567

Төрийн захиргааны байгууллагын нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/хоол, унааны нэмэгдэл, 3/ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/буцалтгүй тусламж, 6/шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байна. Төрийн албан хаагч бүрийн хувьд ажилласан жил, зэрэг дэв гэх зэргээс хамааран харилцан адилгүй байдаг тул нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15 хувиар нийтлэг зардлыг, 10 хувиар дагалдах зардлыг, 30 хувиар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцов.

Хүснэгт 9. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

Зардлын төрөл	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Дүн /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	772236		772236
Нийтлэг зардал	772236	15%	115835
Дагалдах зардал	772236	10%	77224
Нэмэгдэл, урамшууллын зардал	772236	30%	231671
Нийт			1 196 966

Материаллаг зардал

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох

⁵ Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ"

хэрэгтэй. Судалгаанд жишиг болгон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны төсвийн гүйцэтгэлээс⁶ харахад нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг доорхи байдлаар тооцлоо.

Хүснэгт 10. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Дүн /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	191 900
	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	174 900
	Шуудан холбоо	370 000
	Нийт	736 800
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	236 900
	Тавилга, эд хогшил	154 200
	Нийт	391 100

Дээр тооцсон бүх зардал нийтдээ нэг албан хаагчийн “ажлын байрны дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлэх юм.

Хүснэгт 11. Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

Материаллаг зардал	Зардлын дүн /төгрөг/
Урсгал зардал	736 800
Элэгдэл, хорогдлын зардал	391 100
Нийт	1 127 900

Үүнээс харахад төрийн захиргааны байгууллагын нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1127900 төгрөг байна.

Бусад зардал

Хуулийн төслөөс харахад Хүснэгт 3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Ургамал хамгааллын үндэсний байгууллагууд хуулийн төслийн 7.1.5, 8.4, 20.2, 22.4, 32.1, 34.9, 34.10, 40.4, 23.1, 34.10 дахь заалтуудад журам, төлөвлөгөө, жагсаалт⁷ батлахаар тус тус заасан байна.

Захиргааны ерөнхий хуулийн 61.1-д “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх ажиллагааг тухайн актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага зохион байгуулна.” гэж, 61.4-д “Захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээг энэ хуулийн 61.6-д заасан аргачлалын дагуу хийж, түүнд дараах нөхцөл байдлыг тусгаж, танилцуулга бэлтгэнэ.” гэж, мөн хуулийн 62.2-д “Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор

⁶ shilendans.gov.mn

⁷ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ (legalinfo.mn)

хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ.” гэж тус тус заасны дагуу Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Ургамал хамгааллын үндэсний байгууллагууд хуулийн төсөлд заасан журам, жагсаалт, төлөвлөгөөний төслийг боловсруулах, нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, нийтээр хэлэлцүүлэх, захиргааны хэм хэмжээний актад нөлөөллийн шинжилгээ хийх зэрэг арга хэмжээнд тодорхой зардлууд гарахаар байна.

Дээр дурдсан арга хэмжээний тухайд хүний нөөцийн нэмэлт зардал гарахгүй бөгөөд тухайн төрийн байгууллагын албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусан өдөр тутмын үүрэгт орж явах боловч журам, жагсаалт, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор судалгаа хийх нэмэлт зардал гарч болзошгүй байна. Гэхдээ эдгээр үйл ажиллагаатай холбогдсон зардлыг салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын болон гадаад орны төслүүдийн санхүүжилтээр хийх боломжтой юм

Хүснэгт 12. Бусад зардлын хэмжээ

Зардлын нэр буюу хуулийн заалт	Нэгж зардал, сая төгрөг	Давтамж	Зардлын хэмжээ 1 жил / сая төгрөг
Захиргааны хэм хэмжээний акт, журам, жагсаалт, төлөвлөгөө	10	13	130
Мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох	40	3	120
Эрсдлийн шинжилгээ, тандан судалгаа	100	4	400
Ургамал хамгааллын салбарын мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах	20	1	20
Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	10	1	10
Нийт			680

3.4. Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм.

Хүснэгт 13. Нийт зардлын хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	1 196 966	11	157 999 512
Материаллаг зардал	1 127 900	11	12 406 900
Бусад зардал	680 000 000	1	680 000 000
Нийт зардал			850 406 412

Дээрх хүснэгтээс харахад “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд”-д тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага нэг жилд дунджаар 850 406 412 төгрөгийн зардал үүсэхээр байна.

3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэнэ:

- 1.Мэдээллийн санг цахимаар байгуулах боломжтой эсэх;
- 2.Эрсдлийн шинжилгээ, тандан судалгааг багасгах боломж бий эсэх;
- 3.Сургалтын давтамжийг багасгах боломж бий эсэх;
- 4.Хэлэлцүүлгийн тоог багасгах боломж байгаа эсэх;

✓ **Мэдээллийн санг цахимаар байгуулах боломжтой эсэх:** Хөдөө аж ахуйг цахимжуулах стратегийн хүрээнд газар тариалангийн нэгдсэн мэдээллийн plant.mofa.gov.mn цахим санг ашиглалтад оруулсан. Уг мэдээллийн санд ургамал хамгааллын бэлдмэлийн хэрэглээ, зарцуулалт, түүний төрөл, борлуулагч, хүлээн авагчийн мэдээллийг цахимаар оруулаад байна. Дээрх ажлуудыг илүү боловсронгуй болгох шаардлага байгаа ингэснээрээ системийн ажилтны ачааллыг багасгах боломж байгаа нь харагдаж байна.

✓ **Эрсдлийн шинжилгээ, тандан судалгааг багасгах боломж бий эсэх:** Ургамал хамгаалал гэдэг нь ургамлыг өвчин, хортон, хог ургамлаас хамгаалах, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний ургацыг сайжруулж, хорогдлыг багасгах ач холбогдолтой ч нөгөө талаасаа аюултай химийн бодис учраас хэрэглээг нь зөв төлөвшүүлээгүй тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх асар их эрсдэлтэй. Тиймээс улс орнууд ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хорио цээр, эрүүл ахуйн хууль тогтоомж, тогтолцоогоо сайжруулах замаар ургамлын өвчин, хортонг нутаг дэвсгэртээ орж ирэх, нэвтрэх, тархахаас сэргийлэхэд ихээхэн анхаардаг. Уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөнөөлт организмын эрсдлийн шинжилгээ, тандан судалгааг гүйцэтгэдэг учраас уг арга хэмжээг багасгах нь эрсдэлтэй байна.

✓ **Сургалтын давтамжийг багасгах боломж бий эсэх:** Хуулийн төсөлд зааснаар эрдэм шинжилгээний байгууллага ургамал хамгааллын мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах чиг үүргийг заасан. Уг судалгаанд энэ чиглэлээр жилд 20 сая төгрөг тусгасан нь ойролцоогоор 2 удаагийн сургалтын зардал бөгөөд үүнээс илүү бага байх нь үр дүнгүй юм.

✓ **Хэлэлцүүлгийн тоог багасгах боломж байгаа эсэх:** Захиргааны ерөнхий хуулийн 62.2-д “Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Ургамал хамгааллын үндэсний байгууллагууд хуулийн төсөлд заасан журам, жагсаалт, төлөвлөгөөний төслийг боловсруулах, нийтийн хэлэлцүүлгийг оролцогч талын төлөөллийг оролцуулан зохион байгуулах шаардлагатай.

Уг судалгаанд энэхүү хэлэлцүүлгийг хамгийн багадаа 3 удаа хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. Уг хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулан давтамжийг багасгаж болох ч төлөөллийг маш сайн хангаж, оролцогчийн тоог нэмэх шаардлагатай.

ДӨРӨВ.САНАЛ, ДҮГНЭЛТ

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон хууль хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдэд нэмэлт үүрэг болгоогүй тул нэмэлт зардал гарахгүй гэж үзсэн. Харин хуулийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагуудад бий болсон шинэ болон өргөтгөсөн чиг үүргүүд байна. Иймээс тэдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зарим зүйл, заалт дээр нэмж туссан болон өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон гаргасан. Харин одоогийн хүчин төгөлдөр хуульд байгаа чиг үүргүүд хэвээр үлдсэн бол төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж дүгнэв.

Төрийн байгууллагад нэмэлт зардал шаардагдах чиг үүргийн дийлэнхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ургамал хамгааллын үндэсний байгууллага, салбарын эрдэм шинжилгээний байгууллага тус тус гүйцэтгэхээр байна.

Судалгаанаас харахад “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлд”-д тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад нэг жилд дунджаар 850 406 412 төгрөгийн зардал, 11 хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтай байна. Гэсэн хэдий ч хуулийн төсөлд заасан ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, холбогдох бусад эд зүйлд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн гэрчилгээ олгох чиг үүргийг Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар Гаалийн ерөнхий газрын Гаалийн хорио цээрийн газар⁸ Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын дагуу иргэн, хуулийн этгээдэд олгож байна. Иймээс энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг холбогдох олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ургамал хамгааллын үндэсний байгууллагад байхаар хуулийн төсөлд тусгасан, ингэхдээ энэ чиг үүргээ бусад байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой байхаар мөн зохицуулсан тул төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй.

Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг өөрчлөн шинэчлэх талаар гарсан Засгийн газрын тогтоолд⁹ одоогийн ургамал хорио цээрийн байцаагчийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бодлогын яаманд чиг үүрэг, орон тоо, цалингийн хамт шилжүүлэхээр заасан. Иймээс хуулийн төсөлд заасан ургамал хамгааллын үндэсний байгууллагын байгууллагад эдгээр албан хаагчид шилжин ажиллах эрх зүйн орчин бүрдсэн тул тус байгууллагын эрүүл мэнд, ургамал хамгааллын бусад чиг үүргийг төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж үзэв. Иймээс эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг шинэ зардал гэж үзэхгүй байх боломжтой юм

⁸ <https://www.customs.gov.mn>

⁹ Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр, Дугаар 417, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532027305321>

ХУУЛИЙН ТӨСӨЛД ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ ХИЙХЭД АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, МЭДЭЭЛЛИЙН САН

Хуулийн төсөлд зардлын тооцоолол хийхтэй холбогдох эрх зүйн акт

1. Хууль тогтоомжийн тухай хууль
2. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”
3. Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөл. Улаанбаатар хот. 2016 он.

Хүний нөөцийн зардал тооцоход ашигласан эрх зүйн акт

4. Нийгмийн даатгалын тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Барилга байгууламжийг элэгдэл, хорогдлын зардлыг Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслэлийн нийтлэг жишиг”
7. Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”
8. Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ”
9. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”

Ургамлын эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд шинээр тусгагдсан зардал үүсгэх зохицуулалтуудыг тодорхойлоход ашигласан эрх зүйн акт

10. Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”
11. Засгийн газрын 2008 оны 190 дүгээр тогтоолын хавсралт: Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам
12. Ургамал хамгааллын тухай хууль
13. Ургамлын эрүүл мэндийн тухай хуулийн төслийн танилцуулга
14. Ургамлын эрүүл мэндийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
15. Ургамлын эрүүл мэндийн тухай хуулийн төсөл
16. Ургамлын эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан
17. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2019 оны А/500/283 дугаар хамтарсан тушаалын хавсралт: Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам

18. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2001 оны А/80 дугаар тушаалын хавсралт: Бэлчээр тариалангийн хөнөөлт шавьж, мэрэгчамьтантай тэмцэх арга хэмжээнд мэргэжлийн хяналт тавих журам
19. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн А-105 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт: Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам,
20. ХХАА-н сайдын 2015 оны 06 сарын 26-ны өдрийн А-90 тоот тушаалын хавсралтаар баталсан “Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч амьтдын нэрсийн жагсаалт”,

Судалгаанд ашигласан мэдээллийн сангууд

21. Стандартын мэдээллийн нэгдсэн сан: <http://estandard.gov.mn>
22. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://www.legalinfo.mn/>
23. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn
24. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем. www.tender.gov.mn
25. Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл

**УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БОЛОН САНАЛ
ТУСГАСАН БАЙДАЛ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хуулийн төслийн хэлэлцүүлгийг Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, Монголын тариаланчдын холбоо зэрэг бусад мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн төлөөллийг оролцуулан 2 удаа зохион байгуулсан.

Мөн хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны цахим хуудас (www.mofa.gov.mn)- д санал авч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01/3018 дугаартай албан бичгээр нэр бүхий 14 газарт санал авахаар хүргүүлж, ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгасан.

Санал ирүүлсэн байгууллага	Өгсөн санал	Тусгасан байдал
Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, 2022.11.03, №06	<p>1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нэр, томъёоны 4.1.1, 4.1.3, 4.1.6, 4.1.8, 4.1.15-ийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах;</p> <p>2. Төслийн 8 дугаар зүйлийн 8.7-д реэкспорт гэдэг үгийг Монгол үгээр оновчтой оруулах;</p> <p>3. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т тусгагдсан "Лавлагаа" гэдэг үгийг хасах;</p>	<p>1. Саналыг бүрэн тусгаж, хуулийн нэр томъёоны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан.</p> <p>2. Саналыг тусгаж, хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.3-т Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, реэкспорт, дамжин өнгөрөх асуудлыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулна гэж оруулсан.</p> <p>3. Саналыг тусгаж хассан.</p>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	<p>Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлтэй танилцан, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын</p>	<p>1. Саналыг хүлээн авч, "Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааг дэмжих, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад</p>

	<p>нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино" гэснийг "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ургамлын хорио цээр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын хөнөөлт организмаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж нэмэлт оруулж өөрчлөх;</p> <p>2. Төслийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалтын "хөрс, хүнсний зориулалттай ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицид болон нитрат, нитритын үлдэгдлийг шинжлэх" гэснийг "зохицуулалттай эд материалд ургамлын хорио цээр, эрүүл ахуй, болон пестицид, нитрат, бохирдуулагчийн үлдэгдлийг шинжлэх" гэж нэмэлт оруулж өөрчлөх;</p> <p>3. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын "зохицуулалттай эд материалд ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, итгэмжлэгдсэн лабораторид ургамлын эрүүл ахуй, хорио цээр, пестицид болон нитратын үлдэгдлийг шинжлүүлэх, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд шинжилгээний дүнг үндэслэн дүгнэлт гаргах баталгаажуулах" гэснийг "зохицуулалттай эд материалд ургамлын эрүүл ахуй үзлэг хийж, итгэмжлэгдсэн лабораторид ургамлын эрүүл ахуй, хорио цээр, пестицид болон нитрат, бохирдуулагчийн</p>	<p>оршино." гэж өөрчлөн найруулсан.</p> <p>2. Саналыг тусган Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн "17.1.4.Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө батлах." гэсэн заалтыг нэмэхээр боловсруулсан.</p> <p>3. Саналыг тусган хуулийн төслийн 22.2.9-т зохицуулалттай эд, материалд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн үзлэг хийж шинжилгээний дүнг үндэслэн дүгнэлт гаргах баталгаажуулах гэж өөрчлөн найруулсан.</p>
--	--	---

	<p>үлдэгдлийг шинжлүүлэх, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд шинжилгээний дунг үндэслэн дүгнэлт гарган баталгаажуулах" нэмэлт оруулж өөрчлөх;</p>	
<p>"Мед Импекс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Оюундэлгэр,</p>	<p>Монголын Тариалан Эрхлэгчдийн Үндэсний Холбооны гишүүн байгууллагын нэрийн өмнөөс мөн Ургамал хамгааллын гол аргын нэг болсон пестицидийг хэрэглэсний дараах үлдэгдлийн шинжилгээний чиглэлээр ажиллаж буй Демо лабораторийн өмнөөс хуулийн төсөлд дараах саналуудыг хэлсэн:</p> <p>1. Ургамал хамгааллын хуулийн төслийг шинэчлэх ажил НҮБ-ын ХХААБ-ын төслийн хүрээнд бараг 3 жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд тэр үеэс эхлэн онлайн уулзалтуудад оролцож саналаа хэлж явсан нь өнөөдрийн хуулийн төслийн саналд тусгагдаж чадсан байна. Тухайн үед хэлсэн санал нь Ургамал хамгааллын үйл ажиллагаанд пестицидийн хэрэглээ нилээн зонхилох байр суурь эзэлж байдаг тул энэхүү хуулинд зохистой хэрэглээг дэмжсэн, пестицидийн үлдэгдлийг хянах зохицуулалт хийх талаархи зүйл заалтыг оруулах саналыг тавьсан.</p> <p>2. Хэлэлцүүлгийн үеэр тавигдсан илтгэлд олон орнууд, жишээлбэл Япон улс үүнтэй адилхан хуулийн хүрээнд бидний дэвшүүлсэн пестицидийн үлдэгдлийг хянах шалгах, зохицуулах асуудлуудыг тусгаж өгдөг гэж байсан нь бид бусад орнуудын адил хэрэгжүүлдэг арга хэмжээг хуулиндаа тусгаж өгсөн байна.</p> <p>3. Одоогоор хуулийн төсөлд Пестицидийн үлдэгдлийг хянах төлөвлөгөөг жил бүр хэрэгжүүлнэ гэсэн байдлаар тусгаад мөн үлдэгдлийн шинжилгээг Итгэмлэгдсэн Лавлагаа лаборатори гэж тусгасны "Лавлагаа" гэсэн үгийг өөрчлөх буюу хасах саналыг оруулсан. Одоогоор манайд ийм төрлийн шинжилгээг хийх хүчин төгөлдөр лавлагаа лаборатори байхгүй,</p>	<p>Уг саналыг тусган Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн "17.1.4.Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө батлах гэсэн утга бүхий заалтыг нэмэхээр тусгасан.</p>

	<p>харин итгэмжлэгдсэн лабораториуд байгаа учраас ингэж тусгайлан зааж өгөх шаардлагагүй гэсэн саналыг дэвшүүлсэн.</p> <p>4. Зарим оролцогчдын зүгээс хуулийн заалтад нарийн, мэргэжлийн асуудлуудыг оруулж өгөх шаардлагагүй, хасах саналыг гаргасантай санал нийлэхгүй, одоо байгаагаар нь үлдээх саналыг гаргасан. Учир нь энэ хууль өөрөө нарийн мэргэжлийн, асуудлуудыг зохицуулах зорилготой хууль учраас ерөнхийлөн хуулийн заалтуудыг оруулж өгөөд, дараа нь баахан журмаар зохицуулна гэсэн санаатайгаар үлдээчихээр хуулийн журмын хэрэгжилт сул байх магадлал маш өндөр байдаг, ерөнхийлөн бүх асуудлуудыг оруулчихаар заавал хийгдэх ажлууд нь хийгдэхгүй орхигдох магадлал өндөр гэдгийг хэлсэн.</p>	
--	---	--

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл
болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан
бусад хуулийн төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

1. Х.Болорчулуун – Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
 2. Ц.Болорчулуун – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Бодлого төлөвлөлтийн газрын дарга
 3. Д.Есөн-Эрдэнэ - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга
 4. Э.Цолмонжаргал – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн дарга
 5. Б.Уранчимэг – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Бодлого төлөвлөлтийн газрын Газар тариалангийн
асуудал хариуцсан мэргэжилтэн
-

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны tofa.gov.mn албан ёсны вэбсайтад "Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай" хуулийн төслийг 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс өнөөдрийг хүртэл байршуулж, нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлсэн.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

И-УР ТАНЫЛЦУУЛГА МЭДЭЭ МЭДЭВЭЛЭЛ ХҮҮЛЬ-ЭХЭЭМ ТӨСӨВ САНГААХ ҮЙЛДЭВЭРИЙН ХААГААР ХАМГААГАХ ХААГААР ҮЙЛЧЛЭГЭЭ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

И-УР ТАНЫЛЦАХ ҮЭС
E-Орхис АСУУГАХУЛГА
САНГААГАХ ҮЙЛЧЛЭГЭЭ
ХААГААР

Төсөлд санал авч байна.

№	Төсөлд санал авч байна.	Мөйл:	Сурвалж
5	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлд санал авч байна	2023-04-18	2023-05-18 Э-Файл үзэх
6	Согтууруулах үндэс худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмших худалдаа үйлчилгээний газрын ангилал, түүнд тавих шаардлагын төсөлд санал авч байна	2023-04-17	2023-05-17 Э-Файл үзэх
7	Согтууруулах үндэсний үйлдвэрийн төслийн баримт бичгийн	2023-04-17	2023-05-17 Э-Файл үзэх



НЭР БҮХИЙ 14 ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Дотоо газрын Их байр, Зөвлөлийн өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13311
Утас: 26 22 71 76; 26 22 71 77
Цахим хуудас: mofa.gov.mn
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2024.09.18 № 01/2018

талай _____ нм № _____ г

Санал авах тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 141 дэх заалтад туссан Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг ажлын хэсэг боловсруулаад байна.

Уг хуулийн төслийг тус яамны албан ёсны www.mofa.gov.mn цахим хуудасны "төсөл хэлэлцүүлэг" хэсгээс татан авч танилцан, саналва 2022 оны 10 дугаар сарын 14-ний дотор ирүүлнэ үү.

Холбоо барих: Ажлын хэсгийн нарийн бичиг, Бодлого, төлөөлөлтийн газрын газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Б Уранчимэг, утас 51-260709, 99049885, uranchimeg@mofa.gov.mn

Хүндэтгэсэн,


Х.БОЛОРЧУЛУУН

00001404



УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар: 06

Улаанбаатар хот
Утас 345212, 341054

Хуралд оролцогсад: Доктор, дэд профессор М. Бямбасүрэн /даргалав/, Доктор Б.Мөнхцэцэг, Доктор И.Отгонбаатар, Доктор Sc, профессор Н.Энхболд, Доктор, профессор Ч.Чулуунжав, Доктор, профессор М.Отгонсүрэн, Доктор, дэд профессор Б.Дондов, Доктор, дэд профессор Ц. Итгэл, Доктор, Доктор, дэд профессор Т. Дэжидмаа, Доктор Д. Мөнхцэцэг, Доктор Д.Цэвээндорж, Доктор О.Ариунаа, Доктор Т.Азаяа, Доктор Н.Оюунгэрэл нар оролцов.

Хурлын ирц: 100%

Хэлэлцсэн асуудал: Ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төслийн нэр, бүтэц, хуулийн нэр томъёо бусад холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэв.

Хуулийн төслийг Ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай хууль боловсруулах ажлын хэсгийн гишүүн Доктор Т.Дэжидмаа танилцуулав.

Тэмдэглэсэн нь:

1. Ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай хуулийн 4-р зүйлийн нэр томъёоны 4.1.1, 4.1.3, 4.1.6, 4.1.8, 4.1.15 -ийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах
2. 8-р зүйлийн 8.7-д ре-экспорт гэдэг үгийг Монгол үгээр оновчтой оруулах
3. 12-р зүйлийн 12.1.2-т тусгагдсан "Лавлагаа" гэдэг үгийг хасах

Шийдвэрлэсэн нь: Монгол улсад шинээр батлагдахаар хэлцэгдэж буй Ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найрууллагад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хууль боловсруулах ажлын хэсэгт хүлээлгэж өгөхөөр шийдвэрлэв.

Хуулийн төсөлд оруулах саналыг ажлын хэсэгт хүргүүлэхийг ЭНБДаргад үүрэг болгов.

Эрдмийн зөвлөлийн дарга:
Доктор(Sc.D), дэд профессор

Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга:
Доктор(Ph.D)

Протокол хөтөлсөн: Референт



М.Бямбасүрэн

Б.Мөнхцэцэг

С.Баярцэцэг



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
 ГАЗАР**

Партизаны гудамж, 1 дүгээр хороо,
 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14250
 Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77.
 Цахим шуудан: doc@nema.gov.mn,
 Цахим хуудас: www.nema.gov.mn

2022.10.13 № 1/2202
 танай 09.28 -ны № 01/3018 -Т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
 ҮЙЛДВЭРИЙН САЙД Х.БОЛОРЧУЛУУН
 ТАНАА

2022.09.28-ны өдрийн 01/3018 дугаар албан
 бичгээр ирүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал
 хамгааллын тухай хуулийн төсөлд тусгайлан өгөх
 саналгүй болно.

Хүндэтгэсэн

[Handwritten signature]
 ДАРГА,
 КОШУУЧ ГЕНЕРАЛ
[Handwritten signature]
 2022.09.28



[Handwritten signature]
 00003559



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
 ЕРӨНХИЙ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр,
 Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
 E-mail: info@inspection.gov.mn, http://www.inspection.gov.mn

2022. 10. 11 № 06-05/2253

танай _____-ны № _____-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
 ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ БОДЛОГО,
 ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
 Ц.БОЛОРЧУЛУУН ТАНАА

**Хуулийн төсөлд
 санал хүргүүлэх тухай**

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөлтэй танилцан, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах, худалдааг дэмжих, хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгалийн тэнцвэрт байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино" гэснийг "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дотогорт ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ургамлын хорио цээр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын хөнөөлт организмаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж нэмэлт оруулж өөрчлөх;

2. Уг хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалтын "хөрс, хүнсний зориулалттай ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицид болон нитрат, нитритын үлдэгдлийг шинжлэх" гэснийг "зохицуулалттай эд материалд ургамлын хорио цээр, эрүүл ахуй, болон пестицид, нитрат, бохирдуулагчийн үлдэгдлийг шинжлэх" гэж нэмэлт оруулж өөрчлөх;

3. Уг хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын "зохицуулалттай эд материалд ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, итгэмжлэгдсэн лабораторид ургамлын эрүүл ахуй, хорио цээр, пестицид болон нитратын үлдэгдлийг шинжлүүлэх, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд шинжилгээний дүнг үндэслэн дүгнэлт гаргах баталгаажуулах" гэснийг "зохицуулалттай эд материалд ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, итгэмжлэгдсэн лабораторид ургамлын эрүүл ахуй, хорио цээр, пестицид болон нитрат, бохирдуулагчийн үлдэгдлийг шинжлүүлэх, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд шинжилгээний дүнг үндэслэн дүгнэлт гаргах баталгаажуулах" гэж нэмэлт оруулж өөрчлөх;

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
 ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.АЛТАНТУЯА

1522 2770

Ургамалын эрүүл мэндийн үйлчилгээний газар
 [Handwritten signatures and initials]

